# АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛ



*Багшийн гарын авлага*

# АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛ

# (БАГШИЙН ГАРЫН АВЛАГА)

УЛААНБААТАР ХОТ

2011

АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛ

ЕБС-ИЙН БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

Боловсруулсан:

Ч.Алтангэрэл
Л.Алтанзаяа
У.Туяа

Зөвлөх:

Д.Дуламсүрэн

Хянан тохиолдуулсан:

Д.Цэнд-Аюуш

Хэвлэлд бэлтгэсэн:

Т.Мөнхтунгалаг

АГУУЛГА:

ӨМНӨХ ҮГ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СУРАГЧДАД АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ ХАНДЛАГЫГ ХЭРХЭН ТӨЛӨВШҮҮЛЭХ ВЭ?

- ЯАГААД АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛ ХЭРЭГЦЭЭТЭЙ ВЭ?
- АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫН АГУУЛГА
- АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫН АРГА ЗҮЙ
- АВЛИГЫН ЭСРЭГ СУРАЛЦАХУЙН ОРЧИН
- АГУУЛГЫН ИНТЕГРАЦИЙГ ХИЙХ БОЛОМЖ

ХОЁРДУГААР ХЭСЭГ: АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫН ЗАГВАР ХИЧЭЭЛ

- АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫН ЗАГВАР ХИЧЭЭЛ
  - СЭДЭВ 1: ШУДАРГА БА ШУДАРГА БУС ЗҮЙЛСИЙН ЯЛГАА
  - СЭДЭВ 2 : НӨХӨРЛӨЛ, ШУДАРГА ЁС ХОЁР
  - СЭДЭВ 3 : БЭЛЭГ ҮҮ, АВЛИГА УУ?
  - СЭДЭВ 4: НЭР ХУГАРАХААР ЯС ХУГАР
  - СЭДЭВ 5: УРТ ХАЛБАГА
  - СЭДЭВ 6: РОМЫН БҮГД НАЙРАМДАХ УЛСЫН ҮЕ ДЭХ АВЛИГА
  - СЭДЭВ 7: БҮГД НАЙРАМДАХ УЛС: УНАЛТ БА ЯЗГУУРТНУУДЫН ЁС ЖУРАМГҮЙ БАЙДАЛ
  - СЭДЭВ 8: МОНГОЛ ХУТАГТЫН ДУРТГАЛД АВЛИГЫН ТАЛААР БИЧСЭН НЬ
  - СЭДЭВ 9: ДЭЛХИЙН ХҮЙТЭН ДАЙНЫ ҮЕИЙН ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛС
  - СЭДЭВ 10: ХЭЗЭЭ “ҮГҮЙ” ГЭЖ ХЭЛЭХ ВЭ?
  - СЭДЭВ 11: ИРГЭНИЙ ЭРХЭМ ЧАНАРУУД
  - СЭДЭВ 12: АЖИЛД АВАХАД ЮУГ ГОЛ ШАЛГУУР БОЛГОДОГ ВЭ?
  - СЭДЭВ 13: МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭ
  - СЭДЭВ 14: АВЛИГЫГ ТҮЛХҮҮР ҮГСЭЭР ТОДОРХОЙЛОХ НЬ
  - СЭДЭВ 15: ТАСЫН ГОЁЛ БА ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ
  - СЭДЭВ 16: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ
  - СЭДЭВ 17: АВЛИГЫН ХОР ХОХИРОЛ
  - СЭДЭВ 18: АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР ЯМАР ЧИГ ҮҮРЭГТЭЙ ВЭ?
  - СЭДЭВ 19: АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ХЭМЖИХ НЬ
  - СЭДЭВ 20: ҮЗГИЙН ХҮЧ (ШУДАРГА ЁСНЫ ТУХАЙ ЗАХИДАЛ БИЧИХ)
  - СЭДЭВ 21: ХҮҮХДҮҮД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ ЧАДНА
  - СЭДЭВ 22: ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ХЭРХЭН БОЛОВСРУУЛАХ ВЭ?
  - СЭДЭВ 23: МОНГОЛ ХҮҮХДҮҮД ШУДАРГА УУ?

- ХИЧЭЭЛИЙН НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

ГУРАВДУГААР ХЭСЭГ: АВЛИГЫН ТАЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

БИД ЯАГААД АВЛИГЫН ТУХАЙ ЯРИХ ЁСТОЙ ВЭ?
АВЛИГА ГЭЖ ЮУ ВЭ?
БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АВЛИГА БАЙГАА ЮУ?
ХАВСРАЛТ
ХАВСРАЛТ 1: НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР
ХАВСРАЛТ 2: СУДАЛГААНЫ ӨГҮҮЛЛҮҮД
ЭХ СУРВАЛЖ

## ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| АТГ | Авлигатай тэмцэх газар |
| АТБХ | Агуулгын тогтолцооны бүтэцчилсэн хүрээ |
| БДБХ | Бага, дунд боловсролын тухай хууль |
| БДБС | Бага, дунд боловсролын стандарт |
| БНОУХ | Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн |
| БХ | Боловсролын тухай хууль |
| БСШУЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| ЕБ | Ерөнхий боловсрол |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ИНБ | Иргэний нийгмийн байгууллага |
| МБХАН | Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг |
| МННХ | Монголын нээлттэй нийгэм хүрээлэн |
| МУ | Монгол Улс |
| МҮЭХ | Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| СЕХ | Сонгуулийн ерөнхий хороо |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТБББ | Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого |
| ТНУ | Түүх, нийгмийн ухаан |
| ТНУБ | Түүх, нийгмийн ухааны боловсрол |
| ТНУБС | Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт |
| УБ | Улаанбаатар |
| УИХ | Улсын Их Хурал |
| УТБА | Улс төрийн боловсролын академи |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ХЗҮХ | Хууль зүйн үндэсний хүрээлэн |
| ХМХ | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл |
| ХЭҮК | Хүний эрхийн үндэсний комисс |
| ЭЗХАХБ | Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага |

# ӨМНӨХ ҮГ

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны тэргүүлэх нэг чиглэл нь олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах явдал мөн.

Энэхүү ажлын хүрээнд нийгмийн тодорхой зорилтод бүлгүүдэд хандсан соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэг бүрчилсэн болон нийтлэг байдлаар зохион байгуулан ажиллаж байна.

Улс орны ирээдүй хүүхэд багачууд, өсвөр үеийнхэнд шударга ёсны ойлголт, зарчим, үнэт зүйлсийн талаар мэдлэгийг олгож, цаашдын ажил, амьдралдаа баримтлах итгэл үнэмшил болгох, шударга бус зүйлд хууль ёсны хариу үйлдэл үзүүлэх чадварыг төлөвшүүлэх нь өнөөгийн зорилт, маргаашийн хөрөнгө оруулалт болох юм.

Энэ ариун үйлсэд ерөнхий боловсролын сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн хүлээх үүрэг, идэвхи оролцоо нэн чухал.

Нөгөөтэйгүүр манай ЕБС-ийн сургалтын агуулга, хөтөлбөрт авлигын ойлголт, хор хөнөөл, түүнтэй тэмцэх арга зам болон шударга ёсны тухай ойлголт, мэдлэг олгох тусгайлсан хичээл тусгагдаагүй, энэхүү сэдвээр сургалт, яриа хийх багшийн хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүйн зөвлөмж хангалтгүй байгааг харгалзан “Авлигын эсрэг боловсрол” багшид зориулсан гарын авлагыг бэлтгэн багш, нийгмийн ажилтан, сурган хүмүүжүүлэгч нарт хүргэж байна.

“Авлигын эсрэг боловсрол” сэдвээр е рөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан гарын авлага, сурах бичиг Монгол Улсад урьд нь хэвлэгдэж байгаагүй тул энэхүү анхны гарын авлагыг боловсруулсан ажлын багийн гишүүд, хамтран ажилласан АНУ-ын Азийн сангийн хамт олонд талархал илэрхийлье.

Энэхүү гарын авлагыг улам боловсронгуй болгох, мөн холбогдох санал, хүсэлт байвал Авлигатай тэмцэх газарт хаяглан ирүүлэхийг хүсье.

Хичээнгүйлэн боловсруулан энэхүү гарын авлага нь Багш таны мэдлэг, ур чадвараар баяжигдан Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах иргэдийг бэлтгэхэд тус нэмэр болно гэдэгт итгэл дүүрэн байна.

Шударга ёс хүн бүрийн үнэт зүйл байх болтугай...

Авлигатай тэмцэх газрын
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга,
Эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн

# ОРШИЛ

Бидний амьдран буй дэлхий дахинд нийгмийн өөрчлөлт шинэчлэлтүүд олон түвшинд, янз бүрийн хэлбэр агуулгаар хэрэгжиж байна. Өөрчлөгдөн буй дэлхий ертөнцөд хүмүүсийн амьдралын хэв маяг байнга өөрчлөгдөж буй бөгөөд түүнд хэрхэн дасан зохицох, зөв хариу үйлдэл үзүүлэх асуудал нэн чухлаар тавигдаж байна. Орчин үеийн нийгэм дэх улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох нь өнөөгийн иргэн бүрийн зайлшгүй эзэмшвэл зохих чадвар юм.

Эдгээр хариу үйлдлийн нэгэн болох “Авлигын эсрэг боловсрол” хэмээх боловсролын нэгэн шинэ ойлголтыг та бүхэнд энэхүү гарын авлагаар дамжуулан хүргэж байна. Учир нь энэхүү гарын авлага ЕБС-ийн багш та бүхний бүтээлч үйл ажиллагаа, санаачилгаар дамжин нийгэм дэх шударга ёсны үзэл санааг хүүхэд, өсвөр үе, залуучуудад хүргэх, улмаар тэднийг авлига болон бусад шударга бус зүйлийг үл тэвчих үнэт зүйлсийг удирдан залах, үр дүнд хүргэхэд нь туслах зорилго агуулж байна.

“Авлигын эсрэг боловсрол” гарын авлагын гол зорилго нь багш нар шударга ёсыг эрхэмлэх, авлигыг үл тэвчих үзэл санааг өөрсдийн хичээл сургалтын үйл явцад нэвтрүүлж, улмаар нийгэмд зүй ёсыг тогтооход өөрсдийн хувь нэмрээ оруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох, зөв, шударга иргэний үлгэр дуурайл үзүүлэхэд нь сурагчдад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Энэхүү зорилго нь бүхэлдээ түүх, нийгмийн ухааны боловсролын стандартыг хэрэгжүүлэх хүрээнд үйлчлэх бөгөөд багш, сургууль болон шударга ёсны төлөөх байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны үр дүнд амжилтад хүрнэ. Сургалтын гарын авлагыг боловсруулахдаа БСШУЯ-наас батлан гаргасан Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт, түүний зөвлөмж, агуулгын үлгэрчилсэн хүрээг баримтлан ажилласан болно. Мөн гарын авлагад сурагчдын сурах үйлийг дэмжсэн оролцооны буюу интерактив аргуудыг түлхүү тусгахыг эрмэлзсэн бөгөөд энэ нь суралцагчид бие даан бүтээлчээр ажиллах, тухайн орон нутаг, амьдралын орчин дахь асуудлуудыг шийдвэрлэх, оролцох, нийгмийн амьдралын хэм хэмжээ, дүрэм журамтай танилцан, нийгэмшин амьдрах чадварыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

Гарын авлагад оруулсан загвар хичээлүүдийн арга зүй нь ихэвчлэн багаар буюу хамтран ажиллах, асуудлыг судлан шинжлэх, тодорхой санал, шийдэл боловсруулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн бүтээлч дасгал, даалгавруудтай байхаар төлөвлөсөн болно.

Багш танд зориулсан энэхүү гарын авлага нь таны зааж буй хичээлийн агуулга, арга зүй, хичээлийн үзэл санаагаар дамжин манай улсын хөгжлийг тээн явагч–залуу иргэдэд авлигыг үл тэвчих үзэл санаа, зан үйлийг төлөвшүүлэх, амьдралынх нь хэвшил болон хүрэх болтугай.

# НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

# СУРАГЧДАД АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ ХАНДЛАГЫГ ХЭРХЭН ТӨЛӨВШҮҮЛЭХ ВЭ?

## 1.1 ЯАГААД АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛ ХЭРЭГЦЭЭТЭЙ ВЭ?

Яагаад заавал авлига, нийгмийн шударга ёсны талаар ерөнхий боловсролын хичээлүүдээр дамжуулан сурч мэдэх ёстой вэ? Мэдээлэл харилцааны технологи өндөр хөгжиж буй энэ үед бусад арга замаар энэ талын мэдлэг, мэдээллийг авч болохгүй гэж үү, тэртээ тэргүй хичээл багтахгүй байна гэж та бодож болох юм. Үүний хариултыг бидний амьдарч буй нийгмийн харилцаа, үйл явц өөрөө харуулж байна. Өдөр тутам хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгмийн шударга ёсыг зөрчиж, ёс суртахууны болон ажил үүргийн зөрчил, доголдол гарсан тухай мэдээ цацагдаж, давтагдаж байна. Тодорхой шалгуургүй эерэг, сөрөг мэдээллүүд нь хүүхэд багачуудад мөн л эерэг, сөрөг ойлголтыг өгч байна. Иймээс тэдэнд бага балчраас нь шударга ёсыг эрхэмлэх үнэт зүйлийг төлөвшүүлэх шаардлага гарч байна.

Монгол Улс бол ардчилсан орон хэмээн бид тодорхойлдог. Гэвч манай улсын иргэд нийгмийн харилцаанд оролцох, ялангуяа төрийн албаны үйлчилгээ хүртэхэд хүнд сурталтай тулгарч, энэ нь хүнийг үл ойшоох, ялгаварлан үзэх, асуудлыг хуулийн дагуу шийдэхгүй байх зэргээр илэрч байна. Мөн зарим асуудалтай холбоотой мэдээлэл ойлгомжгүй буюу хаалттай байна. Иргэдийн зүгээс тухайн асуудлаар ямар байр суурьтай байх, төрийн байгууллага, албан хаагчид ямар үүрэг хариуцлага хүлээж буй, нийгэмд шударга ёсыг хэрхэн тогтоох арга замын талаар тодорхой ойлголт, мэдээлэлгүй байсаар байна.

Ардчилсан төрийн гол шинж нь аливаа бодлого шийдвэр нь олон нийтийн амьдралаас урган гарсан, тэдний төлөө үйлчилдэг байх явдал. Ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлгүүдийн төлөөллүүдийг тухайн шийдвэр гаргах үйл явцад оролцуулснаар ил тод байх нөхцөл нь бүрддэг байна. Төрийн бодлогыг тодорхойлох гол арга зам болох хууль тогтоох явцад иргэд үзэл бодол, байр сууриа илэрхийлж өөрт олгогдсон эрхийн хүрээнд улс орны хөгжилд идэвхтэй оролцох нь ардчилсан орны иргэний хүлээх үүргийн илэрхийлэл болж байдаг. Иймээс бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо нь нэг талаас ардчилсан төрийн үйл ажиллагааны ил тод байдлын илэрхийлэл, нөгөө талаар иргэдийн идэвхтэй оролцоог төрөөс дэмжих, иргэний соёлыг төлөвшүүлэх гол хүчин зүйл болж байдаг.

Сүүлийн жилүүдэд ардчиллыг шинээр болон сэргээн тогтоож буй орнууд авлигатай тэмцэх, иргэний нийгмийг төлөвшүүлэх хүрээнд иргэний боловсролын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг хүчтэй тавьж байгаа нь санамсаргүй хэрэг биш юм. Ялангуяа, авлигатай тэмцэх байгууллагууд нь авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг дангаар хийхэд хөрөнгө болон хүн хүчний хувьд хүрэлцэхгүй тул бүх шатны сургуулиудын зүгээс үйл ажиллагаагаа нийгэмд шударга ёсыг тогтоох, авлигыг үл тэвчих үзэл санааг төлөвшүүлэхэд чиглүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэх болсон байна.

Монгол Улсын хувьд 1990-ээд оны дунд үеэс олон улсын болон дотоодын иргэний нийгмийн байгууллагууд ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт Иргэний боловсрол, Эрх зүйн боловсрол, Ардчиллын боловсрол, Хүний эрхийн боловсрол, Эдийн засгийн боловсрол зэрэг авлигын эсрэг боловсролд холбогдох олон төрлийн хичээлийг оруулах чиглэлээр бодлогын нөлөөлөл явуулж, техникийн туслалцаа үзүүлж ирсэн байна. Тухайлбал, МННХ-ээс иргэний боловсрол, эрх зүйн боловсролын хичээлийн агуулга, арга зүйг боловсруулан, багш нарыг сургаж бэлтгэх, сурах бичиг боловсруулж хэвлүүлэх зэрэг ажлыг өөрийн сүлжээний дэмжлэгтэй хэрэгжүүлсэн. Үүний зэрэгцээ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, АНУ-ын Азийн сан, Конрад Аденауер сан, АНУ-ын БНОУХ зэрэг олон улсын байгууллага, мөн Иргэний Боловсрол төв, Сонгогчдын боловсрол төв, УТБА зэрэг дотоодын төрийн бус байгууллагууд ЕБС-ийн багш нарыг сургах, сургалтын материал, гарын авлагаар хангахад дэмжлэг үзүүлж байсан нь энэ чиглэлд ажиллах туршлага, хамтын ажиллагааны үндэс нэгэнт бүрэлдсэн болохыг харуулж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд авлигатай үндсэн гурван аргаар тэмцэж байна. Энэ нь 1) авлигаас урьдчилан сэргийлэх, 2) авлигыг илрүүлэн шийтгэх, 3) олон нийтийн оролцоог дээшлүүлэх зэрэг юм. Авлигын эсрэг тэмцэх оролдлого амжилтад хүрэхгүй байгаа нь ихэнх тохиолдолд иргэдийг соён гэгээрүүлээгүйгээс болдог гэж судлаачид тэмдэглэсэн байна.

Улс орны шударга ёсны тогтолцооны нэн чухал дэмжлэг бол өөрийн эрхийг ухамсарласан, мэдээлэл бүхий иргэд юм. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь иргэд, олон нийтийг гэгээрүүлж, авлигыг үл тэвчих, шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлэхгүйгээр амжилттай хэрэгжих боломжгүй гэдгийг олон улсын практик харуулж байна. Учир нь иргэд болон хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд нь өдөр тутмын амьдралдаа авлигыг харж, хянаж илрүүлж, урьдчилан сэргийлэхэд оролцож байдаг.

Үүний нэгэн адил боловсролын байгууллага – сургуулиудын нэгэн зорилт бол авлига зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдээс үүдэн орон нутаг, өрх гэрт ямар хохирол учирч байгааг мэдүүлэх, иргэдийг нийгмийн шударга ёсны талаар ухааруулан сэнхрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал юм. Иргэд, ялангуяа хүүхэд, залуусыг авлигын эсрэг дархлаатай болгох үүднээс ерөнхий боловсролын хичээлийн агуулгад уг асуудлыг нэвтрүүлэх нь нэн чухал алхам болж байна.

Авлигын эсрэг боловсрол нь нийгэм дэх шударга бус зүйлийн эсрэг тэмцэгч, түүнээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл болсон сурах, сургах үйл явц юм. Авлигын эсрэг боловсролын хөтөлбөр нь хүүхэд, өсвөр үеийнхнээс эхлэн залуучууд, насанд хүрэгчдийн гэсэн залгамж шинж чанартай, албан ба албан бус, танхимын ба зайны зэрэг олон талт хэлбэрээр хэрэгжих боломжтой. Гэхдээ энэ боловсролын хүрээнд зөвхөн авлига, түүний хор уршгийн талаар авч үзэх нь оновчгүй болно. Хүүхэд, өсвөр үеийнхэн өөрийн эрх, үүргээ мэдэж, нийгмийн хамтын амьдралын дүрэм журам, шударга ёс, ёс суртахуун, хууль, эрх зүйн зарчмуудын талаар мэдлэг ойлголттой, зөв үзэл хандлагатай болох ёстой. Авлига нь түүнтэй адилтгаж болох гэмт үйлдлүүдийн адилаар хувь хүний ухамсар, сонголтоос үүдэн гарч буй нийгмийн үзэгдэл юм. Харин тухайн гэмт үйлдлийг хийх эсэх нь тухайн хүний ёс суртахууны чанар, үнэт зүйлсийн төлөвшил, хувийн ба нийтийн эрх ашгийг хэрхэн эрэмбэ дараалалд оруулж буйгаар хэмжигдэнэ. Иймд уг боловсролын хүрээнд суралцагчид нийгмийн харилцаанд оролцох бүртээ өөрийн эрх үүрэг, харилцааны хэм хэмжээ, түүнээс үүдэн гарах үр дагаврын талаар эргэцүүлэн бодож,

тухайн зүйл “зөв” эсвэл “буруу” болохыг ялган үйлдэхэд суралцах болно. Ингэснээр суралцагчид ямар тохиолдолд “Тийм” эсвэл “Үгүй” гэж хэлэх сонголтоо хийж чадна гэсэн үг юм. Иймээс суралцагчид одоогийнхоос илүү өргөн хүрээтэй, амьдралаас урган гарсан авлигын эсрэг боловсролыг эзэмших нь чухал. Гэхдээ хамгийн гол нь суралцагчид “Шударга ёс“ бол ямар нэгэн хийсвэр нэр томьёо биш, анги танхим, гэр орон, найз нөхөд, хамт олон зэрэгтэй нь холбогдох бодит амьдралын асуудал гэдгийг ойлгон ухаарах ёстой. Шударга ёс бол хэн бүхний үүргээ гүйцэтгэж байгаагаар илэрч байдаг бодит зүйл юм.

Авлигын эсрэг боловсрол нь боловсролын нэгэн салбар болохынхоо хувьд суралцагчдад дараах 3 цогц чадамжийг төлөвшүүлдэг байна.

Авлигын эсрэг боловсрол олгох үйл ажиллагаанд баримтлах сурган хүмүүжүүлэх зарчмыг дараах байдлаар дэвшүүлсэн байна. Үүнд

## 1.2 АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫН АГУУЛГА

Нийгмийн шударга ёсны ойлголт нь эрх зүй, улс төр судлал, эдийн засаг, түүх, сэтгүүл зүй зэрэг нийгмийн олон шинжлэх ухаан, судалгааны огтлолцол дээр тайлбарлагддаг. Иймд сайн засаглал, хууль дээдлэх ёс, хүний эрх болон хөгжил, орон нутгийн болоод төрийн албан хаагчдын эрх хэмжээ, нийгмийн тэгш байдал, ёс зүй, иргэний эрх ба үүрэг хариуцлага, иргэний оролцоо зэрэг олон талт асуудал төвлөрдөг. Авлигын эсрэг боловсролын үйл ажиллагаа нь өөр хоорондоо харилцан хамаарал бүхий дараах хоёр бүрэлдэхүүн хэсэгт хуваагдана.

Нэгдүгээрт: Онолын үзэл баримтлал: Энэ нь тухайн боловсролын мэдлэгийн тал бөгөөд сурагчид шударга ёс, авлига гэж юу болох, авлигын ямар хэлбэрүүд байдаг, тухайлан ямар үйлдэл, үйл ажиллагаа нь авлига болдог талаар танин мэдэхэд тустай.

Хоёрдугаарт: Нөлөөллийн үйл ажиллагаа нь авлигын эсрэг боловсролын практик тал бөгөөд нийгмийн харилцааны тодорхой бүлэг хэсгүүдэд зохих нөлөөлөл үзүүлэх замаар нийгмийн шударга ёсыг сурталчлах, түүнийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зэрэг болно. Нөлөөллийн үйл ажиллагаа нь олон улсын, олон нийтийн санаа бодлын, хууль тогтоох байгууллагын, шүүхийн болон сургалтын зэрэг олон талт хэлбэрээр хэрэгждэг.

Нийгмийн харилцааны явцад шударга болон шударга бус байдал, хууль ёсны болон хууль бус зүйлсийг шууд ялгаж дүгнэхэд бэрхшээлтэй байдаг. Үүний адилаар тухайн тохиолдол нь авлига мөн эсэх талаар үндэслэл, баримт нотолгоогүйгээр шууд таамаглан хэлэх нь зохисгүй юм. Иймд бодит үйл явдал, тохиолдол бүр үндэслэл, нотолгоотой хандаж, үнэн зөв болон шударга, шударга бусыг ялган тодорхойлох нь зүйтэй.

Авлигын эсрэг боловсрол нь дараах агуулга бүхий сэдвүүдэд төвлөрнө. Үүнд:

Шударга ёс, тэгш байдлын тухай
Сайн засаглалын тухай ойлголт
Иргэний болоод улс төрийн эрх, эрх чөлөө
Эдийн засгийн болоод нийгэм соёлын эрхүүд
Орон нутгийн болоод төрийн албан хаагчдын эрх хэмжээ, үүрэг, хариуцлага
Нийгэм-эдийн засгийн тэгш бус байдал, нийгмийн баялгийн хуваарилалт
Авлигын шалтгаан нөхцөл, түүний хэлбэрүүд
Авлигын эсрэг бодлого, стратеги болон хууль тогтоомж, хариуцлага
Авлигаас нийгэм, улс оронд үзүүлэх сөрөг үр дагавар

Авлига болон хөгжлийн хоорондын хамаарлын асуудал
Авлигатай тэмцэх санаачилгын нөлөөлөл, үйлчлэл ба үнэлгээ

Авлигын эсрэг боловсрол нь агуулгын хувьд дараах зорилтуудыг өөртөө агуулсан байвал зохистой. Үүнд:

Нийгмийн шударга ёсыг зөрчиж буй үзэгдэл, үйл явцад дүн шинжилгээ хийх
Авлига, түүний төрөл, хэлбэрүүдийн талаарх тодорхойлолтыг судлах
Авлигын нийгэмд учруулж буй хор хохирлыг тодорхойлох, судлах
Авлигатай тэмцэж буй олон улсын чиг хандлага, туршлагыг түгээн дэлгэрүүлэх
Авлигатай тэмцэх үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодорхойлох
Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд төр, байгууллага, иргэд олон нийтийн хамтын ажиллагаа, түншлэлийг өрнүүлэх

Авлигын талаар ерөнхий боловсролын сургуульд хичээл заахад зарим бэрхшээл, хүндрэл тохиолддог. Боловсролын салбарт авлигын эсрэг боловсролыг дэмжсэн эрх зүйн, хүний эрхийн, ардчиллын зэрэг олон тооны үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүд төрийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагуудын санаачилгаар хэрэгжиж байна. Гэвч эдгээр санаачилга нь нэгдсэн бодлого уялдаа холбоо, тууштай дэмжлэг дутагдсаны улмаас хүрсэн үр дүнгээ хадгалах, тогтолцоо болон хэвшиж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, тэдгээр санаачилгын үр дүн, ололт амжилтыг нэгтгэн, уялдаа холбоог нь хангаж, сургалтад нэвтрүүлж, үр дүнг тооцох тогтолцоо сайтар бүрэлдэж чадаагүйн улмаас иргэний боловсролын талаарх санал санаачилгууд “төслийн загвар” төдий хэлбэрээр үргэлжилсээр байна.

Ялангуяа “Иргэний боловсрол” хичээлийн сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээ, сурах бичиг, мэргэжлийн заавар зөвлөмж өнөөг хүртэл боловсруулагдаагүй тул багш нарын хувьд ямар агуулга, арга зүйг сонгон хичээл сургалтыг зохион байгуулах нь тодорхойгүй байх бэрхшээл байна. Үүнээс гадна багш нарт сургалтын хэрэглэгдэхүүн хомс, тэдний хувьд авлига, нийгмийн шударга ёсны талаар сургалт, мэдээлэл авч байгаагүй, энэ чиглэлээр тэдний мэргэжлийг дээшлүүлэх, дахин бэлтгэх тогтолцоо алга байна.

Мөн авлигыг зөвхөн мэдээлэх, практик амьдралтай нягт холбоогүй байдлаар авч үзэж байна. Нөгөө талаас авлигын асуудал нь тодорхой тохиолдлуудад байнга хөндөгдөх мөртлөө тэдгээрийн цаана нуугдмал, далд хандлагатай байдгийг тэр бүр анхааран үзэхгүй байна. Иймд нийгмийн ухааны багш нарыг чадваржуулах, тэдэнд ардчилал, иргэний нийгмийн тухай мэдлэг, түүнийг сурагчдад заах ур чадварыг хөгжүүлэх, багш нарын мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх шаардлага байна. Энэхүү шаардлагыг хангахын тулд нийгмийн бүхий л байгууллага, бүрэлдэхүүн хэсгүүд өөр өөрийн үйл ажиллагаа, санаа зорилгоороо нэгдэн ажиллах нь чухал юм.

## АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫН АРГА ЗҮЙ

Ерөнхий боловсролын түвшинд уламжлал болгон зааж буй түүх, нийгмийн ухаан, эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд авилгын эсрэг боловсролын холбогдох агуулга, арга зүй, үнэлгээг боловсруулан сургалтад нэвтрүүлэх, улмаар өөрийн хэрэгцээ, ашиг сонирхлоо

илэрхийлэх, нийгмийн шударга ёсыг хамгаалах чадвартай иргэнийг бэлтгэх нь үүнд хүрэх гол арга зам байх болно. Энэ хандлага нь өнөөгийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд томоохон өөрчлөлт оруулахгүйгээр шинэ агуулга, арга зүйг нэгтгэн интеграцичлах замаар авлигыг үл тэвчих үзэл санаа, ойголтыг бий болгох явдал юм. Авлигын эсрэг боловсролыг хичээлийн агуулгад нэвтрүүлэхийн хамт хичээлийн бус цагаар буюу сургалтын бусад үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломж их байна.

Авлигын эсрэг боловсрол олгох нь бусад сургалтын адилаар багш ба суралцагчийн хоорондын идэвхтэй харилцаанд суурилсан сургалтын цогц үйл явц мөн. Энэхүү сургалтын үйл явцад буюу тэдгээрийн хоорондын харилцаа, туршлагаар гол үр дүн болох мэдлэг хандлага бүтээгддэг. Суралцагчид нь тэдэнд өгч буй мэдээллийг хүлээн авч, бичиж байдаг хоосон хуурцаг бус өөрийн сэтгэхүйн үйл ажиллагаанд нийцүүлэн аливаа, мэдээлэл туршлагыг бүтэцжүүлэн боловсруулж байдаг идэвхтэй оролцогчид юм. Ер нь аливаа боловсролын зорилго нь суралцагчдад тухайн шаардлагатай мэдлэгийг дамжуулан өгөх бус харин тэдгээрийг өөрийн амьдралын үйл ажиллагаанд тохируулан хэрэглэх, үнэлэх, ухааран ойлгоход чиглэдэг. Авлигын эсрэг боловсролын нэгэн гол онцлог бол суралцагчид өөрсдийн бодит байдалд үндэслэн нийгмийн шударга ёсны талаар өөрийн гэсэн үзэл бодолтой, итгэл үнэмшилтэй, холбогдох мэдээллийг боловсруулах, бие даах чадвартай болгох зорилго тавьдаг. Энэ нь суралцагчид ямар үзэл санаа, байр сууриуд байгааг шүүмжлэлт байр сууринаас авч үзэх боломжийг олгоно гэсэн үг юм.

Авлигын эсрэг боловсролын үр дүн нь бидний өдөр тутмын амьдралаар хэрэглэгдэж, батлагдаж мөн цаашид хөгжин гүнзгийрч байдаг хэрэглээний шинжтэй мэдлэг, үйл ажиллагаа билээ. Ийнхүү өөрчлөмтгий, динамик шинжтэй байх тул суралцагч төвтэй, оролцооны арга зүйд тулгуурлавал илүү оновчтой гэж үздэг. Мөн онол ба практикийн хэрэглээг хослуулж, сурган хүмүүжүүлэх ухааны болон технологийн дэвшлүүдэд аль болох нээлттэй байх хэрэгтэй.

Сүүлийн үеийн судалгаагаар оролцоонд тулгуурласан сургалтын онцлогийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Мэдлэг нь нээх-дахин нээх, бүтээх-дахин бүтээх, тухайн нөхцөл байдлаас хамаарал бүхий динамик шинжтэй.
- “Дээрээс доошоо” гэсэн чиглэл нь “харилцан идэвхтэй” гэсэн зарчимд тулгуурлана.
- Мэдлэгийн эрэл хайгуулд суралцагчид идэвхтэй оролцогчид байдаг.
- Багш нь мэдлэгийг дамжуулагч биш мэдлэгийг бүтээх үйл явцын идэвхжүүлэгчийн үүрэгтэй байна.
- Сурах хэв маяг нь цээжлэн тогтоох бус харин хэлэлцэх, анализ хийх зарчимд үндэслэнэ.
- Судалгааны объект нь хүний амьдрал, үйл байдал учраас бүтээгдэж буй мэдлэг нь харьцангуй шинжтэй.
- Сурахуйн үр дүнд бүтээгдэх мэдлэг нь баримт, мэдээллийн цогц бус харин анализ, синтез зэргийг агуулсан дескриптив мэдлэг байна.

Авлига, нийгмийн шударга ёсны тухай мэдлэг эрдэмтдийн судалгаа шинжилгээгээр бүтээгдэх боловч үүнээс илүүтэйгээр хүмүүсийн өөрсдийн ажиглалт, тайлбар, хандлагаар бүтээгддэг.

Хамгийн зүй ёсны “шударга” нийгмийг байгуулах бэлэн жор байдаггүйн адилаар шударга ёсны тухай заах хамгийн шилдэг арга гэж байх бололцоогүй. Гэхдээ авлигын эсрэг, шударга ёсны боловсролын арга зүй нь тухайн асуудалд дүн шинжилгээ хийх, судлан тодорхойлох, шийдвэр гаргахад чиглэсэн оролцооны аргад тулгуурлан явагдах нь зүйтэй хэмээн үздэг байна. Тухайлбал, оролцооны арга зүйд тулгуурласан дараах  арга хэлбэр авлигын эсрэг сургалтад түгээмэл хэрэглэгддэг. Үүнд:

Туршлагын – Суралцагчид шударга ёс, хүний эрхийн зөрчил, гомдолтой холбоо бүхий нөхцөл байдлыг тогтоож, тэдгээрт анализ хийж, ярилцах. Суралцагчийн хувьд нийгмийн шударга ёсны тухай үйл явдал, жишээ баримт нь ямар нөхцөл байдалд болж буй талаар тодорхой ойлголттой болно.

Асуудал шийдвэрлэх – Суралцагчид нь өмнөө тулгарсан аливаа асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрхэх тухай хэлэлцэн шийдвэрлэх, хамтран ажиллах зэргээр тухайн ойлголт мэдлэг бүтээх. Энэ үйл явц нь суралцагчдыг үйл явдлын гүнд татан оруулж, тэдгээрийг шийдвэрлэх, зохицуулахын тулд сэтгэн бодох, төлөвлөх хэрэгжүүлэх сэдэлд хүргэдэг. Ингэснээр өөрт хамааралтай болохыг ойлгож, сэтгэхүйдээ тодорхой дүр төсөөлөл буулгаснаар асуудлыг шийдвэрлэх гарц, замыг эрж хайх, улмаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг байна.

Тоглоомын – Сурагчдад төрөл бүрийн тоглоомоор дамжуулан үнэт зүйлсийг эзэмшиж байдаг.

Оролцооны – Сургалтын энэ арга нь оролцогчид өөрсдийн хамтын ажиллагааны тусламжтайгаар сэдэв сонгох, үзэл баримтлал, байр сууриа тодорхойлох, төлөвлөх, үйлдэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм. Оролцогч бүр өөрийн туршлага, мэдлэгээ бусдад хүргэх, дэлгэрүүлэхийн зэрэгцээ тэднээс суралцаж байдаг. Ингэснээр сургалтын үр дүнд хүмүүсийн хооронд мэдлэг чадвар ба суралцах үйлийн солилцоо өрнөж, мэдлэг улам бүр өргөжиж, гүнзгийрч, хөгжиж байдаг. Суралцагчид өөрт байгаа мэдлэг чадвараа мэдлэгийн хүчин төгөлдөр бусад эх сурвалжуудтай харьцуулж, нэгтгэн дүгнэх нь энэ хандлагын өвөрмөц онцлог юм.

Оролцооны арга нь хүн бүр өөрийн гэсэн тодорхой түвшин бүхий суралцах чадвартай болохыг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Оролцоонд тулгуурласан сургалт нь суралцагчид, сургагч багш болон сургалтын материалуудын хоорондын идэвхтэй харилцаанд тулгуурласан 3 талт үйл явц юм.

Багш  Суралцагч

Сургалтын
хэрэглэгдэхүүн

Энэхүү бүдүүвчээс харахад сургалтын үйл явц нь суралцагч болон багшид хоёуланд нь нөлөөлдөг болох нь харагдаж байна. Багшийн хувьд суралцагчдын байнга өсөн нэмэгдэж буй мэдлэгийн хэрэгцээнд хариулахын тулд идэвхтэй сургалтын стратеги баримтлах шаардлагатай байдаг бол суралцагчдын хувьд багшийн шинэчлэгч байр сууриас хамааран олон талт сурах арга барилуудаа хөгжүүлж байдаг.

Суралцагч төвт арга зүйн үндсэн шинж нь[1]:

Суралцагчийн идэвхтэй оролцоо
Багшийн сурч боловсрох арга зүйн зөвлөгч, туслагч байх үүрэг
Бүлгийн ажиллагаа
Эрэл хайгуул хийх боломж
Сургалтын амьдралын арга ухаанд баримжаалсан байдал
Суралцагчдын хэрэгцээнд тулгуурласан хөтөлбөр
Шалгалт, хяналтын үйл явцад ач холбогдол өгдөггүй байдал
Бие даан суралцах, эрэл хайгуул хийхэд түлхэц, урам өгөх байдал зэргээр илэрч байдаг.

Нийгмийн шударга ёс, авлигыг үл тэвчих үнэлэмжийг сурагчдад төлөвшүүлэхэд багшийн мэргэжлийн мэдлэг, хамгийн гол нь заах арга зүйн ур чадвар голлох үүрэг гүйцэтгэнэ. Хичээлийн зорилгыг хангах, чанаржуулахын тулд сурагчдын сурах үйлийг дэмжсэн идэвхтэй оролцооны аргуудыг бид зөвхөн анги танхимд хэрэгжүүлэх идэвхтэй үйл ажиллагаагаар хязгаарлаж болохгүй юм. Тухайлбал, зөвхөн анги танхимд төвлөрөх бус харин өөрийн сургууль, хороо, дүүрэг зэрэг нийгмийн тодорхой орчин дахь асуудлыг судлан танилцах, оролцон хэрэгжүүлэх боломжтой байхуйцаар зохион байгуулах арга хэлбэрүүдийг эрэлхийлэх хэрэгтэй. Үүний тулд тухайн орон нутаг дахь үйлдвэрлэл, бизнесийн байгууллагууд, сум дүүрэг, баг хороодын тамгын газар, иргэдийн хурал, бусад боловсрол соёлын байгууллагууд, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах, тэдгээрийг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах нь зүйтэй.

Засгийн газар, парламентын ордон нь сургуулийн сурагчид, багш, оюутнуудаар дүүрэн байдаг бусад улс орнуудын адилаар манай төрийн засгийн байгууллагууд, тэдгээрийн шийдвэр гаргах үйл явц нь сурагч, багш нарын хувьд нээлттэй байх, оролцох, ажиглах боломжийг олгох нь уг зорилтыг хангахад туслах болно. Мөн тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаатай танилцах, хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг хэрхэн боловсруулагдаж иргэдэд хүрч байгааг танилцуулах нь мэргэжлийн чиг баримжаа авах, сонголт хийх болон бусдыг хүндэтгэх соёлд суралцуулна.

Сургалтын явцад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээллийн агуулгыг задлан шинжлэх, судлах, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой ажиллах байдлаар зохион байгуулж болох юм. Энэ бүхэн нь суралцагчдын хувьд бие хүн төлөвших, нийгэмшин амьдрах, нийгмийн амьдралыг зохицуулах хэм хэмжээ, дүрэм журамтай танилцан, түүнийг мөрдөх, хэрэгжүүлэх, түүнд зохицон амьдрах чадварыг бий болгох, хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Хэвлэл мэдээлийн байгууллагууд нь хэвлэн нийтлэх үүргээ сайтар хэрэгжүүлэх явдал нь уг сургалтыг үр дүнтэй болгоход хувь нэмрээ оруулна. Үүнд:

---

[1] George J Andreopoulos, Richard Pierre Claude ., (1997) Human Rights Education for the Twenty First Century University of Pennsylvania Press, ð. 181

- тухайн байгууллагуудын зохион байгуулалт, эрхлэх ажил, үүрэг, санхүү
- олон нийтэд шууд хүргэдэг ажил үйлчилгээтэй холбоотой мэдээлэл
- тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан олон нийтийн зүгээс хүсэлт, гомдол гаргах механизм, түүнчлэн тухайн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, түүнд өгсөн хариултын товчоон
- тухайн байгууллагын мэдээлэл хадгалах тогтолцоо, хадгалагдаж буй мэдээллийн төрөл, хэлбэр, хэвлэн нийтэлдэг мэдээллийн төрөл, мэдээлэл олж авах хүсэлт тавихдаа мөрдөх зарчим зэргийг багтаасан хэрэглэхэд хялбар гарын авлага
- ахлах болон удирдах албан тушаалтнуудын эрх мэдэл, үүргийн тодорхойлолт, шийдвэр гаргахдаа мөрддөг дэг жаяг
- тухайн байгууллага үйл ажиллагаагаа гүйцэтгэхтэй холбоотой дүрэм бодлого, журам зааварчилгаа, гарын авлага
- тухайн байгууллагын бодлого тодорхойлох, эрхээ хэрэгжүүлэх ажиллагаанд олон нийтийн зүгээс нөлөөлөх буюу төлөөллөө бий болгох аливаа арга хэрэгсэл зэрэг нь нэн чухал агуулга юм.

Энэ нь нэг талаас олон нийтийн мэдэх эрхийг хэрэгжүүлж буй хэрэг болно. Ард иргэд ардчилсан сонгуулиар төрөө бүрдүүлдэг тул төр, засаг амласнаа аль хэр биелүүлж байна, бидний татвараар бүрдэж буй төсвөө аль хэр үр ашигтай зарцуулж байна зэргээр гэдэгт хяналт тавих хууль ёсны эрх нь олон нийтийн мэдэх эрхээр тодорхойлогдоно. Нөгөө талаас төрийн аливаа байгууллага мэдээллээ нээлттэй байлгах үүрэгтэй бөгөөд иргэд төрийн байгууллагаас өөрийн хүссэн мэдээлэл ба уг мэдээллийн эх сурвалжийн талаар мэдэх эрхтэйг уг сургалтын хүрээнд таниулах нь чухал болно.

## 1.4 АВЛИГЫН ЭСРЭГ СУРАЛЦАХУЙН ОРЧИН

Хүний амьдралын үнэт чанарын нэг бол нийтээр хамтран амьдрах явдал билээ. Хамтын амьдрал нь улс эх орон, үндэстэн угсаатан, аймаг хот, ажлын газар, хамт олон, сургууль анги танхим, хөршүүд гэр бүл зэрэг маш олон түвшинд хуваагдаж ялгагдах ба ижилсдэг. Эдгээр нийтлэгт түүнд хамрагдагч хүн бүрийн даган баримтлах эрх хэмжээ, эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлага байдаг. Тэгвэл анги хамт олноороо, бүлэг нийтлэгээрээ авлигын эсрэг, нийгмийн шударга ёсны талаар хамтран суралцаж болно гэдэг нь ихээхэн үнэ цэнэтэй санаа юм.

Хэдийгээр олон хот суурин, сургууль байгууллагууд байдаг боловч тэдгээрт хамаарах гишүүн бүр нь аюулгүй тайван байж, бусадтайгаа харилцаж, суралцаж, ойлголцож байх үндсэн хэрэгцээ шаардлага байдаг. Тухайлбал, сургуулиуд боловсролын стандартыг биелүүлэх, хүүхдийг зөв төлөвшүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах зорилгоор ажилладаг бол хяналтын байгууллагууд нь цэвэр, аюулгүй орчин бүрдүүлэх, эрүүл хүнсээр хангах, эмнэлгийн байгууллагууд эрүүл мэндийн үйлчилгээ, тусламж үзүүлэх гээд олон талын санаачилга, үйл ажиллагаа байнга өрнөж байдаг. Өөрөөр хэлбэл, гэр бүлд, сургуульд, хотод болон улс оронд бүхэлд нь хүний эрхийн түгээмэл байх, нийгмийн шударга ёсыг эрэлхийлэх зарчим үйлчилдэг. Тиймээс эдгээр зарчмыг хэрэгжүүлэхийн тулд бидэнд адил зорилго, үйл ажиллагаа, мөн үүрэг хариуцлага байх ёстой.

Хэрхэн авлигыг үл тэвчигч, нийгмийн шударга ёсыг дэмжигч бүлэг, хамт олныг бүрдүүлэх вэ? Энэ талаар АНУ-ын Миннеасотагийн их сургуулийн Хүний эрхийн төвийн захирал Кристи Рудельс Палмерийн боловсруулсан “Хүний эрхэд суралцахуйн тойрог”-ийг танилцуулж байна.

Бүдүүвч: Хүний эрхийн суралцахуйн тойрог

Хүний эрхийн суралцахуйн тойрог нь тухайн нийгэмлэгийн гишүүн бүр даган мөрдөж, баримталж, бусдад түгээн дэлгэрүүлж, дэмжин дэлгэрүүлж байх 8 үндсэн зарчмуудаас тогтдог. Эдгээр зарчмууд нь хүний эрхийг тухайн бичил орчинд хэрэгжүүлэхийн тулд оролцогчдын үр дүнтэй манлайлал, санаачилга, үүрэг хариуцлагыг улам бүр тэтгэх зорилготой. Мөн уг тойрог нь хамт олны ба хувь хүний гэсэн 2 түвшинд хэрэглэгддэг.

Мэдэх: Хувь хүн тэдгээрийн нийтлэгүүд өөрсдийн эрх, эрх чөлөө, үүрэг хариуцлагыг мэдэх ёстой. Тэрхүү мэдлэг нь өөрийгөө улам бүр гүнзгийрүүлж, хөгжүүлдэг байх нь суралцахуйн гол үндэс байна.

Үнэлэх: Хувь хүмүүс, хамт олон, хүний нийтлэг эрхийн үнэт зүйлс, шударга ёсны тухай үзэл санааг ухамсарлан ойлгосон байх ёстой. Хэрвээ бид бусдынхаа эрхэм зэрэг, чанарыг хүндэтгэн харилцдаг бол бүгд аюулгүй, тайван эвсэн амьдарч чадна.

Холбох: Хүн өөрийн оюун ухаан, сэтгэл зүрх, итгэл үнэмшлээ бусадтай нягт холбосноор тэдний дотоод эрч хүч, бололцоо улам бүр өргөжин тэлэх болно.

Анагаах: Аливаа нийтлэг бүрт өөрийн алдаа дутагдал, гэм байдаг. Эдгээрийг засч залруулахын тулд хувь хүн, тэдгээрийг эмчлэн анагаах арга замуудад суралцаж, засч залруулах нь зүйтэй.

Үйлдэх: Хүний эрхийг хангах, хамгаалах, хэрэгжүүлэх үр дүнтэй арга бол ганцаарчлан болон хамт олноороо үйлдэх явдал мөн. Үйлдэхүйн зэрэгцээ бид бусадтай хамтран ажиллаж, тэднээс суралцаж, урам хүндлэл хүлээж байдаг.

Тусгах: Бидэнд алдаа дутагдлаас ч илүү сайн талууд байдаг. Тэдгээр нь бидэнд сайны, зөвийн үлгэр жишээ болж байдаг. Тиймээс тэдгээр сайн талуудыг өөртөө шингээж, улмаар өөрийн хүч чармайлт, оролцоог сайн үйлсийн аянд хувь болгон оруулах хэрэгтэй.

Урам хайрлах: Хүний эрхийн төлөө, шударга ёсны төлөө, авлигын эсрэг ажиллах нь ихээхэн хүч чармайлт, зориг тэвчээр шаардсан ажил мөн. Тиймээс бусдын, өөрийн оршин буй орчны төлөө анхаарал тавин ажиллаж буй эдгээр хүмүүстээ нийтлэгийн, хамт олны зүгээс урам дэм хайрлах шаардлагатай байдаг. Зөвхөн энэ урмаар тэдгээр хүмүүсийн эрч хүч сэргэж, илүү ихийг хийж бүтээх эрмэлзэл өндөр болдог.

## 1.5 АГУУЛГЫН ИНТЕГРАЦИЙГ ХИЙХ БОЛОМЖ

Авлигын эсрэг, шударга ёсны боловсрол нь зөвхөн нэг хичээлийн агуулгаар хэрэгжих боломжгүй юм. Бид, сургууль, багш нар энэ боловсролыг бүхий л хичээлийнхээ агуулга, арга зүй, сургууль, ангидаа тогтоосон шударга ёсоор үлгэрлэн сурагчиддаа олгох боломжтой.

Хүүхэд, залууст авлигын эсрэг үзлийг сурталчлах, түгээхэд сургууль, багш нар чухал үүрэг гүйцэтгэж, тодорхой шинэчлэлийг нийгэмд авчирч байдаг. Сургууль, боловсролын байгууллагууд нь авлигатай тэмцэх гэхээсээ илүү түүнээс урьдчилан сэргийлэх, зан үйлийг өөрчлөх чиглэлд ажиллах нь чухал юм. Хэдийгээр авлигаас урьдчилан сэргийлэх нь авлигатай тэмцэх явдлын нэг л тал боловч боловсролын тогтолцоо, сургалтын үйл ажиллагаанд нэвтэрснээр удаан хугацааны тогтвортой үр дүнд хүргэдэг байна.

Хэдийгээр шударга ёсны тухай зааж сургах, нийгэмд төлөвшүүлэх арга хэмжээ нь олон хэлбэртэй боловч олонх мэргэжилтнүүд “тусгай нэмэлт хичээлээр бус харин одоогийн мөрдөж буй сургалтын агуулга, хөтөлбөрүүдэд нягт уялдуулан шингээж өгөх нь илүү үр дүнтэй” хэмээх дүгнэлттэй санал нийлж байна. Авлигын эсрэг боловсролыг ерөнхий боловсролын агуулгатай нэгтгэн интеграцичлах оролдлого зарим улс оронд амжилттай хэрэгжиж буй боловч олон улсын түвшинд эхлэлийн байдалтай байна.

Авлигын эсрэг боловсрол нь дангаар бус одоо хэрэгжиж буй албан боловсролын бүрэлдэхүүн хэсгүүдтэй агуулгын хувьд нэгтгэн интеграцичлах нь илүү оновчтой хэмээн үзэж байна. Үүнд:
Нийгэм судлал
Иргэний боловсрол
Түүх зэрэг олон хичээлийн хүрээнд нэвтрүүлж болно.

Ерөнхий боловсролын сургуулиар олгож буй нийгмийн ухааны боловсролын өнөөгийн нөхцөл байдлаас үзэхэд авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлд одоо мөрдөж буй сургалтын төлөвлөгөөний дагуу “Нийгмийн ухаан”, “Иргэний боловсрол” хэмээх хоёр хичээл шууд холбоотой болно. “Нийгмийн ухаан” нь ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн VIII-IX ангийн сургалтын төлөвлөгөөний[2] дагуу сургалтын тогтвортой агуулга болох тул заавал судлах хичээл юм. Нийгмийн ухааны хичээлийн хүрээнд нийгмийн харилцаа, ёс суртахуун, эрх зүй, эдийн засаг гэсэн нийгмийн амьдралын үндсэн хүрээг хамран судалдаг. Харин “Иргэний боловсрол” нь  сургууль зохицуулах агуулгад хамаардаг бөгөөд уг хичээлээр ёс суртахууны өндөр соёлтой, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач энэрэнгүй, эх оронч, үндэсний дэвшилтэт ёс заншил болон хүн төрөлхтөний соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж заажээ.

Сургуулиуд нь авлигын эсрэг боловсролыг дэмжихийн тулд одоогийн албан боловсролын тогтолцооны олон бүрэлдэхүүн хэсэгт өөрчлөлт хийх шаардлагатай болно. Сургуулийн хөтөлбөрүүдэд хүний эрхийн хичээлийг оруулах буюу өөр бусад хичээлүүдтэй нэгтгэн интеграцичлах, одоогийн ашиглаж буй сурах бичгүүдийг хүний эрхийн стандартад нийцүүлэн шинэчлэх, мөн хүний эрхийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг болон бусад сургалтын материалуудыг боловсруулах, сургуулийн дүрэм журмыг хүний эрхийн зарчмуудад нийцүүлэн өөрчлөх зэргээр хүний эрхийн соёлыг сургуулийн орчинд түгээн дэлгэрүүлэхийг мэргэжилтнүүд санал болгож байна. Мөн уг хичээлийг үзэж буй суралцагчдын нас, тэдгээрийн нийгмийн оролцоо, ойлгоцын түвшнээс хамааран олон талт байдлаар зохион байгуулж болно.

---

[2] *Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн VIII-IX ангийн сургалтын төлөвлөгөө, БСШУ-ны сайдын 2010 оны 4 дүгээр сарын 2-ний өдрийн 201 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт*

Суралцагчдад ардчилсан нийгмийн үнэт зүйлс, хувь хүний үнэлэмж төлөвшихөд хамгийн чухал үүрэг гүйцэтгэгчид нь багш нар билээ. "Иргэншил", "Иргэний боловсрол" хичээлүүд нь өнөөгийн нийгмийн байгууламж, ардчилал, хүний эрх, ёс зүй, эрх зүй зэрэг агуулгыг хамарч, иргэнийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд чиглэдэг учраас багш нарын хувьд уг хичээлүүдийг маш чухалчлан үздэг байна. Нөгөө талаас, тухайн хичээлүүдээр нийгмийн амьдралын асуудлуудыг судалдаг, сэдэв агуулга нь өргөн хүрээг хамардаг, суралцагчид үзэл бодлоо илэрхийлэх, харилцах боломжийг илүү хангадаг тул тухайн хичээлд идэвхтэй оролцдог. Сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн хувьд багш нар энэхүү зорилгыг хангахад голлох үүрэгтэй байна. Сургуулийн боловсролын стандарт, хөтөлбөрт авлигын эсрэг боловсролын агуулгыг хэрэгжүүлэн, бусад хичээлүүдтэй интеграцичлан оруулах зэрэг нь өнөөгийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн багшлах ажилдаа нэвтрүүлбэл зохих гол чиглэл юм.

# ХОЁРДУГААР ХЭСЭГ:

# АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫН ЗАГВАР ХИЧЭЭЛ

## СЭДЭВ 1: ШУДАРГА БА ШУДАРГА БУС ЗҮЙЛСИЙН ЯЛГАА

Хүлээгдэж буй үр дүн:

- Нийгмийн олон талт харилцааны явц дахь шударга болон шударга бус байдал, хууль ёсны болон хууль бус зүйлсийн талаарх жишээ баримтуудыг ялган зааглаж, тодорхой шударга ёсны тухай зохих ойлголттой болох
- Нийгэм дэх шударга болон шударга бус байдал, хууль ёсны болон хууль бус зүйлсийн талаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх, шударга ёсны үнэт зүйлсийг хамгаалах чадвараа хөгжүүлэх.

Холбогдох хичээл: Иргэний боловсрол

Зорилтот бүлэг: 8-9 дүгээр ангийн суралцагчид

Сургалтын арга: Тохиолдол шинжлэх, бүлгээр ажиллах, нээлттэй хэлэлцүүлэг

Хэрэглэгдэхүүн: Шударга ёс, хууль ёсны болон хууль бус зүйлсийн талаарх бодит тохиолдлуудын жагсаалт

Иргэн М хот хоорондын тээврийн автобусаар хөдөө явахаар болов. Тэрээр автобусны тасалбарыг авч амжаагүй тул тасалбар хураагчид хандан өөрийг нь явуулж өгөхийг гуйлаа. Харин тасалбар хураагч түүнд тасалбар авахгүйгээр нийт үнийн дүнгийн тал хувийг төлөөд зорчихыг санал болгов.

Их Британийн Ерөнхий сайд Черчиллийн машин их хурдтай явж байсан тул Замын цагдаа зогсоолоо. Жолооч нь Ерөнхий сайд яаралтай ажлаар явж байгаа тул хурдтай явсан болохыг тайлбарлалаа. Харин замын цагдаа түүнд хандан “Замын хөдөлгөөний дүрэм бүх хүнд адил үйлчлэх ёстой. Ерөнхий сайд ч гэсэн дүрэм зөрчсөн тул торгох шаардлагатай” хэмээгээд торгууль ногдуулжээ. Маргааш нь Ерөнхий сайд Черчилл Цагдаагийн даргыг дуудаж, өчигдрийн цагдаагийн шударга байдлыг магтан ярьж, түүнийг хугацаанаас нь өмнө цол ахиулахыг тушаажээ. Хариуд нь Цагдаагийн дарга “Уучлаарай, Ерөнхий сайд аа. Тэр цагдаа хийх ёстой ажлаа л хийсэн тул түүнийг хугацаанаас нь өмнө цол ахиулах боломжгүй” хэмээн хэлжээ.

Аав, ээж, хүү гурав гэрийн ажлаа хуваарь гарган ээлжлэн хийдэг байжээ. Мөн тэдний тогтсон хуваарь ёсоор хүүг оройн 22 цагаас хойш телевиз үзэхийг зөвшөөрдөггүй байв. Гэтэл нэгэн удаа ээж нь эзгүй байх үед хүү  аавдаа хандан “Хэрвээ би таны өмнөөс бүх аяга тавгаа угаавал та намайг өнөө орой нэг кино үзэхийг зөвшөөрөх үү?” хэмээн асуужээ. Үүнийг аав нь зөвшөөрчээ.

Сургуулийн барилга барих тендерт оролцож буй нэгэн компанийн захирал “Тендер шалгаруулахад их мэдээлэл шаардлагатай байдаг. Тиймээс та бүхэн мэдээлэл олж авахдаа ашиглаарай” хэмээн утасгүй интернет ашиглах 2 сарын эрхийн бичиг тендер шалгаруулах комиссын гишүүдэд өглөө.

Сургууль төгсөлтийн баярын үеэр нэгэн ангийн сурагчид хичээл орж буй багш нартаа маш том баглаа цэцэг бэлэглэлээ.

Жолооч Г замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тул замын цагдаа түүнийг зогсоож шалгалаа. Цагдаа түүнд 20,000 төгрөгийн торгууль ногдуулахад тэрээр одоогоор түүнд ердөө 12,000 төгрөг л байгаа тул дараа банкаар тушаая хэмээн дансны дугаар асуулаа. Харин цагдаа түүнд байгаа мөнгийг аваад “Баяртай” хэмээн хэллээ.

Жолооны дамжаанд суралцаж буй Э жолооны дадлагын шалгалтдаа унажээ. Багш нь түүнд хандан бага зэргийн мөнгө өгөх юм бол дахин шалгалт авахгүйгээр жолоочийн үнэмлэх авах боломжтой шүү хэмээн хэллээ.

Нэгэн бизнес эрхлэгч мэргэжлийн хяналтын ажилтанд хэмжилт хийж өгсөн тул гэрээнд заасан ёсоор түүнд мөнгөн төлбөрийн баримт өглөө. Гэтэл уг мөнгөн дүн нь бодит хэмжээнээс хоёр дахин их байгаа тул авах боломжгүй хэмээн буцаан өглөө.

Нэгэн компанийн захирал татвар нуун дарагдуулсан хэргээр шалгуулж байв. Энэ үеэр тэрээр иргэний хэргийн шүүгчийг нэгэн үнэтэй ресторанд хамт хоол идэхийг урилаа. Харин шүүгч хар нүдний шил зүүн бусдад танигдахгүйг хичээж байв

Сургуулийн нэгэн багш эмэгтэй маш их хэмжээний даалгавар өгдөг. Түүний өгсөн даалгаврыг хийхийн тулд сурагчид маш их хүч хөдөлмөр, цаг зарцуулдаг байжээ. Нэгэн сурагч охины ээж тэр багштай удаан хугацаанд ярилцлаа. Хэдийгээр багш, ээж хоёр юуны тухай ярилцсаныг хэн ч мэдээгүй боловч түүнээс хойш тэр охинд маш амархан даалгавар өгөх болжээ.

Хичээлийн явц:

Суралцагчид 4 бүлэгт хуваагдаж, дараах даалгаврыг гүйцэтгэнэ. Үүнд:

Бүлэг тус бүр өөрийн авсан тохиолдолд шинжилгээ хийж, хэлэлцэнэ. Үүний тулд багшийн самбарт бичсэн асуултыг ашиглана.

Бүлэг тус бүр өөрсдийн дүн шинжилгээг бусад багуудад танилцуулахад бэлтгэнэ.

Багшийн анхааралд:

Бүлэг тус бүрд Шударга ёс, хууль ёсны нөхцөлийн талаарх жагсаалт өгнө.

Дараах асуултуудыг самбарт бичнэ.

- Аль тохиолдолд, хичнээн хохирогч байна вэ? Тэд яагаад хохироход хүрсэн бэ?
- Тохиолдлуудад ямар гэм буруутай үйлдэл, үйл ажиллагаа хийж байгааг тодорхойлно уу? Яагаад буруутайд тооцох вэ?
- Энэ нь гэмт хэрэг мөн үү?  Хэрэв мөн бол ямар төрлийн гэмт хэрэг вэ?
- Энэхүү гэмт хэргийг гарахад ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?
- Гэм буруу ба гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх шаардлагатай вэ?

Бүлгийн ажлын танилцуулга: бүлэг тус бүр өөрсдийн дүн шинжилгээг бусад багуудад танилцуулна.

Дүгнэлт: Дараах асуултаас ашиглан дүгнэлт хийх боломжтой. Үүнд:

- Тохиолдол бүрт байгаа нийтлэг асуудал юу байна вэ?
- Тохиолдолд гарч буй нийтлэг асуудлыг шийдвэрлэснээр бидэнд ямар үр өгөөжтэй вэ?
- Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд хэн, хэн, юу хийх ёстой вэ?

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Нийгмийн бодит харилцааны явцад шударга болон шударга бус байдал, хууль ёсны болон хууль бус зүйлсийг шууд ялгаж дүгнэхэд бэрхшээлтэй байдаг. Үүний адилаар тухайн тохиолдол нь авлига мөн эсэх талаар үндэслэл, баримт нотолгоогүйгээр шууд таамаглан хэлэх нь зохисгүй байдаг. Иймд бодит үйл явдал, тохиолдол бүрд үндэслэл, нотолгоотой хандаж, үнэн зөв болон шударга, шударга бусыг ялган тодорхойлох нь зохистой болохыг суралцагчид танин мэднэ.

Нэмэлт мэдээлэл:  Шударга ёс гэж юу вэ?

Шударга ёс хэмээх ойлголт нь зөвийг эрхэмлэн дээдэлж, энэрэн хайрлаж, хөхиүлэн дэмжих, бурууг жигшин зэвүүцэж, зэмлэн цээрлүүлэх талаар хүн төрөлхтөний харилцаанд тогтсон үнэт зүйлүүдийн нэг болохыг хууль зүйн эрдэмтэд тайлбарласан байдаг. Олон улсын түвшинд шударга байх гэдгийг ёс зүй, ёс суртахуун (morality, ethics), сайн үйл хийх, зөв хүмүүжил (righteousness), хууль ягштал сахих (law abiding), авлигыг үл тэвчих (Intolerance to corruption) гэсэн ойлголтуудаар илэрхийлдэг байна.

Шударга ёсны төлөө тэмүүлэл нь аз жаргалын төлөөх хүмүүсийн хүсэл юм. Аз жаргал гэдэг нь хүн дан ганцаараа олж үл чадах зүйл бөгөөд нийгэм дотроос эрж хайдаг. Тиймээс шударга ёс бол нийгэм дэх аз жаргал. Өөрөөр хэлбэл, нийгмийн тогтолцоог баталгаажуулж өгч байгаа аз жаргал хэмээн ойлговол зохилтой. Тиймээс эртний сэтгэгч Платон шударга ёсыг аз жаргалтай адилтган “Зөвхөн шударга хүн л жаргалтай, шударга бус хүмүүс жаргалгүй” гэж хэлж байжээ.

“Шулуун шударга явах нь хүний хамгийн нандин зан чанарын нэг. Хүмүүсийн шулуун шударга байх ёс алдуурвал нийгэмд шударга бус явдал газар авч, улс орны хөгжил нь зогсч уруудан доройтох тийшээ ханддаг нь жам ёсны үзэгдэл ажээ. Шударга зан чанарыг монгол гэрийн баганатай зүйрлэж болно. Гэрийн хос багана байхгүй бол тооныг тогтоож чадахгүй. Үүнтэй нэгэн адил хүнд авьяас, эрдэм байгаад ч шулуун шударга, ариун байхгүй бол хөл дээрээ баттай зогсч чадахгүй” хэмээн Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн С.Нарангэрэл “Шударга ёс” өгүүлэлдээ бичжээ.

Эх сурвалж: Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, НҮБХХ., Авлигын эсрэг цагаан толгой., УБ., 2010., http://www.iaac.mn

СЭДЭВ 2: НӨХӨРЛӨЛ, ШУДАРГА ЁС ХОЁР

Хүлээгдэж буй үр дүн:

Шударга ёсны тухай болон хүний сайн зан чанарын тухай эргэцүүлэх, шударга ёсыг тогтоохын төлөө үйлдэл хийх итгэл үнэмшилтэй болоход туслах

Хичээлийн нэр: Нийгмийн ухааны хичээл

Зорилтот бүлэг: 8-9 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Эвлүүлгийн арга

Хэрэглэгдэхүүн 1: Шударга ёсны тухай хүмүүсийн хэлсэн үгийг уншина уу. Та ч бас шударга ёсыг тодорхойлох эрхтэй.

"Шударга байхад шударга ёс хэрэгтэй" Баабар

"Үнэн, үнэн гэж хэлэгдэхээ болих цагт шударга ёс үнэртэхээ болино" "Чөлөөт бүс" Блогоос

"Үнэн байх, шударга байх гэдэг нь сэтгэлийн таашаал төдий зүйл биш, амьд явахын, хүн байхын шагнал буюу" "Өнөөдөр" сониноос

"Шударга ёс гэдэг нөмөр нөөлөгт нь үнэний төлөөх эрэл урагшлан давшиж чадах нийгмийн тогтолцоо" Иргэн Р.Батхүү

"Шударга ёсыг тогтооход бид энд тэндээс зээл тусламж хүсэх шаардлагагүй. Шударга ёс тогтож чадвал нийгмийн баялгийн хуваарилалт зөв болж ард түмэн маань хямралт байдлаас ангижрах болно. Үүнийг Та бид өөрсдөө л хийнэ" Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж

"Шударга бус хүн эд баялаг, эрх мэдлийг олж авбал өөртөө ч, өрөөлд ч гай зовлон тарьдаг" Иргэн А.Даваасүрэн

Эх сурвалж: http://integrity.blog.gogo.mn

Хэрэглэгдэхүүн 2: Нөхөрлөл, Шударга ёс хоёр

Энэ түүх эрт дээр үед болжээ. Нөхөрлөл, Шударга ёс хоёр багаасаа л дотнын андууд байжээ. Тэд бие биедээ ах, дүүс шиг итгэж, санаа бодлоо бүрэн ойлголцдог, нөхрийнхөө төлөө юу ч хийхээс буцахгүйгээр нөхөрлөдөг байв. Нэгэн удаа тэдний нөхөрлөлийг шалгасан айхтар зүйлтэй тулгарчээ.

Шударга ёс хэд хэдэн удаа хаан ард түмнийг дарлаж байгаа тухай, түүний түшмэд нь шударга бус үйл ажиллагаа явуулж байгаа тухай шүүмжилжээ. Эзэн хаан үүнд маш их хэлэгнэж Шударга ёсыг найз Нөхөрлөлтэй нь дуудаж гэнэ. Тэгээд:

Энэ бол урвалт. Чи намайг түлхэн унагах хуйвалдаан зохиож байна. Хэлсэн үгээ буцааж авахгүй бол хүндээр шийтгэнэ гэж гэнэ.

Шударга ёс:

Би хэзээ ч хэлсэн үгээ буцааж авахгүй. Яагаад гэвэл би үнэн хэлсэн. Та нар хэт их эрх эдэлж, ард олныг дарлаж байна гэжээ.

Тэгвэл чи үхэх болж дээ. Үхэхийнхээ өмнө хэлэх хүсэлт байна уу? гэж хаан уурсан хашгирав.

Байнаа. Аав, ээжтэйгээ салах ёс гүйцэтгэж ирэхийг зөвшөөрнө үү гэж Шударга ёсыг хэлэхэд хаан:

Чи намайг шударга бус төдийгүй тэнэг гэж бодож байх шив. Чамайг явуулчихвал хэзээ ч эргэж ирэхгүй шүү дээ гэв.

Шударга ёс:

Тэгвэл би танд барьцаа үлдээе.

Чамайг эргэж ирнэ гэдэгт би итгэлтэй байхаар ямар барьцаа чи надад өгч чадах юм бэ? гэж хаан асуув.

Гэтэл найзтайгаа зэрэгцэн сууж байсан Нөхөрлөл гэнэт босож:

Би барьцаа болъё. Шударга ёсыг эргэж иртэл би шоронд байя. Та бидний нөхөрлөлийг мэднэ. Би энд үлдвэл тэр заавал ирэх болно гэлээ.

Эзэн хаан найзууд руу чимээгүй харж байгаад:

За яахав, хэрэв тэр тогтоосон хугацаанд ирэхгүй бол чи цаазлуулах болно шүү гэж гэнэ.

Ингээд Шударга ёс явж, Нөхөрлөл шоронд оров. Тогтоосон хугацаа ойртож Шударга ёс ирээгүй л байлаа. Эзэн хаан Нөхөрлөлийг харамсч байгаа эсэхийг харах гэж шоронд очоод:

Чиний цаг бараг дууслаа даа. Өршөөлийн тухай бодох ч хэрэггүй шүү. Найзынхаа амлалтад итгэсэн чинь тэнэг хэрэг байж дээ гэж Нөхөрлөлийг тавлав. Нөхөрлөл:

Тэр зүгээр л жаахан саатсан. Түүнд тохиолдсон замын саатлыг давж гардаг л юм бол тэр цагтаа ирнэ гэж маш итгэлтэйгээр, аажуу тайван хариулав гэнэ. Хаан хоригдлын итгэлтэй байдлыг хараад балмагдав.

Тогтоосон өдөр дуусч Нөхөрлөлийг цаазын тавцан руу аваачив.

Найз чинь ирсэнгүй. Чи одоо юу хэлмээр байна гэж хааныг асуухад:

Тэр бол миний найз. Би түүнд итгэдэг гэж Нөхөрлөл хариулав.

Энэ үед талбай дээр Шударга ёс гарч ирлээ. Тэр ядарч туйлдсан, хамаг хувцас нь урагдсан байлаа. Тэр найзыгаа тэвэрч, ядарсандаа арайхийн ингэж хэлжээ:

Чи одоо аюулгүй боллоо. Хувь заяа бидний эсрэг эргэжээ л гэж бодож байлаа шүү. Хөлөг онгоц маань эвдэрч, бидэн рүү дээрэмчид дайрсан. Гэхдээ л амжиж ирлээ шүү. Би цаазлуулахад бэлэн байна.

Хаан бүр балмагдчихсан байв. Түүний нүд, зүрх сэтгэл нээгджээ. Тэр энэ агуу нөхөрлөлийн өмнө өөрийнхөө хүчгүйг мэдрэв. Цаазлах ялыг хүчингүй болгоод тэр ингэж хэлэв: Нөхөрлөл гэдэг ийм агуу итгэлээр гэрэлтдэг гэдгийг би хэзээ ч итгэж явсангүй. Та бүхэн миний бурууг ойлгуулсан тул шагналд нь би та нарт эрх чөлөө олгоё. Гэхдээ нэг зүйлийг гуйхыг зөвшөөрнө үү?

Юу вэ? Хэлээч гэж найзууд асуув.

Намайг энэ эрхэм нөхөрлөлдөө сургаач хэмээн эзэн хаан чин сэтгэлээсээ гуйв.

Хичээлийн явц:

“Нөхөрлөл, Шударга ёс хоёр” эх дээр дараах даалгаврыг хийгээрэй.

- Эхийг унших
- Өөрт хамгийн их таалагдсан үг, өгүүлбэрийн доогуур зурах
- Өөрт төрсөн сэтгэгдэл, сургамжийг тэмдэглэх

Хосоороо ажиллах:

Доогуур нь зурсан үг, өгүүлбэр болон сэтгэгдэл, сургамжийг бие биедээ уншиж өгөх

Том болон жижиг багаар ажиллах:

а) Сурагчид “Шударга ёс”, “Нөхөрлөл”, “Хаан” гэсэн гурван багт, тэнцүү тоотой гишүүнтэй байхаар хуваарилагдана

б) Багууд дараах даалгаврыг гүйцэтгэнэ. Үүнд:

- “Шударга ёс” баг: Шударга ёсыг тогтоохын тулд юу хийх хэрэгтэй талаар хаанд өгөх зөвлөгөөг бэлтгэнэ.
- “Нөхөрлөл” баг: Хүний эрхэм сайн зан чанарыг өөртөө хэрхэн төлөвшүүлэх талаар хаанд өгөх зөвлөгөөг бэлтгэнэ.
- “Хаан” баг: улс орондоо шударга ёс тогтоох, ард иргэдийн ёс зүйн хүмүүжлийг дээшлүүлэх талаар юу хийх хэрэгтэй байгаа талаар Шударга ёс, Нөхөрлөл хоёрт хийх танилцуулгыг бэлтгэнэ.

Анхаарах зүйл: Багш баг тус бүрийн даалгавраа ойлгосон эсэхийг нягтлах ба багийн ажлын үед шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. Мөн том багийн ажлын явцад баг тус бүрийн гишүүдэд нэгээс эхлэн тооногдуулах бөгөөд ингэснээр гурван багт адил тоотой нэг нэг гишүүн бий болно. Энэ нь дараагийн жижиг багийн ажлын бэлтгэл болно.

а) Том баг дээр багийн гишүүн бүр өөрийн багийн ажлын үр дүнг танилцуулахад бэлэн болсны дараа баг бүрийн адил тоотой хүүхдүүдийг нэг баг болгож гурван гишүүнтэй жижиг багууд үүснэ. Жижиг багийн тоо нь том багийн гишүүний тоогоор үүснэ.

б) Жижиг багийн гурван гишүүн өөд өөдөөсөө харж зогсоод том баг дээр бэлтгэсэн танилцуулга болон зөвлөгөөг 3-5 минутад багтаан бие биедээ ярьж өгнө.

Анхаарах зүйл: Жижиг багийн ажлын үеэр багш 2 зүйлийг анхаарна. Үүнд:

- Багийн гишүүдийг зэрэг эхлүүлэх, цагийг нь баримтлуулах. Ингэж чадвал олон жижиг баг зэрэг ажлаа дуусгана.
- Жижиг багуудын дундуур явж хүүхдүүд хэрхэн бие биедээ ярьж өгч байгааг ажиглана.
- Эхийг уншсанаараа болон том, жижиг багт ажилласнаар хүүхдүүд юу олж авсныг ярилцана.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Нийгмийн бүх харилцаанд шударга ёсыг тогтоох, хүн бүр зан суртахууны эрхэм чанарыг эзэмшсэн байх нь авлигагүй нийгмийг байгуулах үндэс болно. Үүнийг төр засаг, иргэд хоёр хамтарч хийх хэрэгтэй.

СЭДЭВ 3: БЭЛЭГ ҮҮ, АВЛИГА УУ?

Хүлээгдэж буй үр дүн:

- Авлигын хор уршгийг мэдэх;
- Өөрийн үйл ажиллагаандаа болон нийгэмд байгаа зохисгүй үзэгдлүүдийг олж харж; шүүмжлэлтэй хандаж сурах;

Холбогдох хичээл: Иргэний боловсрол

Зорилтот бүлэг: 7-9 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Дүрийн тоглолт, ярилцлага

Хэрэглэгдэхүүн:

**Дүрийн тоглолтоор үзүүлэх тохиолдол**

- 5-10 дугаар анги хүртэл ангийг нь дааж ажилласан багшдаа 10 дугаар ангийн хэсэг сурагчид баяр хүргэж цэцгийн баглаа, бичгийн хэрэглэл бэлэглэж байгааг харуулсан тоглолт
- Нэг чинээлэг бололтой гэр бүлд сургууль төгсөх шалгалт ойртсон тухай яриа болно. Ээж нь: "Энэ Алтжин юу ч хийхгүй юм. Яаж анги дэвшиж 8 дугаар ангидаа орноо. Цаана нь бас 9 дүгээр ангидаа орж чадах эсэх, 10 дугаар ангиа төгсөх асуудал байна" гэхэд аав, охин хоёр хэнэггүй сууна. Маргааш нь Алтжингийн аав сургууль дээр ирж анги удирдсан багшид дугтуйтай зүйл, ээмэг бэлэглэнэ.

Хичээлийн явц:

Сурагчдын анхаарлыг төвлөрүүлж, идэвхтэй үйл ажиллагаанд татан оролцуулахын тулд багш хэсэг сурагчидтай хамтран хоёр янзын жүжигчилсэн тоглолтыг бэлтгэсэн байна. Багш энэ хоёр жүжигчилсэн тоглолтоор хичээлээ эхэлнэ.

Анхаарах зүйл: Ангийн байрлал хагас дугуй хэлбэртэй тойрч суугаад, жүжиг үзэх, ярилцлага хийхэд эвтэйхэн засагдсан байна.

Жүжгийг үзсэний дараа «Бэлэг хээл хахууль мөн үү?» сэдвээр ярилцлага явуулах бөгөөд дараах асуултаас ашиглаарай. Үүнд:

- Жүжиг дээр гарсан үйл явдлууд ямар ялгаатай вэ? Бэлэг, хээл хахууль хоёр ямар ялгаатай вэ?
- 10 дугаар ангийн хүүхдүүд яагаад багшдаа бэлэг өгсөн бэ? Бэлэг авсан багш, сурагчид хоёрын хооронд ямар харилцаа үүсэх вэ?
- Алтжингийн аав багшид яагаад бэлэг өгсөн бэ? Алтжин, болон тэдний гэр бүлийнхэн болон багшийн хооронд ямар харилцаа үүсэх вэ?

Энэ бэлэг Алтжинд ямар хортой үр дагавартай вэ? Ашигтай байж болох уу?

Амьдрал дээр ийм явдал тохиолддог уу?

Хээл хахууль гарч байгаагийн шалтгаан юу вэ?

Хээл хахууль хувь хүнд болон нийгэм, улс оронд ямар хор хохиролтой вэ?

Хор хохиролтойг нь мэдсээр байж яагаад энэ үзэгдэл гараад байдаг юм бэ?

Үүнтэй тэмцэх ямар арга замууд байдаг вэ?

Бид бүхэн авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэхэд ямар хувь нэмэр оруулж чадах вэ?

Үлдсэн хугацаанд сурагчид ярилцлагынхаа сэдвээр зохион бичлэг хийж бусдадаа уншиж сонсгоно.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Авлига өргөн хүрээтэй ойлголт болохыг танин мэднэ.

Нэмэлт мэдээлэл: Бэлэг гэж юу вэ?

Монголчууд төр ёсны болон өвөө эмээ, аав ээж, ах дүү, үр хүүхэд, анд нөхдөдөө бэлэг барьдаг эртний тогтсон уламжлалтай. Я.Цэвэлийн “Монгол хэлний тайлбар толь”-д бэлгийг “Талархлаа илэрхийлж өгөх юм” гэж тодорхойлжээ. Харин энд бид “өөр бэлэг”-ийн талаар ярилцах болно. Жишээ нь, хичээлээ сайн заасан багш, мэс засал амжилттай хийсэн эмч, ажлаа сайн хийж таны асуудлыг шийдвэрлэж өгч буй төрийн албан хаагчид талархлаа илэрхийлэн өгч байгаа мөнгө болон эд зүйлс бэлэг мөн үү?

Хүмүүс ачит багш, алтан гартай эмчид баяр талархлаа илэрхийлж, мөнгө, эд зүйл өгөхийг хүсч болох юм. Харин Таны өгч буй мөнгө, эд зүйлийг тэд авах ёсгүй. Яагаад гэвэл эдгээр хүмүүс мэргэжлийн албан үүргээ л амжилттай гүйцэтгэсэн, угаасаа ч ингэж гүйцэтгэх ёстой. Энэ нь тэдний мэргэжлийн үүрэг, хариуцлага юм. Ингэхээр та ч бас тэдэнд “бэлэг” өгөх шаардлагагүй гэсэн үг. Үүнийг бид авлигад “Үгүй” гэж хэлж сурах, авлигыг үл тэвчих үзэл гэж ойлгож болно. Ийм “бэлэг” нь та бидэнд зориулсан нийгмийн үйлчилгээг улам үнэтэй, хүнд сурталтай болгодог аюултай. Цаашдаа яван явсаар том авлигын эх суурь болдог. Олон улсын практикт “Хахууль бол хариу тус авахын тулд өгсөн бэлэг бөгөөд төрийн албан хаагчаас ажил албаа гүйцэтгэх зан үйлд нь нөлөөлөх, төрийн албаны шударга байдал, ёс зүйн дүрэм журмаас эсрэг үйлдэл хийлгэх зорилготой” гэж үздэг.

Улс орон бүр төрийн албан хаагчидаа ийм зүй бус “бэлэг” авах аюулаас хамгаалахын тулд тодорхой дүрэм журмууд гаргасан байдаг. Тухайлбал, манай улсын Төрийн албаны тухай хууль, “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”, “Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрэм” болон бусад мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд энэ талаар тодорхой зүйл заалтыг тусгасан байна.

Гэтэл хүн гэдэг амьтан угаасаа нийгмийн амьтан тул бусдаасаа баяр талархлыг хүлээн авч, бид ч бусдадаа баярлаж, талархсанаа илэрхийлж бэлэг өгөх дуртай. Тэгэхээр ямар бэлгийг авч болохгүй вэ, ямар бэлэг өгч болохгүй вэ? гэдэг асуултад хариулах хэрэгтэй болно. Хэн нэг нь

бэлэг өгснийхөө төлөө авлигыг дэмжигч болж, мөн хэн нэг нь бэлэг авсныхаа төлөө авлигач болохыг хүсэхгүй шүү дээ.

Эх сурвалж: МУ-ын ШУА., Монголын нэвтэрхий толь., УБ., 2000., Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, НҮБХХ., Авлигын эсрэг цагаан толгой., УБ., 2010., Авлигатай тэмцэх газар., Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага., УБ., 2010.,

## СЭДЭВ 4: НЭР ХУГАРАХААР ЯС ХУГАР

Хүлээгдэж буй үр дүн:

Хүний эрхэм чанар, зан аашийг ялгах, өөрийн зан суртахуунд шүүмжлэлтэй хандах;
Шударга, үнэнч зан суртахууныг өөртөө төлөвшүүлэх;

Холбогдох хичээл: Нийгмийн ухааны хичээлийн “Ёс зүй” бүлэг болон ангийн ажил, иргэний боловсролын хичээл

Зорилтот бүлэг: 6-7 дугаар ангийн сурагчид

Хичээлийн арга: Ярилцлага, багийн ажил

Хэрэглэгдэхүүн: То вангийн сургаалын хэсгээс

Энэхүү гайхамшигт сургаалыг XYIII-XIX зууны Монголын их сурган хүмүүжүүлэгч Тогтохтөр /То ван/ зохиожээ.

| Эрхэм сайн хөвүүний ёс нь: | Үүрд муу хөвгүүн нь: |
|---|---|
| Эцгийн сургаалаар явагч<br>Эрдэм билиг сурахад дуртай<br>Энхрэх[11] ухаантай хөвгүүн лүгээ нэг.<br><br>Ах дүү хэнд ч аятай<br>Алинд нь зарвал ялгуум[22] сайн<br>Ааль зан нь дөлгөөн номхон<br>Уургүй, шударга хөвгүүн лүгээ хоёр. | Аяган дахь идээгээ чамлан<br>Айлын идээнд гүйгч<br>Аливаа хов үгсийг зөөгч<br>Асар муу хөвгүүн лүгээ гурав болно. |

Сайн охины ёс нь: Асар муу охины ёс нь:

Сайн, сайхан гоо зүстэй бөгөөд санаа сэтгэл нь номхон дөлгөөн, саруул нэг. ухаантай охин лугаа нэг.

Эхийн сургаалаар явагч, эгч дүүтэйгээ этэй, эсгэх оёход уран, эрхэм сайн айл охин лугаа хоёр.

Авир дүр нь чөтгөр мэт, асар ихууртай, ааш муутай охин лугаа

Ачит эцэг, эхээ сургавал уурлан, ах дүүтэйгээ хэрэлдэн хараагч, алиа наадангуйд маш баясан,

хэсэгч охин лугаа хоёр.

Хичээлийн явц:

Сурагчдын анхаарлыг төвлөрүүлэх хэсэг:

Монголчууд яагаад “Нэр хугарахаар яс хугар” гэж үздэг вэ? асуултын хүрээнд сурагчдын санаа бодлыг сонсох.

Дээрх зүйр үгтэй ижил, төсөөтэй утгагтай зүйр үг, хэлц үгийг асуух

Ярилцлага:

То вангийн сургаалыг уншаад дараах асуултын дагуу ярилцах

То ван одоогоос хэдэн зууны өмнө сургаалаа бичсэн бэ?

Энэ сургаал яагаад өнөөг хүртэл мартагдаагүй байна вэ?

Та өөрийгөө урамшуулна уу? Танд сайн охин /хүү/-ы ямар, ямар шинжүүд байдаг вэ?

Та өөртөө шүүмжлэлтэй хандана уу? Танд муу охин /хүү/-ы ямар шинж байна вэ?

Багаар ажиллах:

“Үүрд муу хөвгүүн”, “Сайн охин”, “Эрхэм сайн хөвгүүн” “Асар муу охин” дөрвөн багт хуваагдаад дараах даалгаврыг хийгээрэй.

То вангийн сургаалын утга санааг жишээ, баримттайгаар тайлбарлана.

Тайлбараа зургаар илэрхийлнэ.

- Багийн ажлын тайланг сонсох

Дүгнэлт хэсэг: Ашиглаж болох асуултууд:

Та бүгд То вангийн сургаалаас хүний ямар эрхэм чанар, зан аашийг ялгасан бэ?

Хүн ёс суртахууны эрхэм чанар, зан суртахууныг эзэмшсэн байх нь түүнд ямар хэрэгтэй вэ?

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Авилгыг үл тэвчих үзэл, хандлага нь хувь хүний ёс зүй, ёс суртахуунтай шууд холбоотой. Иймээс багш бид хүүхдэд багаас нь шударга, үнэнч зан суртахууныг төлөвшүүлэхэд анхаарах учиртай.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ: ТО ВАН (ТОГТОХТӨР)-ийн намтраас

Монгол Улсын түүхнээ Халхын хэцүү То ван хэмээн алдаршсан Бат-Очирын Тогтохтөр 1797 онд Сэцэнхан аймгийн Илдэн вангийн хошууны нутаг “Сангийн далай” гэдэг газарт засаг ноён Бат-Очирын гэр бүлд төржээ. 25 настайдаа эцгийн хэргэм зэргийг залгамжлан, хошууны засаг ноён болсон ба 1839 онд Хэбэй ван, 1859 онд Сэцэнхан аймгийн Чуулганы даргаар томилогджээ. То ван Бээжинд шадарт яваад буцах замдаа 1868 оны 4 дүгээр сарын 6-нд учир битүүлэг шалтгаанаар насан эцэс болжээ.

То ван бол эзэн богд Чингис Хааны алтан ургийн хүн бөгөөд төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, авъяаслаг зохион байгуулагч, эх оронч хүн байлаа.

То вангийн ажил үйлс, шинэтгэлийн үйл ажиллагаа нь хичнээн дэвшилтэт байсан ч Монголыг эрхшээж байсан Манжийн засаг төрийн бодлогын эсрэг чиглэж байснаас ямар ч дэмжлэг авч байгаагүй, харин ч шахалт хавчлагатай байнга тулгарч ирсэн байна. То ван самбаачлан, албан татварын хөрөнгөөр хошуунyхаа 4 жасыг том лам нарын мэдлээс гарган, үйл ажиллагааг нь өргөтгөн байгуулж, өөрөө удирдан, өртөө улааны алба хаших, уран барилга, бурхан шүтээний зураг төсөл зохиох,ном хэвлэх, ядуучуудад абшиг хишиг хүртээх зэргээр эдийн засгийн шинэчлэл явуулахад ашиглаж иржээ.

Манжийн эрхшээлийн үед байнга гардаг байсан маргаан, зөрөлдөөний нэг түгээмэл хэлбэр нь газар нутгийн хил хязгаарын асуудал байлаа. Нутаг дэвсгэр, хил хязгаарын маргааныг нааштайгаар шийдвэрлэх явцдаа Ар булаг, Модон хашаат, Хулд уул зэрэг нэр бүхий Манжид алдагдсан газрыг мэргэн ухаанаар өөрийн нутагт буцааж авсан.

Эх сурвалж: www.tovan.pms.mn

СЭДЭВ 5: УРТ ХАЛБАГА

Хүлээгдэж буй үр дүн:

Хүний эрхэм чанар, зан аашийг ялгах, өөрийн зан суртахуунд шүүмжлэлтэй хандах;
Шударга, үнэнч зан суртахууныг өөртөө төлөвшүүлэх;

Хичээлийн нэр: Нийгмийн ухаан

Зорилтот бүлэг: 6-7 дугаар ангийн сурагчид

Хичээлийн арга: Ярилцлага, бие даан болон хосоор ажиллах арга

Хэрэглэгдэхүүн 1:

Урт халбага /домгоос сэдэвлэв/

Нэгэн бадарчин бурхнаас “Намайг хамгийн зовлонтой хүмүүстэй газар аваачиж үзүүлээч” гэж гуйжээ. Бурхан ч түүний хүслийг биелүүлж гэнэ. Бадарчин тэнд очоод тансаг хоол ундтай том ширээ байхыг харжээ. Гэтэл тэнд байгаа хүмүүс их өлсч байлаа. Бадарчин гайхаад Бурхнаас асуусанд:

Энд ирсэн бүх хүмүүст таван тохой урт бариултай халбага өгөөд хоол идэхийн тулд үзүүрээс нь барьж идэхийг даалгадаг юм. Хэрэв халбагыг үзүүрээс нь баривал идэх боломжгүй болно. Тэгээд тэд амандаа хоол хийж чадахгүй байгаа юм гэжээ.

Бадарчин бурхнаас “Тэгвэл би хамгийн аз жаргалтай байгаа хүмүүсийг үзэж болох уу” гэжээ. Бурхан ч зөвшөөрч гэнэ. Бадарчин тэнд очоод тансаг хоол ундтай том ширээ байхыг харжээ. Харин тэнд байгаа хүмүүс их баяр хөөртэй, аз жаргалтай байлаа. Бадарчин гайхаад Бурхнаас:

Энд халбага тавиагүй юм уу? гэж асуусанд:

Байгаа. Яг адилхан таван тохой урт бариултай халбага өгөөд хоол идэхийн тулд үзүүрээс нь барьж идэхийг даалгадаг. Харин энд байгаа хүмүүс өөрөөсөө гадна бусдыг хооллохыг илүүд үздэг юм гэж хариулжээ.

Хэрэглэгдэхүүн 2:

Хүүхдийн зургийг тойруулан дүрсүүд зурж, дотор нь асуултын тэмдэг тавина. Хүүхдүүд асуултын тэмдгийн оронд сайн хүний зан чанарыг бичнэ.

Хичээлийн явц:

Та бидний эргэн тойронд сайн, сайхан зүйлс олон байдаг. Мөн сөрөг үзэгдлүүд ч гарч байдаг. Тухайлбал, хүүхдүүд та бүхэн дараах таатай бус, сөрөг үзэгдлүүдийг сонсч, хэрхэн илэрдэг талаар хэлнэ үү.

<table>
<tr><th>Сөрөг үзэгдлүүд</th><th>Илрэх хэлбэр</th><th>Ямар мэдрэмж төрдөг вэ? /хор холбогдол/</th></tr>
<tr><td>Хүүхдүүд бие биеэ гомдоодог</td><td>Худлаа хэлдэг<br>Нэр хоч өгч шоолдог<br>Нэг нь нөгөөгийнхээ эд зүйлсийг зөвшөөрөлгүй авдаг</td><td rowspan="3">Дахиж ярилцмааргүй санагддаг<br>Анги, хичээлийнхээ үйл ажиллагаанд оролцохоос айдаг<br>Өөртөө итгэлгүй болдог<br>Ганцаараа баймаар санагддаг</td></tr>
<tr><td>Зарим хүмүүс шударга бус ханддаг</td><td>Хичээл дээр яриагүй байхад ярилаа, үймүүллээ гэж загнадаг<br>Чадах ядахаараа хийсэн ажлыг маань үгүйсгэдэг</td></tr>
<tr><td>Заримдаа бие биенээ</td><td>Тоглоомдоо оруулдаггүй</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| ялгаварлан гадуурхдаг | | Уйлмаар санагддаг |

“Урт халбага” домгоос сэдэвлэсэн эх дээр дараах даалгаврыг хийгээрэй.

Эхийг унших

Өөрт хамгийн их таалагдсан үг, өгүүлбэрийн доогуур зурах

Өөрт төрсөн сэтгэгдэл, сургамжийг тэмдэглэх

Хосоороо ажиллах:

Доогуур нь зурсан үг, өгүүлбэр болон сэтгэгдэл, сургамжийг бие биедээ уншиж өгөх

Аль нь адил, аль нь ялгаатайг ярилцах

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Авлигыг үл тэвчих үзэл, хандлага нь хувь хүний ёс зүй, ёс суртахуунтай шууд холбоотой. Иймээс багш бид хүүхдийг багаас нь өөртөө шударга, үнэнч зан суртахууныг төлөвшүүлэхэд анхаарах учиртай.

## СЭДЭВ 6: РОМЫН БҮГД НАЙРАМДАХ УЛСЫН ҮЕ ДЭХ АВЛИГА

Хүлээгдэж буй үр дүн:

Тухайн цаг үед эргэн очиж, төрийн түшмэдийн хээл хахууль авах, өмч хөрөнгийг хэрхэн шамшигдуулж байсныг сурагчдад ойлгуулах

Авлигын хор уршгийг сурагчдад таниулах

Холбогдох хичээл: Түүх (Дэлхийн түүхийн эртний үе)

Зорилтот бүлэг: 7 дугаар ангийн сурагчид

Хэрэглэгдэхүүн 1: Цицероны тухай түүхч Плутарх хэлсэн нь:

Энэ хүний өмч хөрөнгө нь бага ч гэсэн зардлаа төлөхөд хангалттай. Тэгэхээр тэр яагаад өмгөөллийнхөө үйлчилгээнд бэлэг ч авахгүй, хөлс ч авахгүй байгааг гайхаж байна. Энэ бүгдээс болж Веррус түүнийг шүүхэд дуудаж ирүүлсэн байна.

Энэ хүн бол Сицилийн претор (praetor)[3] байсан байна. Тэрбээр олон жигшүүрт хэргүүдийг шийдвэрлэж ял оноож байсан. Цицерон юу ч яриулахгүйгээр ял оноочихдог, үнэн хэрэгтээ ярих ч шаардлага байдаггүй байжээ. Преторчууд Веррусt онцгой эрх мэдэл өгсөн байна. Өмгөөлөгчийн үг хангалтгүй байгаа талаар ярьж эхэлснээс хойш саяхныг хүртэл шийдэгдэж чадаагүй л байна. Эцэст нь энэ асуудал дуусаагүй байна. Цицерон үг хэлэх шаардлагагүй гэж үзсэн. Тиймээс тэр жигшим хэргийг шалгасны дараа шоронд явуулах эсэхийг шийдэх хэрэгтэй гэж үзэж байв.

[3] Претор-Эртний Ромын төрийн албан хаагч

Хэрэглэгдэхүүн 2: Веррусийн эсрэг Цицероны хэлсэн нь:

Энэ хүн Сициллийн претор байхдаа өөрийн хууль, Сенаторуудын тогтоол зарлиг, үндэсний нийтлэг эрхийг ч эрхэмлэдэггүй байв. Сициллид хүн бүр түүний шунахай зан, ёс суртахуунгүй байдлыг мэддэг ч хэлж, нийтэлж чаддаггүй байна. Гурван жилийн турш хууль бус шийдвэр гаргаж байв.

Сургалтын арга: Дүрийн тоглолт

Хичээлийн явц: Хичээлийн эхэнд сурагчид Ромын Бүгд найрамдах улсын засгийн газартай төстэй байдлаар ангиа зохион байгуулж тус тусын байрандаа сууцгаана. Язгууртнууд бол эрх баригчид болохыг тусгайлан анхаарна. Эрх мэдэл нь зөвхөн хотын баян оршин суугчдад хамаарна. Эдгээр оршин суугчид нь бүхий л үүрэг хариуцлагаас гадуур буюу чөлөөтэй байдаг.

Сурагчид гурван багт хуваагдаж дараах даалгаврыг гүйцэтгэнэ.

Эхний баг нь Верруст ял тулгах тогтоолыг уншиж, түүнийг яллах нь зүйтэй гэдэг үндэслэл гаргана.

Хоёрдугаар баг нь Веррусийн зан байдлын шалтгааныг тайлбарлаж, түүнийг тухайн үйлдлийг хийхэд нөлөөлсөн зүйлсийг тодорхойлно.

Гуравдугаар баг нь хохирогчийн болон учирсан бүх хохирлын тухай эргэцүүлэн бодно.

Багууд дараах асуултууд болон зорилгыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

- Баримт бичгийг шалгаж үзээд Ромын Бүгд найрамдах улсад авлига байсан гэдгийг батлах. Хэрхэн илэрч гарч ирсэн бэ?
- Ромын Бүгд найрамдах улсын оршин суугчид нь хуулийг дагаж мөрдөөгүйн улмаас тэдэнд ямар хор хөнөөл учирсан бэ?
- Ромын эзэнт гүрний дээд албан тушаалтнууд болох Цицерон ба Веррус нарын зан байдлыг харьцуул. Тэднийг ийм зан гаргахад юу нөлөөлсөн бэ?

Багшийн анхааралд:

- Багш баг тус бүртэй ажиллаж зааварчилгаагаар хангана. Мөн баг бүрийн сурагчдыг адил тоогоор тоолж, сурагчдад хэлж өгнө.
- Багийн ажлыг дууссаны дараа сурагчид шүүх үйл ажиллагаанд оролцогчдын дүрийн тоглолтыг хийнэ. Үүний тулд багш дараах зохион байгуулалтыг хийнэ.
- Баг бүрт байгаа адил тоотой хүүхдүүд нийлж жижиг багийг үүсгэнэ. Өөрөөр хэлбэл, нэг жижиг баг нь нэг, хоёр, гуравдугаар багийн нэг, нэг гишүүнээс бүрдсэн байна.
- Жижиг багийн гишүүд том баг дээр хэлэлцэж гаргасан үндэслэл, нотолгоогоо бие биедээ танилцуулна.
- Эцэст нь сурагчид Веррусийг шоронд хорих эсэх талаар шийдвэр гаргана. Ажлыг шүүгч удирдана.

Хичээлийг дүгнэж ярилцана. Үүнд:

Эрх мэдэлтнүүд Ромын Бүгд найрамдах улсын хуульд захирагддаггүй байсан тухай ярилцана.

Ийм учраас оршин суугчдад хохирол учирсан талаар хэлэлцэнэ.

Сурагчид яагаад эрх мэдлийг хяналтгүйгээр урвуулан ашигласан, өмч хөрөнгийг шамшигдуулсан, хахууль авсан талаар шүүн ярилцана.

Авлигын эсрэг боловсролын холбоосууд: Энд Ромын үе дэх авлигын талаар онцлон авч үзнэ. Үүний үр нөлөө нь төрийн түшмэдүүдийн аж амьдралд тустай боловч нийгэм, улс оронд хортой байсан.

Нэмэлт мэдээлэл: Цицерон Марк Туллий ( МЭӨ 106-43 он)

Эртний Ромын улс төрийн зүтгэлтэн, уран илтгэгч, философич тэрээр ёс зүйн асуудлыг голчлон анхаарч өөрийн үзлээ “Сайн, муугийн заагийн тухай”, “Их Катон буюу өтөл насны тухай”, “Лелий буюу нөхөрлөлийн тухай”, “Үүргийн тухай” зэрэг зохиолдоо дэвшүүлжээ. Мөн дээд буяны тухай аз жаргалын цорын ганц уг сурвалж болсон сайн үйлийн тухай, ёс суртахууны үүрэг, хувийн ашгийн зөрчлийн тухай асуудлыг авч үзээд практик зөвлөмж өгөхийг оролджээ. Хүнд байгаа уг чанарыг дагаж мөрдвөл зохино гэж уриалаад түүний жинхэнэ мөн чанарыг практикийн философи нээнэ гэж үзжээ. Ингэхдээ төгөлдөржихийг эрмэлзэх ёстой. Ийм эрмэлзэлд дөрвөн сайн үйл тохирдог. Үүнд, цэцэн ухаан, шударга явдал, эрэлхэг зориг, аядуу ааш эдгээр болно. Цицерон “Төрийн тухай”, ”Хуулийн тухай” зэрэг улс төрийн зохиолууддаа төрийн үйл ажиллагаан дахь хаант засаг, язгууртны болон ардчилсан үндсийг нэгтгэх нь зайлшгүй чухал гэж дүгнээд энэ шаардлагыг Ромын Үндсэн хууль хангаж байна гэж үзжээ.[4]

## СЭДЭВ 7: БҮГД НАЙРАМДАХ УЛС: УНАЛТ БА ЯЗГУУРТНУУДЫН ЁС ЖУРАМГҮЙ БАЙДАЛ

Хүлээгдэж буй үр дүн:

Бүгд найрамдах улсын хүчийг сулруулж буй шалтгаан, нөхцөл байдлыг тодорхойлох замаар авлигын хор холбогдлыг тодорхойлох

Холбогдох хичээл: Түүх (Дэлхийн түүхийн дундад ба шинэ үе)

Зорилтот бүлэг: 8 дугаар ангийн сурагчид

Хэрэглэгдэхүүн: 1

Бүгд найрамдах улсад хаан эрх мэдэлгүй. Энд эрх мэдлийн төвлөрөл байхгүй, хүн бүр шийдвэр гаргагч байдаг. Онолын хувьд эрх мэдэл нь оршин суугчид, язгууртнуудад байсан. Гэтэл амьдрал дээр тэр нь сайн үр дагаврыг авчирдаггүй. Эрх мэдэл дайны үед намын давамгайллаас бус том хөрөнгөтнөөс хамаарч байв. Төлөөлөгчийн газруудад арай бага төвшинд замбараагүй

[4] Философийн толь. УБ.,1990. 514-р тал.

байдалд хүрсэн. Улсдаа бүрэн эрх байхгүй гадаадын хүн албан ёсны зөвшөөрөл авахдаа хахууль авах, хөрөнгөтнүүдийн зарим нь албан тушаалаа ашигладаг байв.

Хэрэглэгдэхүүн: 2

...Төлөөлөгчийн газар...Бүх л улс төрийн амьдрал төлөөлөгчдийн газраас хамаарна. Тэнд аль том хөрөнгөтөн том асуудлыг шийддэг. Тиймээс том хөрөнгөтнүүд албан тушаалаа урвуулан ашиглахыг оролддог байсан. Зохицуулан хамгаалах, найр наадамд урих замаар өөрийн ажлаа амжуулдаг. Энэ шалтгаанаас болж язгууртнууд нь төлөөлөгчийн газруудыг худалдан авч байсан байна.

Хэрэглэгдэхүүн: 3

Төлөөлөгчийн газар...энэ нь зөвхөн том хөрөнгөтнүүд сонголтын үр дүнд нөлөөлнө гэдэг нь тодорхой. Тэгэхээр язгууртнуудын дунд хамгийн баян, нөлөө бүхий хөрөнгөтнүүдтэй холбогдож байсан байна. Нөгөө талаар язгууртнууд тэднээс хамгаалалт хүсч байсан байна. Иймээс шийдвэр гаргах эрх мэдэл бүхий төлөөлөгчид хөрөнгөтнүүдийн сонголтоор сонгогддог байна.

Сургалтын арга: Оюуны зураглал, баримттай ажиллах, хүснэгт бөглөх

Хичээлийн явц:

- Сурагчид бүгд найрамдах засгийн онцлогийг оюуны зураглалын аргаар тодорхойлно. Үүний тулд сурагч бүр бүгд найрамдах засагтай улсаас нэрлэж, нэг онцлогийг хэлнэ. Багш самбарт тэмдэглэнэ.
- Хэлэхийг хүссэн бүх хүүхдийг хэлж дууссаны дараа нэгтгэж, бүгд найрамдах улс гэж ямар улс болохыг хамтран тодорхойлно.
- Сурагчдыг гурван хэсэгт хувааж гурван эх сурвалжийг өгнө. Хэсэг тус бүрийн сурагчид эх сурвалжтай танилцаад, бүгд найрамдах улсад ямар нөхцөл байдал үүссэнийг тодорхойлно. Сурагч бүрийн тодорхойлсныг хэсэг дотроо нэгтгэж бусад хэсгүүдэд танилцуулахад бэлтгэнэ.
- Гурван хэсгийн сурагчид бүгд найрамдах улсад үүссэн нөхцөл байдлын тухай тус тусынхаа тодорхойлолтыг танилцуулна.
- Дүгнэлт хийх: Дараах асуултаас ашиглаж дүгнэлтийг хийгээрэй. Үүнд:
    - Бидний жишээгээр авсан бүгд найрамдах улс яагаад унахад хүрсэн бэ?
    - Энэ улсын уналтад нөлөөлсөн хүчин зүйлсийг нэрлэнэ үү.
    - Авлигын хор уршиг хувь хүнд болон улс орон хэрхэн тусч байна вэ?

Авлигын эсрэг ойлголт өгөх боловсролтой холбогдох нь: Авлига нь улс орныг доройтуулаад зогсохгүй улс төр, эдийн засгийн хувьд уналтад оруулдаг.

## СЭДЭВ 8: МОНГОЛ ХУТАГТЫН ДУРТГАЛД АВЛИГЫН ТУХАЙ БИЧСЭН НЬ

Хүлээгдэж буй үр дүн:

- Дилав хутагт Б. Жамсранжавын дуртгалд авлигын тухай хэрхэн бичсэн талаар дүгнэн ярилцах
- Авлигын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар түүхийн эх сурвалжтай ажиллаж, дүн шинжилгээ хийх чадвараа хөгжүүлэх

Холбогдох хичээл: Монголын түүх

Зорилтот бүлэг: 9 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Ярилцлага

Хэрэглэгдэхүүн: Монголын түүх сурах бичиг,
Дилав хутагт Б. Жамсранжав. Ариун сэтгэл-авралын үндэс. (Дуртгал, намтар, өгүүлэл). Хэвлэлд бэлтгэсэн Л. Чойжилсүрэн. УБ.,2000.

"...1914 онд Эрдэнэ шанзав Бадамдоржийг тэргүүн сайд болгов. Бадамдорж Монголын тулгуур төр байгуулах хэрэгт хамгийн тэргүүнд хүчин зүтгэсэн онц гавъяа бүхий бөгөөд Богд хаанд ихэд итгэмжлэгдсэн хүн тул их эрх хүчтэй болов. Түүний чих, нүд болж итгэгдэж байх этгээд нь шалиг самуун явдалтай, ховдог холчиргоны харгайгаар түүний албан явуулах нь зохисгүй зүйл олон болсноос бусад албаны хүмүүс лүгээ нийлэхгүй байсан ба улсын доторх ам хөрөнгийн тоог бүртгэж <u>албан татварыг тэгшитгэх</u> хэмээн сайд Бадамдорж сэдэвлэн гаргасанд олон хошууд үнэн тоог бүрэн өгөхгүйд Дотоод яамнаас заавал үнэнээр мэдүүл хэмээн дахин шаардахад зарим нь мөн сайд Ба(Бадамдорж)-д <u>далдуур дамжуулан</u> <u>тал бэлэг барьж гуйсны</u> тоог худал боловч үнэн болгож тийм явдалгүй болбоос үнэн боловч худал хэмээн чангалан тушаах зэргээс албан гувчуур самуун болсон..."[5]

Хичээлийн явц: Мэдээллийн эх сурвалжтай ажиллах, харьцуулалт хийх, дүн шинжилгээ хийх, багийн хэлэлцүүлэг хийх

Багшийн анхааралд: Энэхүү хичээлийн XX зууны Монголын түүхийн сурвалжуудын нэг болох Дилав хутагт Б.Жамсранжавын "Ар Монголын улс төрийн дуртгал" зохиолын хэсгээс уншиж 2 багт өгөхөд бэлтгэсэн байна.

- Сурагчдыг зохиолын хэсгээс хуваасан хэсгийн тоогоор багт хувааж Бадамдоржийн үеийн Монголын нийгмийн нөхцөл байдлын талаар тайлбарлан ярина.
- Дуртгалын хэсгийг 2 багт өгч дараах даалгаврыг өгнө. Үүнд:
    - Багийн гишүүд оногдсон хэсгийн агуулгыг уншиж Г.Бадамдорж болон түүнийг тойрон хүрээлэгчид, албан татварыг тэгшитгэх, хэн ямар зорилгоор хэнд "далдуур дамжуулан тал бэлэг барьж гуйсан" нь авлигатай ямар уялдаа холбоотой, ямар үр дагаварт хүрснийг тодорхойлж ярилцана.
- Багууд тус тусын саналыг танилцуулах бөгөөд 2 багийн саналыг нэгтгэн бүхэлдээ ямар агуулгатай болсныг багш асууж, хичээлийг дүгнэнэ.

[5] Дилав хутагт Б. Жамсранжав. Ар Монголын улс төрийн дуртгал// Дилав хутагт Б. Жамсранжав. Ариун сэтгэл-авралын үндэс. (Дуртгал, намтар, өгүүлэл). Хэвлэлд бэлтгэсэн Л. Чойжилсүрэн. УБ.,2000.91-92-р тал.

- Дуртгалыг үндэслэн XX зууны эхэн үеийн Монголын түүхэн дэх авлигын илрэлийг тодорхойлох
- Авлигын нөхцөл, шалтгааныг түүхийн бусад жишээтэй харьцуулан ярилцах

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Авлига нь улс орны хөгжил дэвшилд саад бэрхшээл болдог.

## СЭДЭВ 9: ДЭЛХИЙН ХҮЙТЭН ДАЙНЫ ҮЕИЙН ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛС

Хүлээгдэж буй үр дүн:

- Сурагчдын чадавхийг дараах ойлголтуудын хүрээнд хөгжүүлэх:
- Хувьсгалын өөр өөр үеүдэд тулгарч байсан асуудлуудыг харьцуулах
- Сурагчдын гаргасан санаанд тулгуурлан ангилал хийх
- ЗХУ-ын үеийн нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжлийг үнэлж дүгнэх
- Түүхийн үеүдэд гарч байсан авлигатай холбогдох асуудыг тодотгож, авлигын эсрэг чиглэсэн үйл хэрэгт хувь хүний зан байдал, хэв шинжийг тэвчээр, хүлээцтэй байдалтай холбон тайлбарлах

Холбогдох хичээл: Нийгмийн ухаан, шинэ үеийн түүх

Зорилтот бүлэг: 10-11 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Мэдээллийн эх сурвалжтай ажиллах, харьцуулалт хийх, дүн шинжилгээ хийх, багийн хэлэлцүүлэг хийх

Хэрэглэгдэхүүн: Төрийн эрх мэдэл, авлига, хээл хахуулийг харуулсаншог зургууд, Стефан Мерл. “Өнөөгийн Оросын авлига нь Сталины гэрээс үү?” Стефан Мерль.ЗХУ ба Европын түүхэнд холбогдох зарим асуудлууд.УБ., 2009. 71-79-р тал.

Хичээлийн явц:

Энэхүү хичээлийн өмнө Стефан Мерл “Өнөөгийн Оросын авлига нь Сталины гэрээс үү?” судалгааны өгүүллэгийг уншиж утгат хэсгээр нь хуваан багуудад өгөхөд бэлтгэсэн байна.

- Сурагчдыг өгүүллэгийг хуваасан хэсгийн тоогоор багт хувааж нэг, нэг шог зураг өгнө. Багууд шог зургийн агуулгыг тайлбарлан ярина.
- Одоо арай хүнд даалгавар руу орохыг сануулаад судалгааны өгүүллэгийг хэсэг хэсгээр нь тарааж дараах даалгаврыг өгнө. Үүнд:
  - Багийн гишүүн бүр оногдсон хэсгийн агуулгыг уншиж, судлаач ямар асуудал хөндсөн, ямар баримтыг ашигласныг тодорхойлж баг дотроо ярилцана.
  - Баг дотроо ярилцсаны дараа багийн гишүүд босч, өөр багийн хүүхдүүдээс мэдээлэл цуглуулна. Мэдээллийг хангалттай цуглуулсан гэж үзсэн үедээ багаараа эргэн нэгдэж цуглуулсан мэдээллээ нэгтгэнэ.
- Багууд мэдээллээ хэрхэн нэгтгэсэн талаараа тус тус тайлан тавих бөгөөд тэдний мэдээлэл нэгтгэгдсэний дараа бүхэлдээ ямар агуулгатай болсныг багш асууж, хичээлийг дүгнэнэ.

Судалгааны өгүүллийг үндэслэн Зөвлөлт холбоот улсын авлигын илрэлийг тодорхойлох
Авлигын нөхцөл шалтгааныг түүхийн бусад жишээтэй харьцуулан ярилцах

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Түүхийн аль ч үед авлига нь улс орны болон хүн ардын амьдралд хор хохирол учруулдаг.

Нэмэлт мэдээлэл: ЗХУ-ын тухай
Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс буюу Зөвлөлт Холбоот Улс нь 1922 оноос 1991 он хүртэл Евразид оршин тогтносон социалист орон байжээ. ЗХУ нь 15 Бүгд Найрамдах Улс болон хэд хэдэн автономит улс, хязгааруудаас тогтсон холбооны улс байсан. Энэ холбооны улс нь дэлхийн хуурай газрын зургааны нэгийг хамарсан 200 гаруй сая хүн амтай их гүрэн байлаа. ЗХУ нь үзэл суртлын хувьд дэлхийн социалист лагерийн тэргүүлэгч, цэрэг улс төрийн Варшавын гэрээний орнуудын гол хүчин байсан юм. Төвлөрсөн төлөвлөгөөт удирдлагатай, 100 хувь улсын өмчид тулгуурласан хөшүүн хойрго хөрвөх чадваргүй эдийн засагтай байв. Сибирийн нефть, байгалийн хий экспортолж байснаас олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл хөгжсөнгүй. Өргөн хэрэглээний бараа ДНБ-ий бага хувийг эзэлж байв. Хээл хахуульд идэгдсэн, алдар нэр горилогчид эдийн засгийн өндөр өсөлтийн тухай худал мэдээлэл илгээж төр, ард түмнээ хууран мэхэлж байсан байна. Хаалттай нийгэм, дотоодын хамгаалахын хатуу хяналт нь гадаад орнуудтай шинжлэх ухаан технологийн мэдээлэл солилцох, шинэ ололт, нээлтүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бүх боломжийг хаан боогдуулж байлаа.

## СЭДЭВ 10: ХЭЗЭЭ “ҮГҮЙ” ГЭЖ ХЭЛЭХ ВЭ?

Хүлээгдэж буй үр дүн:

“Үгүй” гэж хэлэхийн утга учрыг эргэцүүлэх,
Шаардлагатай үед “үгүй” гэж хэлж сурах

Хичээлийн нэр: Иргэний боловсрол

Зорилтот бүлэг: 8-9 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Цуглуулгын болон дүрийн тоглолтын арга

Хичээлийн явц: 1. Хүүхэд бүр өөрийн амьдралд тохиолдсон “Үгүй” гэж хэлсэн баримтыг хэлэх, багш том цаасан дээр тэмдэглэх
2. Тэмдэглэлээ ашиглан баримтуудыг төсөөтэй байдлаар нь хамтран ангилах
3. Дараах асуултын дагуу ярилцах:
Бид ямар тохиолдлуудад ихэвчлэн “үгүй” гэж хэлдэг вэ?
“Үгүй” гэж хэлэх амархан уу, яагаад?
Бид ямар тохиолдолд “үгүй” гэж хэлж болохгүй вэ? “Үгүй” гэж хэлж болохгүй тохиолдолд хэлснээс ямар үр дагавар үүсч болох вэ?
Эсрэгээр нь бид ямар тохиолдолд “үгүй” гэж хэлэх зайлшгүй шаардлагатай вэ? “Үгүй” гэж хэлэх ёстой тохиолдолд хэлж чадаагүйгээс болж ямар үр дагавар үүсч болох вэ?

Дүрийн тоглолт хийгээрэй:

Суралцагчид 5-6 сурагчаас бүрдсэн 5 бүлэгт хуваагдаж, дараах даалгаврыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Бүлэг тус бүр авлига, хээл хахууль зэрэгтэй холбогдох өөрсдийн мэдэх тохиолдол, хэвлэлийн мэдээ зэрэг тохиолдлуудыг цуглуулна.
- Бүлэг тус бүр өөрийн сонгосон тохиолдлуудад шинжилгээ хийж, бусад багийнхандаа "Бид авлигад ҮГҮЙ гэж хэлнэ" хэмээх дүрийн тоглолт бэлтгэнэ.
- Бүлэг тус бүр өөрсдийн дүрийн тоглолтоо бусад багуудад танилцуулна.

Жишээ: Бид математикийн анги дэвших шалгалт өгөх хариуцлагатай цаг үе болсон байна. Хэдийгээр энэ богино хугацаанд энэ шалгалтад амжилттай бэлтгэх хугацаа бага байна. Иймээс шалгалтын зөвлөлийнхөнд бэлэг авч өгье гэсэн санал зарим хүүхдээс гарлаа. Гэхдээ бидний эцсийн санал бол "Энэ бол хээл хахууль болно. Тиймээс бид санал нэгтэйгээр "Үгүй" гэж хэлнэ.

"Үгүй" хэмээн хэлэх нь тухайн нөхцөл байдлаас хамааран олон утга, агуулга болон үр дагавартай байдаг. Тухайлбал үүнд хоёр үндсэн ялгаатай байр суурь байна.

Нэгдүгээрт: "Үгүй" хэмээх байр суурьтай байх  Энэ нь тухайн хүн бусдын үзэл бодол, үйл хөдөлгөөн, хийж буй зүйлтэй санал нийлэхгүй байх, түүнээс өөр арга зам, шийдлээр хэрэгжүүлэх саналтай байх явдал юм. "Үгүй" хэмээн хэлэх нь бидний өдөр тутмын амьдралд байнга давтагдаж байдаг хэвийн үзэгдэл бөгөөд энэ нь тухайн хүний хувийн хүсэл сонирхол, мэдлэг туршлага, тухайн үеийн зан байдал зэргээс ихээхэн хамааралтай байдаг.

Хоёрдугаарт: "Үгүй, ингэж болохгүй"  хэмээх татгалзал, хориглолт хийх   Энэ нь өмнөх тохиолдолтой харьцуулахад илүү учир шалтгаан, шударга ёсны зарчимд үндэслэсэн бөгөөд аливаа буруу, шударга бус үзэгдэл, тохиолдолтой эвлэрэхгүй байх, түүнийг үл хүлцэх хандлагын илэрхийлэл юм. Авлига, ялгаварлан гадуурхах, бусдын нэр хүндэд халдах зэрэг шударга бус зүйл, ёс суртахуунлаг бус зүйлд бид ямагт "Үгүй" гэж эрс шийдэмгий хэлж сурах ёстой.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Бид авлигын эсрэг өөрсдийн болон бусдын байр суурийг тодорхой болгох хэрэгтэй. Бид авлигад "үгүй" гэж хэлж сурсан байх шаардлагатай.
Эх сурвалж: http://wikipedia.org/wiki/

## СЭДЭВ 11:  ИРГЭНИЙ ЭРХЭМ ЧАНАРУУД

Хүлээгдэж буй үр дүн:

- Иргэний даган мөрдвөл зохих үнэт чанаруудын талаар тодорхой ойлголт авч, өөрийн итгэл үнэмшил, үнэт зүйлсийг бүрдүүлэх
- Улмаар иргэн бүр эдгээр үнэт чанаруудыг өөртөө тусган хэрэгжүүлснээр ардчилсан, иргэний оролцоот нийгмийг бүрдүүлэх

| | |
|---|---|
| Холбогдох хичээл: | Иргэний боловсрол хичээлийн "Иргэний үнэт чанар" бүлэг сэдвийн хүрээнд |
| Зорилтот бүлэг: | 8-9 дүгээр ангийн сурагчид |
| Хэрэглэгдэхүүн: | Доорх эхийг суралцагчдад тарааж өгнө. |

Аливаа иргэн нь нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, эх орны хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрийг оруулах шаардлагатай. Иргэд өөрийн болон бусдын өмнө тодорхой үүрэг хариуцлага хүлээдэг. Мөн иргэн нь тухайн нийгэм дэх хууль, дэг журам, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэн, ардчилсан зарчим, дэг журмыг зөвшөөрөн дэмжих ёстой. Үүний тулд иргэн хүний даган мөрдвөл зохих хэд хэдэн үнэт чанарууд байдаг. Эдгээр нь:

Өөрийн итгэл үнэмшил, үнэт зүйлстэй байх

Нийгмийн амьдралд идэвхтэй оролцох

Байнга суралцан хөгжихөд эрмэлзэх

Мэдээллийг хайх, хүлээн авах, боловсруулах эрмэлзэлтэй байх зэрэг болно.

Хэрвээ иргэн бүр эдгээр үнэт чанаруудыг хэрэгжүүлж чадваас ардчилсан, иргэний оролцоот нийгэм бий болно.

Өөрийн итгэл үнэмшил, үнэт зүйлстэй байх

Дээр дурдсан эрхэм чанарууд нь бүхэлдээ үнэт зүйлсээр тодорхойлогддог. Үнэт зүйлс гэдэг нь бид аливаа харилцаанд оролцохдоо даган баримжаалж буй итгэл үнэмшлийн цогц юм. Үнэт зүйлс өргөн утгатай ойлголт бөгөөд мөн олон хэлбэртэй байдаг. Иймд хувь хүн, гэр бүл, улс орон зэрэгт олон төрлийн үнэт зүйлс зэрэгцэн оршдог. Үнэт зүйлс нь зорилго тавих, сонголт хийх үндэс нь болдог бөгөөд сайн сайхны төлөөх бидний эрэл хайгуул юм. Үнэт зүйлс нь хүн бүрд байх боловч түвшний ялгаатай байдаг. Эдгээрийг хувь хүний, гэр бүлийн, нийгмийн үнэт зүйлс хэмээн ангилж болно.

Сургалтын арга: Нээлттэй хэлэлцүүлэг

Хичээлийн явц: Эргэцүүлэн хэлэлцээрэй: Та бүхний хэлэлцүүлэгт доорх асуултууд хөтөч болно.

Иргэн хүний эрхэм чанарууд юу вэ?

Таны хувьд иргэн хүн юуг хийж чаддаг байх нь чухал вэ?

Өөрийн итгэл үнэмшил, үнэт зүйлстэй байх нь яагаад чухал вэ?

Та нарт ямар ямар үнэт зүйлс байдаг вэ?

Доорх хүснэгтэд үнэт зүйлсийн зарим нэгэн жишээг харуулав. Эдгээр нь зарим хүмүүсийн хувьд эрхэм үнэ цэнэтэй зүйл болдог. Харин та нарын хувьд ямар байдаг вэ? Эдгээр үнэт зүйлсийн жишээг хувийн, гэр бүлийн, нийгмийн хэмээн ялган зохих баганад төрөлжүүлэн бичээрэй.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Хүмүүсийн хувьд юуг чухал, эрхэм хэмээн бодож байна, тэр зүйл нь итгэл үнэмшил болон тогтоно. Тиймээс бид өөртөө хэрэгцээтэй, чухал, ач холбогдолтой зүйлсэд итгэдэг. Иргэд нийгмийн тэгш байдал, шударга ёсыг эрхэмлэн, итгэл үнэмшлээ болгох нь нийгэм зүй ёсны дагуу хөгжин дэвжих үндэс болно. Тиймээс шударга ёс, тэгш байдал, хүний эрх зэргийг өөрийн итгэл үнэмшлээ болгож, тэдгээрийг нийгэмдээ хэрэгжүүлэхийн төлөө өөртөө зорилго тавьж, хичээн ажиллах нь зүйтэй.

## СЭДЭВ 12: АЖИЛД АВАХАД ЮУГ ГОЛ ШАЛГУУР БОЛГОДОГ ВЭ?

Хүлээгдэж буй үр дүн:

- Нийгмийн харилцааны явц дахь материаллаг зүйлс болон хүний үнэт чанарын талаарх жишээ баримтуудыг ялган зааглаж, шударга ёсны тухай өөрийн гэсэн үнэт зүйлсийн баримжаатай болох
- Нийгэм дэх хувь хүний, гэр бүлийн болон байгууллагын үнэт зүйлсийн талаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх, шударга ёсны үнэт зүйлсийг хамгаалах чадвараа хөгжүүлэх.

Холбогдох хичээл: Нийгэм судлал, хөдөлмөрийн эрх зүй

Зорилтот бүлэг: 8-9 дүгээр ангийн суралцагчид

Сургалтын арга: Харьцуулалт хийх, бүлгээр ажиллах, хэлэлцүүлэг

Хэрэглэгдэхүүн: Тохиолдол: “Ажилд орсон нь”

Энэ явдал 19 дүгээр зууны эхний хагаст нэгэн улсад болжээ. Нэгэн хүн цахилгаан холбооны газар ажилтан авна гэсэн зарын дагуу ажилд орохоор иржээ. Тэрхүү газар жижигхэн албан байгууллага боловч маш чимээ шуугиантай газар байжээ. Тэрээр ирмэгц өөрийн ажилд орох хүсэлтээ бөглөж өгөөд түүнээс өмнө ирсэн 4 хүний дараа дараallaa хүлээн зогслоо.

Удалгүй, ердөө 2 минутын дараа тэрээр дараалан зогссон хүмүүсийн урдуур гарч, менежерийн өрөөнд орлоо. Тун удалгүй менежер өрөөнөөсөө гарч ирээд, ажилд авах хүнээ нэгэнт сонгосон тул бусад хүмүүсийг ярилцлагад орох шаардлагагүй гэж хэлэв.. Үүнийг сонсоод ажилд орох болсон хүнээс түрүүнд ирсэн хүмүүс гомдолтой байгаагаа илэрхийлжяагаад уг хүнийг сонгох болсноо тайлбарлахыг менежерээс шаардлаа.

Менежер тэдгээр хүмүүст өөрийн шийдвэрийг хэрхэн танилцуулах вэ?

Хичээлийн явц:

- Багш суралцагчдад “Ажилд орсон нь” хэмээх тохиолдлыг тарааж өгөх буюу чангаар уншиж өгнө.
- Сурагчдаас тухайн тохиолдлын талаар нэмж лавлах, тодруулах зүйл байвал асуулт хариултын 5-8 минут төлөвлөнө.
- Багш тухайн асуултад Тийм – Үгүй, Зөв – Буруу гэж хариулах бөгөөд зарим үед тодруулж буй зүйл уг асуудалд хамаатай эсэх, чухал эсэх талаар товч хариулж болно.
- Сурагчид тухайн тохиолдолд ямар учир шалтгаантай болохыг үнэн зөв таахыг хичээнэ.
- Хэрвээ сурагчдын хувьд асуулт хариулт олон дахин давтагдвал дараах нэмэлт тайлбар өгч болно. Үүнд:
  - Нас хүйс, хувцаслалт, тухайн хүний шинж байдал огт хамаагүй.
  - Бүх ажил хайгчид материалаа бүрэн гүйцэд өгсөн байсан.
  - Ажил олгогч тэдгээрийг хэнийг нь ч өмнө нь таньдаггүй байсан.
- Сурагчид бүх гарч буй таамаглалыг самбар дээр жагсаан бичнэ.
- Эцэст нь ангиараа дараах асуултын дагуу хэлэлцэнэ.
  - Ямар шалтгаан хамгийн олон удаа дурдагдсан бэ?
  - Тухайн ажил олгогч уг хүнээс хээл хахууль авсан болон шударга бусаар хандсанбайж болох магадлал хэр байна вэ?
  - Хэрвээ ажил олгогч нь та нар байсан бол хэрхэн яаж шалгаруулж авах байсан бэ?

Сурагчид дараах хүснэгтийг тус бүрдээ бөглөж, өөрсдийн дүн шинжилгээг бусаддаа танилцуулна.

| Ажил олгогчид дараах шинж байдлаар хүмүүсийг ажилд авдаг гэж мэддэг\сонсчбайсан. | Хэрвээ би ажил олгогч бол дараах чадвар дадал бүхий хүмүүсийг ажилд авна. | Хэрвээ би ажил хайгч бол өөрийн хүссэн ажилдаа орохын тулд дараах зүйлд анхаарна. |
|---|---|---|
| ..........<br>..........<br>.......... | ..........<br>..........<br>.......... | ..........<br>..........<br>.......... |

Сурагчид бусдынхаа хариултыг сонссоны дараа дараах асуултуудын дагуу дахин хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Төрийн байгууллагад ажилтан авахад ямар дүрэм журам үйлчилдэг вэ?

Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага ажилтан авах үйл ажиллагаанд ямар ялгаа байдаг вэ? Хэрвээ байдаг бол яагаад?

Төрийн албан хаагчдыг зөв шалгаруулан авахын тулд хэн , юу хийх ёстой вэ?

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Төрийн байгууллагад ажилд орохыг олон хүн хүсдэг. Гэхдээ төрийн байгууллагын ажилтан авах үйл явц нь нам, улс төрчдийн оролцоогүйгээр хуулийн дагуу, шударгаар явагддаг гэдэгт олон хүн эргэлздэг. Тиймээс сурагчдын хувьд энэ асуудлын талаар сайтар судалж, өөрсдийн мэдлэг ойлголтоо илэрхийлэх нь нийгэм дэх шударга ёс, иргэний оролцоо, ардчиллын үнэт зүйлсийг хамгаалж сурахад нь туслах болно.

Нэмэлт мэдээлэл:

Хариулт: Тухайн цахилгаан холбооны газар телеграфч буюу мэдээлэл хүлээн авах, дамжуулах ажилтан авахаар зарлажээ. Иймд менежер өрөөнийхөө гадаа зогсч буй хүмүүст хандан ярилцах урилгыг тухайн ажлын гол технологи болох Морзын үсгээр (цэг ба зураасан код) уншиж байжээ. Үүнийг ганцхан тэрхүү хүн ойлгож, ярилцлагад орсон байна.

## СЭДЭВ 13: МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭ

Хүлээгдэж буй үр дүн:

Нийгмийн харилцааны явц дахь материаллаг зүйлс болон хүний үнэт чанарын талаарх жишээ баримтуудыг ялган зааглаж, шударга ёсны тухай өөрийн гэсэн үнэт зүйлсийн баримжаатай болох

Нийгэм дэх хувь хүний, гэр бүлийн болон байгууллагын үнэт зүйлсийн талаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх, шударга ёсны үнэт зүйлсийг хамгаалах чадвараа хөгжүүлэх.

Холбогдох хичээл: Иргэний боловсрол

Зорилтот бүлэг: 10 дугаар ангийн суралцагчид

Сургалтын арга: Тохиолдол шинжлэх, бүлгээр ажиллах, хэлэлцүүлэг

Хэрэглэгдэхүүн: "Нэг зоосон мөнгө" тохиолдол

Нэгэн чинээлэг хүн өөрөө их ажилч хичээнгүй боловч ажил хийдэггүй залхуу хүүхэдтэй байж гэнэ. Тэрээр хүүгээ ажил хөдөлмөр хийж сургахаар шийдэж, нэгэн өглөө хүүгээ дуудаад "Гадагш гарч өөрийнхөө хүч хөдөлмөрөөр нэг зоос олж ир" гэжээ. Тэр өдөр нь залхуу хүү яаж нэг зоос олъё доо хэмээн бодсоор суутал өдөр өнгөрч аргагүйн эрхэнд гэртээ ирлээ. Тэрээр аавaасаа айж, юу хийхээ мэдэхгүй байсан тул ээж нь түүнд ааваас нь нуун нэг зоос өгчээ. Орой нь хүүгээсээ мөнгө авсан аав нь "Энэ чиний өөрөө хөдөлмөрлөж олсон зоос биш байна" гээд зуух уруу шидээд хайлуулж орхижээ. Дараа өдөр мөн л ээж нь зоосон мөнгө өгсөн боловч аав нь бас л  зуух уруу шидчихжээ. Гурав дахь удаад ээж нь өөрийнхөө бурууг ухаарч, хүүдээ ажил хийж мөнгө олох боломж олгов.

Тэр арга буюу гадагш гарч, өдөржингөө хүнд хүчир ажил хийж нэг зоос олоод маш бахдалтай эргэж ирэв. Гэтэл аав нь бас л "Энэ чиний олсон мөнгө биш байна" гээд гал уруу чулуудчихжээ. Хүү яаран зуух уруу гараа хийн зоосоо аваад

- Аав аа! Энэ зоосыг олох гэж хичнээн зовсон болохыг та мэдэж байна уу? гэхэд
- Энэ удаа  ч өөрөө хөдөлмөрлөж олсон нь гарцаагүй үнэн байнаа гэж аав нь хэлээд, таатайхан инээмсэглээд өөрийнхөө эд хөрөнгийг хүүдээ өвлүүлжээ.

Хичээлийн явц:

Багш суралцагчдад "Нэг зоосон мөнгө" хэмээх тохиолдлыг тарааж өгөх буюу чангаар уншиж өгнө.

Сурагчид тухайн тохиолдолд гарч буй үйл явдал, гэр бүлийн гишүүдийн үүрэг оролцооны талаар дараах асуултуудын дагуу хэлэлцэнэ.

Энэхүү тохиолдлоос та нар юуг ойлгож авсан бэ?

Бусдын зүгээр өгсөн болон өөрөө хөдөлмөрлөж олсон мөнгөний үнэ цэнэ яагаад өөр байсан бэ?

"Мөнгийг олох хэцүү, харин үрэх амархан гэж хүмүүс ярьдаг". Энэ үнэн үү? Үүний адилаар шударга бус байдлаар, бусдаас зүгээр авсан мөнгө энэ нэг зоостой адил үнэ цэнэ хүрэх үү

Төсөв яагаад ил тод байх ёстой вэ?

Хувь хүн, айл өрх, байгууллага бүхэн өөрийн гэсэн төсөв, мөнгөн хөрөнгөтэй бөгөөд түүнийгээ үр дүнтэй захиран зарцуулахыг хүсдэг. Үүний адилаар улс орон бүр өөрийн гэсэн мөнгөн сантай байх ба үүнийг бид төсөв хэмээн нэрлэдэг. Төсөв нь татвар төлөгч иргэд, байгууллагуудаас мөнгө хураан бүрдүүлж, улмаар нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэээр зарцуулдаг төрийн мөнгөн хөрөнгийн төвлөрсөн сан юм. Төсөвөн хөрөнгийн төвлөрсөн сан юм.өсөв хэмээн нэрлэ

амын амьдралыг дээшлүүлэх, хөдөө орон нутгийг хөгжүүлэх зэрэг нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилготой.

Иргэн хүн эрхээ эдлэхийн хамт төрдөө татвар төлөх үүрэг хүлээдэг. Татвар бол төр үйл ажиллагаа явуулах гол эх үүсвэр болдог. Гэхдээ энэ нь иргэдийн болон нийгмийн сайн сайхан байдлыг хангах зорилготой байдаг. Гэтэл төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, ашиглан шамшигдуулах зэрэг гэмт хэрэг гарах нь бий. Хэрвээ төсвийн хөрөнгийг үр дүнтэй, зохистой зарцуулахгүй бол зам тавих, гүүр босгох, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сургууль байгуулах, нийгмийн хэв журмыг сахиулах зэрэг нийтийн сайн сайхны төлөө зориулагдах мөнгийг алдаж байна гэсэн үг.

Иймд төр нь төсвийн мөнгөн сангийн бүрдэлт, ашиглалтыг иргэдэд ойлгомжтой тайлагнаж, үр ашигтай төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт, хяналтын систем бүрдүүлэх үүргийг хүлээдэг. Үүнийг төсвийн ил тод байдал гэдэг. Нөгөө талаас иргэн бүр улсын төсвийг хэрхэн бүрдүүлж, юунд зарцуулж байгаа талаар хяналт тавьж хэвших шаардлагатай. Энэ шаардлагыг хангахын тулд хүн бүр мөнгөний үнэ цэнийг мэдэрч, түүнийг үр дүнтэй зарцуулж сурах ёстой.

Хувь хүн, гэр бүл, сургууль, байгууллага, засгийн газар зэрэг нь бүгд өөр өөрийн төсөвтэй байна. Нэгэнт төсөв учраас ерөнхий зарчим нь гэр бүлд, сургуульд, засгийн газарт мөн адил байна. Хэрвээ хүүхдүүд мөнгөний үнэ цэнийг зөв ойлгож чадахгүй бол бие даан худалдаа хийх, мөнгөө төлөвлөх, тооцоо хийх чадварт суралцаж чадахгүй. Учир нь мөнгөтэй хэрхэн харьцах, түүнийг хэрхэн бий болгох, зарцуулах зэрэг нь зохих тооцоо шаарддаг. Өөрөөр хэлбэл мөнгөтэй хэрхэн харьцах арга ухааныг бид энгийнээр “төсөв” хэмээн нэрлэдэг. Төсөв гэдэг нь өөрт байгаа мөнгийг зарцуулах буюу хадгалахад зориулагдсан нэгэн төрөл төлөвлөгөө юм. Төсвийн тухай мэддэг болох нь өөрийн мөнгөө хэрхэн үр ашигтай зарцуулах арга ухаанд сургадаг.

Аливаа төсвийн орлого нь зарлага хоёр нь яг тохирч байх нь сайн хэрэг. Мөн орлого нь зарлагаасаа илүү буюу үлдэгдэлтэй байвал бүр сайн. Төсвөөс тодорхой хэмжээний мөнгө хэмнэгдэж байна. Тэрхүү хэмнэсэн мөнгөөрөө өөртөө хэрэгтэй зүйлийг худалдан авч болно. Үүнийг хөрөнгө оруулалт хийх гэж нэрлэдэг.

Иймээс хүн бүхэн өөрсдийн төсвийг зохион хэрэглэж хэвших нь мөнгийг үр дүнтэй зарцуулах гол арга зам болно. Энд нэгэн хүүхдийн төсвийн загвар байна. Энэ загварыг долоо хоногоор болон сараар хийж болно. Мөн энэ загварыг ашиглан та нар тус бүр өөрсдийн төсвийг хийж хэвшээрэй. Уг загварыг та нар шинээр зохиож болно гэдгийг анхаараарай.

Мөнгөтэй ухаалаг харьцахад дараах дүрмийг мөрдөнө.

Мөнгөө ямагт үр ашигтай зүйлд зарцуулах
Чухал биш зүйлд зарцуулах зардлыг бууруулах
Хэмнэсэн мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийх.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Мөнгөний үнэ цэнэ, татвар болон төсвийн ил тод байдал хэмээх ойлголтуудтай танилцсанаар эдийн засгийн үндсэн ойлголттой, улмаар улсын төсвийн нээлттэй, ил тод байдалд оролцох, хяналт тавих иргэний чадварыг эзэмших үндэс болно. Улмаар энэ нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах, завших гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.

СЭДЭВ 14: АВЛИГЫГ ТҮЛХҮҮР ҮГСЭЭР ТОДОРХОЙЛОХ НЬ

Хүлээгдэж буй үр дүн:

Ижил утгатай зүйлүүдийг ангилж, бүлэглэх, нийгмийн харилцаа, үзэгдлүүдийн хоорондын далд холбоог илрүүлэн дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэх

Холбогдох хичээл: Нийгмийн ухаан

Зорилтот бүлэг: 8-9 дүгээр ангийн сурагчид

Сургалтын арга зүй: KEYS буюу түлхүүр арга

Хичээлийн явц:

Багшийн тайлбар: Самбарт томоор “KEYS” буюу түлхүүр гэдэг үгийн үсгийг салгаж бичнэ.

K- ижил утгатай үгсийг бүлэглэх
E- ангилах
Y-бүлэг ба дэд бүлгүүдийг зураглах
S-холбоос бий болгох

Дүгнэлт хийх зорилгоор үг, өгүүлбэр бүрийг тэрчлэн зарим санааг нэгтгэж бүлэг болгоход энэхүү аргыг бид ашиглана гэдгийг танилцуулна.

Авлига гэсэн түлхүүр үгнээс бүлэг үүсгэхийн тулд дээрх зургийг самбарт өлгөнө. Ижил утгатай үгсийг дугуйн гаднах цацрагууд дээр бичнэ. Аль болох олон үг бичнэ. Зөв зүйтэй хариулт гэж энд байхгүй санаанд орсныг бичнэ.

Дараа нь эдгээр үгүүдийг ангилна. Ангилал хийхдээ ижил төстэйгээр нь хооронд нь зураасаар холбоно.

Жишээ нь: Шагнал, урамшил, баярлах
Бялдуучлал, зусардалт
Хахууль, гар хүндрүүлэх г.м.

Эндээс дэд бүлэг үүсгэнэ. Жишээ нь:

Шан харамж
Шударга бус байдал
Гэмт хэрэг

Дараа нь шүүн хэлэлцэнэ. Ингэхдээ дараах асуултыг ашиглаж болох юм. Үүнд:

Ямар үгсийг багцлахад бэрхшээлтэй байсан бэ?
Бэрхшээлийг хэрхэн даван туулсан бэ?
Багцалсны дараа ямар дүрмээр ангилал хийсэн бэ?

Багшийн анхааралд:

Энэ аргыг сурагчдад дутуу мэдээлэл өгч гүйцээлгэхэд мөн ашиглаж болно.

Авлигын гэмт хэрэг нь олон төрөл хэлбэрүүдийг агуулдаг. Үүнд нийтийн өмч хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн албан хаагч хууль бусаар хөрөнгөжих, үндэслэлгүй хүнд суртал гаргаж үйлчлүүлэгчийг чирэгдүүлэх, хууль бус давуу байдал олж авах, бусдад олгох,

хууль бус бэлэг, шан харамж авах гэсэн эрх зүйн зөрчлүүд орно. Харин түгээмэл тархсан хэлбэрүүд нь хууль бусаар гадаадад мөнгө шилжүүлэх, хөрөнгө эзэмших, хил давуулж хориотой наймаа хийх, төрийн өмчийг завших, хуурамч зүйл үйлдвэрлэх, дансны аргаар мөнгө идэх, өмч хөрөнгийг зүй бусаар зарцуулах, эх орноосоо урвах, төрд тэрслэх, эрх мэдлээ урвуулан ашиглах зэрэг болно.

Олон улсын хэмжээнд галт зэвсэг, хар тамхины хууль бус наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэг, алан хядах ажиллагаа, хүний наймаа, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэл зэрэг нь “авлига”-тай шууд холбоотой байдаг байна. Учир нь энэ төрлийн гэмт хэрэг, үйлдлүүд нь бүгд хууль тогтоомжоор хориглогдсон байдаг. Тиймээс энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж буй буй хүмүүс, бүлэглэлүүд нь хууль хяналтын байгууллага, ажилтнуудыг өөрсдийн ашиг хонжоо олох үйл ажиллагаанд ашиглах, авлига, хээл хахууль өгөхийг оролдож байдаг. Тиймээс эдгээр гэмт хэргийг таслан зогсооход нийт иргэдийн хамтын ажиллагаа, шударга ёс журам чухал үүрэгтэй

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Энэ хичээлийн хүрээнд авлига нь дан ганц мөнгө өгөх, авах төдий үйлдэл биш болохыг ойлгож, түүний учир шалтгаан, нийгэмд үзүүлэх хор хөнөөлийн талаар ерөнхий ойлголт өгөхийг зорилоо. Иргэд авлигын талаар үнэн зөв мэдээлэлтэй болж чадвал авлигын гэмт хэрэг үйлдэхэд түлхэж буйг ойлгох, татгалзах, улмаар илрүүлэх, сэргийлэх арга хэмжээг авах боломжтой болно.

## НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ – АВЛИГА БА ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

2006 онд батлагдсан Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлд авлига, ашиг хонжоо, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох зэрэг бүхий л хүрээ, хэлбэрүүдийг нэгтгэн тодорхойлжээ. Энэ нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дээрх ойлголттой агуулгын хувьд ижил төстэй байна.

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“авлига” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

3.1.2.“ашиг хонжоо” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.3.“албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

3.1.4.“давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

Эх сурвалж: Авлигын эсрэг хууль, 2006 он www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=7794

## СЭДЭВ 15: ТАСЫН ГОЁЛ БА ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ

Хүлээгдэж буй үр дүн:

Төрийн эрх мэдлийн эх сурвалж нь түүнийг сонгосон иргэд болохыг ухаарч ойлгох;

Шударга бус үйлдлийг таслан зогсоох арга замыг олж харах, хэрэгжүүлэх ур чадвараа хөгжүүлэх;

Хичээлийн нэр: Нийгмийн ухааны хичээлийн “Улс төрийн засаглал ба эрх мэдэл”, “Ардчиллын үнэт зүйлс” сэдвийн хүрээнд

Зорилтот бүлэг: 10-11 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Ярилцлага

Хэрэглэгдэхүүн 1: О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг нар., Нийгмийн ухаан X-XI, УБ., 2010., 112-114,169-174 тал

Хэрэглэгдэхүүн 2: Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг, УБ., 2008, 31-34 дэх талууд, 168-179 дэх тал

Хэрэглэгдэхүүн 3:

### Тас яагаад нүцгэн болсон бэ? /үлгэр/

Эрт урьд цагт тас гэдэг номхон зантай шувуу байжээ. Тэр гоц гоё өд сөдгүй ч сайхан шувуу байв. Гэтэл түүний өд сөд зулгаран унаж, тас санаа зовсоор удалгүй хүндээр өвджээ. Бусад шувууд тасыг өрөвдөн өөрсдийн өднөөс нэг, нэгийг авч өгөхөөр шийдэж гэнэ. Шувуу бүр нэг өдөө сугалан өгснөөр тасын өд нь янз бүрийн өнгөөр солонгорон маш гоё харагдах болов.
Тас тэр дороо омогшин, бусдын өдөөр гайхуулан явах боллоо. Сүүлдээ бүр “Энэ дэлхий дээр надаас сайхан шувуу байхгүй” гэж сайрхах ч болов.

Өдөр, хоног өнгөрөх тусам тасын омог бардам зан нэмэгдсээр бүр даварч “Би шувууд та нарын хаан болно” гэж хашгирч гэнэ. Ийм дээрэнгүй үгийг сонссон шувууд өөрсдийн өөрсдийн өгсөн өдийг байтугай өөрийнх нь үлдсэн жаахан өдийг ч зулгаагаад хаячихаж гэнэ. Түүнээс хойш тас нүцгэн, үзэмжгүй шувуу болсон юмсанжээ.

Хичээлийн явц:
Төрийн эрх мэдэлтэй холбоотой дараах асуултуудыг ашиглан ярилцах:

- Төрийн эрх мэдэл гэж юу болох, төрд ямар эрх мэдэл байдаг талаар
- Төрийн эрх мэдлийн эх сурвалж юу вэ? Төр ямар замаар эрх мэдэлтэй болсон бэ?
- Төрийн эрх мэдэл хязгаартай эсэх, хэн, хэрхэн хязгаарладаг вэ?
- Төр өөртөө байгаа эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашигладаг эсэх, тэр нь хэрхэн илэрдэг талаар

Тас яагаад нүцгэн болсон бэ? үлгэрийг уншаад төрийн эрх мэдэлтэй яагаад холбосныг тайлбарлаарай.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Авлигатай холбогдсон төрийн албан тушаалтанд арга хэмжээ авч, хариуцлага тооцох нь нийгэмд шударга ёсыг тогтоох нэг хүчин зүйл болно. Төрийн эрх мэдэл хязгааргүй зүйл биш бөгөөд сонгогч олон түмэнд түүнд эрх мэдэл өгсөн шигээ эрх мэдлийг эргүүлэн авч болно.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ – ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Монгол Улсад эдүгээ 148.223 төрийн албан хаагч ажиллаж байна. Төрийн албанд орохоор мэргэшлийн шалгалт өгч байгаа иргэдийн тоо өсч, одоогийн байдлаар нэг орон тоон дээр 4-5 хүн өрсөлдөж байна.

Төрийн албан хаагчид авлига авч, хүнд суртал гаргадаг, цалин хангамжтай нь харьцуулахад хэт тансаг хэрэглээ, өндөр зардалтай байгаа талаар шүүмжлэл цөөнгүй ажиглагдаж байна. Манай улсын Авлигын индексийн 2009 оны үр дүнгээр олон нийт болон шинжээчид Монгол Улсад авлига түгээмэл байна гээд тэдний 13 хувь нь гэр бүлийн зүгээс төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэжээ. Төрийн албан хаагчдад өгсөн энэ авлигын хэмжээ нь жилийн өрхийн орлогын 14.6 хувь буюу 240.8 мянган төгрөг байгаа бөгөөд тооцож үзвэл сүүлийн 12 сарын хугацаанд иргэдээс 21.7 тэрбум төгрөгийн хээл хахуулийг төрийн албан хаагчдад өгсөн байна[6].

Төрийн албан хаагчдад авлига болон очсон энэ мөнгө нь манай дундаж амьдралтай 4921 өрхийн бүтэн жилийн хэрэгцээг хангах мөнгөтэй тэнцэх юм. Нэг орон сууцны дундаж үнийг 40 сая төгрөгөөр тооцвол энэ нь 540 айлыг орон сууцтай болгох хэмжээний мөнгө болж байна.

Эх сурвалж: tusuv.files.wordpress.com

[6] МУ-ын Авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүн. АТГ-ын “Шударга ёс” сэтгүүл. №1., 2010 он

СЭДЭВ 16 : ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Хүлээгдэж буй үр дүн:

- Төрийн байгууллагын ил тод байдлын талаар мэдэж, түүний үйл ажиллагааны хамрах хүрээний талаар дүгнэн ярилцах
- Ил тод байдлын ойлголт, иргэдийн мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөөний ач холбогдлын талаарх эх сурвалжтай ажиллаж, үйл ажиллагаанд хамрагдах чадвараа хөгжүүлэх

Холбогдох хичээл: Иргэний боловсрол

Зорилтот бүлэг: 10-11 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Ярилцлага

Хэрэглэгдэхүүн: Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2006.74, 115 дахь тал.

Хичээлийн явц:

Төрийн байгууллагын ил тод байдлын талаар дараах асуултуудыг ашиглан 3 багт хуваарилан ярилцах:

- Тунгалаг байдал гэж юу вэ?
- Мэдээллийн эрх чөлөөний ач холбогдол
- Мэдээллийн эх сурвалжийг яагаад хамгаалах шаардлагатай вэ?

Багууд тус тусын саналыг танилцуулах бөгөөд 3 багийн саналыг нэгтгэн бүхэлдээ ямар агуулгатай болсныг багш асууж, хичээлийг дүгнэнэ.

Гол ойлголт: Мэдээллийг чөлөөтэй хуваалцах үйл ажиллагаа нээлттэй байхыг тунгалаг байдал гэдэг. Тунгалаг байдал нь албан тушаалтан эрх мэдлээ зүй бусаар ашигласан тохиолдлыг илрүүлэх, эрх ашгаа хамгаалахад олон нийтэд чухал ач холбогдолтой мэдээллийг олж авах боломжийг олгодог. Тунгалаг байдал нь олон нийтийн оролцоотойгоор шийдвэр гаргах, олон нийт ба албан тушаалтны хооронд харилцах нээлттэй суваг бий болгох, өргөн хүрээтэй мэдээллийг хүртээмжтэй байлгах нөхцөлийг бүрдүүлдэг. Мэдээллийн чөлөөтэй урсгалд тулгуурлана. Тухайн үйл явц, байгууллагын талаарх мэдээллийг тэдгээрт хамаатай хүмүүс чөлөөтэй авах боломжтой, тэдгээр үйл явцыг ойлгох, хянахад хангалттай байх ёстой.

Ардчилсан нийгмийн иргэн хүн өөрийн үзэл бодол итгэл үнэмшилтэй байх эрхээ эдлэх нь мэдээллийн эрх чөлөөтэй шууд холбоотой. Мэдээллийн эрх чөлөө гэдэгт хоорондоо нягт холбоотой бүлэг эрх, эрх чөлөөг хамруулан ойлгодог. Ардчиллын бэхжүүлэхэд мэдээллийн эрх чөлөө хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Олон нийтэд үйлчилдэг байгууллагын (төрийн биш) мэдээлэл бол улс төрч, албан тушаалтнуудын тусын тулд бус харин олон нийтийн ашиг

сонирхолд зориулагдсан юм. Мэдээллийн эрх чөлөө нь хариуцлага хүлээх чадвартай, ил тод засаглалын гол бүрэлдэхүүн хэсэг болдог нь хамгийн чухал байдаг.

Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж хүртээмжийг баталгаажуулах хэрэгтэй гэсэн зарчим дээр үндэслэн мэдээлэл хүртэхэд саад болох ба хадгалагдаж буй мэдээллийг санаатайгаар устгах нь гэмт хэрэг мөн гэдгийг хуулиар тогтоох ёстой бөгөөд төрийн байгууллагууд мэдээллийг хадгалж, хамгаалах наад захын стандартыг хуулиар тогтоох нь зүйтэй. Төрийн байгууллагууд нийтийн мэдээллийг зохих ёсоор хадгалж хамгаалахын тулд хангалттай хэмжээний хөрөнгө зарцуулж, анхаарал тавих учиртай. Мэдээллийг туйлшруулах болон өөрчлөн засварлах аливаа оролдлогоос сэрэмжлэх үүднээс төрийн байгууллагын дотор байгаа мэдээллийг өөрийг нь төдийгүй түүнийг хадгалж буй эх сурвалжуудыг ч нээлттэй байлгах шаардлагтай. Учир нь мэдээллийн нийгмийн улс төрийн салбарт төлөөллийн ардчиллын институциуд байр сууриа алдаж, түүний оронд цахим салбарын хүчээр “цахим ардчилал”-ын хэлбэр бүхий шууд ардчилал давамгайлах боломжтой болжээ.

Хүний эрхийн асуудлын хүрээнд мэдээлэл олж авах, улс орны аливаа асуудлаар мэдээлэлтэй байхыг шаардах зэрэг нь ердийн үзэгдэл болно. Засаглалын харилцаа мэдээллийн зөв, жам ёсны урсгалд тулгуурлах нь нийгмийг хамран гаргах шийдвэрийн оновчтой хувилбарыг сонгох давуу талыг аяндаа бий болгодог байна.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Хэрэглэгдэхүүнд үндэслэн төрийн байгууллагын ил тод байдал нь авлигаас урьдчилан сэргийлэх гол хүчин зүйл болохыг тодорхойлох

Нэмэлт мэдээлэл:

Байгууллагын ажилтнуудын зан үйлд нөлөөлөх, өөрчлөхийн тулд ямар арга хэмжээ авах вэ?

Хүний ажил албан дээрээ биеэ авч явах зан үйл нь байгууллагын соёлоос ихээхэн шалтгаалдаг болох нь тогтоогдсон байдаг. Тиймээс хүний зан үйлийг өөрчлөх нэг чухал арга бол эерэг үнэт зүйл болон ёс зүйг ажлын байран дээр төлөвшүүлэх явдал юм. Үүний тулд хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргууд бол ёс зүйн дүрэм, манлайлал, сургалт хөгжил юм. Ёс зүйн дүрэм нь ажилтнуудын зан үйлийн жишгийг тогтоодог авлигаас урьдчилан сэргийлэх гол хэрэгсэл бөгөөд байгууллага доторх үнэт зүйл, зан үйлийн хүлээгдэж буй жишгийг тогтоосон үндсэн баримт бичиг юм.

Төрийн албан хаагчийн зан үйлийн дүрэм 3 үүрэгтэй:

- Төрийн үйлчилгээнд эрхэмлэх ёс зүйн уур амьсгалыг харуулах
- Төрийн албан хаагчдын сахих ёстой ёс зүйн жишгийг харуулах
- Ард иргэдэд төрийн албан хаагчидтай харилцахдаа тэднээс ямар зан үйл, хандлага хүлээж болохыг хэлж өгнө.

Ёс зүйн дүрмийн тусламжтайгаар байгууллага доторх зан үйлийг залах бөгөөд тусгай бодлого чиглэл үгүй нөхцөл байдалд шийдвэр гаргах удирдамж болгон ашигладаг. Ёс зүйн дүрэм нь авлигаас урьдчилан сэргийлэх стратегийн үндсэн элементийн нэг тул энэ талаар цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулах хэрэгтэй. Дашрамд хэлэхэд, НҮБ-аас гаргасан Төрийн

албан хаагчийн ёс зүйн дүрэмд төрийн албан хаагчдын мөрдөж сахивал зохих зан үйлийн жишгүүдийг нэлээд сайн тусгасан байдаг.

Эх сурвалж: http://www.iaac.mn

## СЭДЭВ 17: АВЛИГЫН ХОР ХОХИРОЛ

Хүлээгдэж буй үр дүн:

- Авлигын талаарх жишээ баримтуудыг ялган зааглаж, түүний үр дагавар, оролцогчид, хор холбогдлын талаар дүгнэн хэлэлцэх
- Мэдээллийн олон эх сурвалжтай ажиллах, хувийн дүгнэлт хийх чадвараа хөгжүүлэх

Холбогдох хичээл: Иргэний боловсрол

Зорилтот бүлэг: 10 дугаар ангийн суралцагчид

Сургалтын арга: Бүлгээр ажиллах, хэлэлцүүлэг

Хэрэглэгдэхүүн: Тохиолдол:

Сэтиш Чанд. Улс төрчдийн үнэгүй аялал болон төлбөр нь хахууль мөн үү?

“Маршаллын арлууд” сэтгүүл 2006 оны 7 дугаар сарын 21-ний дугаартаа “Улс төрчдөд зориулсан үнэгүй аялал болон төлбөр нь хахууль мөн үү” гэж асуужээ. 2006 оны эхээр Маршаллын Арлуудын Бүгд Найрамдах улсын сенатын гишүүд гэр бүлийн хамт БНХАУ-д хийсэн албан айлчлалын дараахан энэ асуулт гарч иржээ. Мэдээжээр албан айлчлал бол тийм ч хачирхалтай зүйл биш, Номхон далайн арлын улс төрчид тусламж, халим, загас агнуурын талаар ярилцахаар урилгаар олон газар айлчлах нь олонтаа. Гэхдээ орон нутгийн хэвлэлийн анхаарлыг татсан гол зүйл нь уг аяллын зардлыг БНХАУ бүрэн даасан гэж нэр нь тодорхойгүй эх сурвалжаас мэдээлсэн явдал юм. Цаашлаад аялагчид 7000-12000 ам.долларыг мөн урьсан газраасаа хүлээж авсан ажээ.

Маршаллын Арлуудын Бүгд Найрамдах улс нь Бүгд Найрамдах Хятад Улс буюу Тайваныг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг цөөхөн орнуудын нэг бөгөөд үүнийг мэдээжээр БНХАУ байнга эсэргүүцэж ирсэн. Нэр дурдагдсан нэгэн сенатын гишүүн тус сэтгүүлийг шүүхэд өгнө хэмээн сүрдүүлсэн байна.

Хичээлийн явц:

- Суралцагчид 5-6 сурагчаас бүрдсэн 5 бүлэгт хуваагдаж, дараах даалгаврыг гүйцэтгэнэ. Үүнд:
  - Багш бүлэг тус бүрд авлигын нөхцөл байдлын талаарх баримт бүхий өгүүлэл, тохиолдлууд өгнө.
  - Бүлэг тус бүр өөрийн авсан тохиолдолд шинжилгээ хийж, хэлэлцэнэ. Үүний тулд багшийн тарааж өгсөн “Авлига: Ашиг хонжоо ба хор хохирол” хэмээх хүснэгтийг ашиглана.

Бүлэг тус бүр өөрсдийн дүн шинжилгээ бүхий хуудсыг хананд байрлуулж бусад багуудад танилцуулна.

Бүлгүүдэд тавих асуултууд:

Ямар хүмүүс ихэвчлэн авлигын хэрэгт холбогддог вэ?

Яагаад энэ хүмүүс авлига авах сонирхолтой байдаг вэ?

Авлига өөрөө ямар хэлбэр, хэв шинжийг агуулдаг вэ?

Ямар салбар, байгууллагууд авлигад илүү өртөмтгий байдаг вэ?

Авлигыг хэрхэн бууруулж, таслан зогсоох вэ?

Бүлгүүдийг дараах байдлаар ажлаа танилцуулахыг зөвлөнө.

Бүлэг 1 - Авлигад оролцогчдын тухай;

Бүлэг 2 - Авлига гарах шалтгаан, нөхцлийн тухай;

Бүлэг 3 - Авлигын үйлдэл, хэлбэрүүдийн тухай;

Бүлэг 4 - Хамгийн их авлигад идэгдсэн байгууллага, хүмүүсийн тухай;

Бүлэг 5 - Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох арга замын тухай.

Хүснэгт: “Авлига: Ашиг хонжоо  ба хор хохирол”

| **Хэнд** | **Ашиг хонжоо** | | **Хор хохирол** | |
|---|---|---|---|---|
| | **Эдийн засгийн** | **Ёс суртахууны** | **Эдийн засгийн** | **Ёс суртахууны** |
| Авлига өгөгчид | | | | |
| Авлига авагчид | | | | |
| Төр, төрийн байгууллагад | | | | |
| Улс орон, нийгэмд | | | | |

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Бүх хүмүүс авлига өгөх, авах нь буруу гэдгийг маш сайн мэддэг. Гэхдээ аль ч нийгмийн харилцааны явцад авлига оршсоор байдаг нь гайхалтай. Тиймээс авлига өгч буй болон авч буй хүмүүс, улмаар байгууллага, төр нийгэмд гарч буй эерэг болон сөрөг талуудыг харуулах нь зүйтэй юм. Үүний эцэст авлига нь зөвхөн өгч, авч буй хоёр хүнд л ашигтай мэт харагдавч улс, нийгмийн хөгжилд маш хор хохиролтой үзэгдэл болохыг ойлгон ухаарах нь уг хичээлийн ач холбогдол болно.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ - БЭЛЭГ ЯМАР ҮЕД ХАХУУЛЬ БОЛДОГ ВЭ?

Энэхүү Маршаллын Арлуудын улсын улс төрчдийн үнэгүй аялал болон томилолтын мөнгө нь авлига мөн үү? Мөн энэ нь авлига хэмээх тодорхойгүй ойлголтын талаарх зарим нэг асуудлыг тодруулах боломж олгож байна.

Авлига гэж юу вэ? Аливаа “бэлэг” ямар үед хахууль болдог вэ? Авлигын үр дагавар юу вэ? Авлигатай хэрхэн тэмцэх вэ?

Авлигад нэг талаас авлига өгөгч /буюу тодорхой үйлчилгээг хүсэгч/ нөгөө талаас авлига авагч /буюу үйлчилгээ үзүүлэгч/ гэсэн хоёр талтай. Авлигыг ихэнх хүмүүс харвал таньж, ялгаж чадна гэдэг боловч авлигыг тоогоор хэмжих нь илүү бэрхшээлтэй.

Авлига байхын үндэс нь ийм үйлчилгээг хүссэн эрэлт болон түүнийг хангадаг нийлүүлэлт байгаа явдал юм. Авлигын нийлүүлэлтэд орлого бага байх, орлуулах ажлын байрны боломж байх, мөрдөн илрүүлэх, байцаан шийтгэх механизм ядмаг, эсвэл огт байхгүй байх, төвлөрсөн эрх мэдэл зэрэг орно. Харин эрэлтэд авлигын үр дүнд асар их хэмжээний орлого олох боломжтой байх, тухайлбал засгийн газрын том хэмжээний тендер, гэрээ нь авлига бий болгох эрэлтийг өсгөх юм. Тиймээс тодорхой үйлчилгээнд өгөх хахуулийн үнэ, авлигын хэмжээ, зэрэг нь дээрх хүчин зүйлсээс хамааралтай. Аливаа нэгэн авлига нь тодорхой үнэд /хахууль/ хийгдэж байдаг. Авлигын хэмжээ цаг хугацаа, орон зайн хувьд ялгаатай байх нь авлигын эрэлт, нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлттэй нягт уялдаатай.

Авлигын үр дагавар юу вэ? Авлига ядуурлыг нэмэгдүүлдэг хэмээн дүгнэсэн олон тооны судалгаа байдаг. Энэ нь хоёр арга замаар нөлөөлдөг. Нэгд, авлига бол үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ утгаараа орлогын өсөлтийг бууруулах хүчин зүйл болдог. Түүнчлэн олон эмпирик судалгаагаар авлига нь эдийн засгийн өсөлтийн хурдыг сааруулдаг нь тогтоогдсон байна.
Хоёрт, авлига нь ядуурлыг нэмэгдүүлэх хор уршигтайгаар орлогын дахин хуваарилалт хийдэг байна. Мэдээжээр, ядуу давхарга хээл хахууль төлөх хөрөнгө, түүнд нэвтрэх мэдээлэл ч байхгүй. Авлига нь тодорхой хөрөнгө мөнгийг нэгээс нөгөөд шилжүүлж байгаа үйлдэл бөгөөд ингэхдээ ядуусыг золиосоо болгож байдаг. Гаалийн татвар ногдуулах ёстой бараа хилээр нэвтрэхэд хахууль авсан гаалийн байцаагч тооцохгүй өнгөрөөж байгаа нь хуулийн дагуу улсад орох ёстой байсан орлого үгүй болж байдаг. Мөн сувилагч үйлчилгээний төлөө хахууль авч байгаа нь нэг өвчтөнд үзүүлэх ёстой байсан эмчилгээг хойшлуулж, ингэснээр ядуу өвчтөн хохирч байдаг. Нөгөө талаас энэ нь дээрх олон чухал үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй албан хаагчид чухал шаардлагатай үйлчилгээг хээл хахууль авахын тулд саатуулах, хүнд суртал гаргах зэргээр ашиглах илүү ноцтой сөрөг үр дагавартай.

Авлигын шалтгааныг мэдсэн тохиолдолд түүнтэй тэмцэх зөв стратегийг тодорхойлоход гол үүрэгтэй.

## СЭДЭВ 18: АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР ЯМАР ЧИГ ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Хүлээгдэж буй үр дүн:

- Авлигатай тэмцэх газрын чиг үүргийн талаар мэдэж, түүний үйл ажиллагааны хамрах хүрээний талаар дүгнэн ярилцах
- Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар мэдээллийн эх сурвалжтай ажиллаж, үйл ажиллагаанд хамрагдах чадвараа хөгжүүлэх

Холбогдох хичээл: Нийгмийн ухаан хичээлийн Эрх зүй бүлэг сэдвийн хүрээнд, Иргэний боловсрол

Зорилтот бүлэг: 9-10 дугаар ангийн сурагчид

Хичээлийн арга: Ярилцлага, давхар хэлэлцүүлэг, асуудал шийдвэрлэх, толь хөтлөх
Хэрэглэгдэхүүн: Цагдаагийн байгууллага, АТГ-ын вэб хуудас /www.iaac.mn/-ны мэдээлэл, Хуулийн нэр томьёоны тайлбар толь бичиг

Хичээлийн явц:
Авлигатай тэмцэх газрын чиг үүргүүдийн талаар болон иргэдийн гомдол, мэдээллийг хэрхэн хүлээн авдаг талаарх ярилцлагыг багшийн зүгээс хөтлөн явуулна.
Чиглүүлэх асуултууд:

- Авлигатай тэмцэх газар нь ямар зорилготой үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байгууллага вэ?
- Авлигатай тэмцэх газар ямар чиг үүргүүдтэй вэ?
- Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхийг нэрлэнэ үү
- Иргэдээс Авлигатай тэмцэх газарт туслах нь ямар ач холбогдолтой вэ?
- Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд бид юу хийж чадах вэ?

Эдгээр асуултын дагуу сурагчид хэлэлцүүлэг хийж гол шийдвэрийг ангиараа гаргана.

- Авлигатай тэмцэх газар нь шүүх, прокурор болон цагдаагийн байгууллагаас ямар үйл ажиллагааг хэрэгжүүлдгээрээ онцлог ялгаатайг тайлбарлаарай.
- Авлигатай тэмцэх газрын үндсэн чиг үүргийг схемээр үзүүлээрэй.
- Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхийн хэрэгжилт нь төрийн байгууллагын ил тод байдалтай хэрхэн холбогдох вэ?
- Авлигатай тэмцэх газарт хандаж гомдол мэдээлэл гаргах ямар арга замууд байдаг вэ?

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:
Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Авлигатай тэмцэх газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
- Хуульд заасан албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах ажлыг гүйцэтгэх.

Авлигатай тэмцэх газар нь дараахь бүрэн эрхтэй:

- Авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;
- Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;
- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;
- Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх, талан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
- Авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах;
- Хуулиар харъяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;
- Чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах;
- Өөрийн байгууллага ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;
- Гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулах авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;
- Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- Өөрийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч бусад этгээдийг шаардлагатай тохиолдолд Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах;
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;
- Мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- Хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;

Авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

Авлигатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн дээр дурьдсан чиг үүрэг, эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, захиргаа, санхүүгийн ажлыг хэрэгжүүлэх үүргийг Тамгын хэлтэс хэрэгжүүлнэ.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг Эрүүгийн хуульд заасан бусад хэргийн нэг адил ерөнхий буюу нийтлэг, тусгай буюу нэг бүрчилсэн гэж хоёр ангилан үзнэ.

Авлигаас урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ нь тухайн улс орны нийгмийн амьдралд бодит үзэгдэл болсон авлигын гэмт явдал үүсэх улс нийгмийн чанартай шалтгаан, нөхцөлийг илрүүлэн олж арилган устгах, улмаар авлигыг таслан зогсоох зорилгоор авч хэрэгжүүлж байгаа ажлуудын нийлбэр байдаг.

Тухайлбал, манай орны хувьд улс орны хөгжлийн төвшин дорой, ард түмний дийлэнх хэсэг нэн ядуу, төрийн албан хаагчдын цалин бага, хууль хэрэгжүүлэх сахилга сул, авлигатай тэмцэх эрх зүйн орчин төгс бүрдээгүй, хийдэлтэй, хууль, шүүхийн өмнө бүх нийтээрээ тэгш эрхтэй байх хууль ёсны зарчим жигд хэрэгждэггүй, төрийн байгууллага, ажилтнуудын хүнд суртал, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчил газар авсан, үйл ажиллагаа нь нээлтэй, ил тод бус зэрэг нь авлига үүсгэдэг гол шалтгаан, нөхцөл болж байна.

Нэмэлт мэдээлэл: Гомдол, мэдээлэл хүлээн авах төв

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тус газарт харьяалуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс хүлээн авах, хойшлуулшгүй ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий “Гомдол, мэдээлэл хүлээн авах төв”-ийг ажиллуулж байна.

Энэ төв нь 24 цагийн турш иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гомдол, мэдээллийг хүлээн авах бөгөөд та хүсвэл утсан харилцаа, факс, шуудан, цахим шуудан болон биеэр ирж гомдол, мэдээллээ гаргаж болно. Орон нутагт томилолтоор ажиллаж байгаа тус газрын мөрдөн байцаагч нь авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг биечлэн хүлээн авч, хойшлуулшгүй ажиллагаа явуулах үүрэгтэй.

“Гомдол, мэдээлэл хүлээн авах төв” нь Авлигатай тэмцэх газар, түүний хэлтэс, албадын болон алба хаагч нарын үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар харьяалуулснаас бусад төрлийн гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авахгүй.

Түүнчлэн гомдол, мэдээлэл гаргагчаас бичгээр ирүүлсэн гомдол нь гарын үсэггүй, буцах хаяггүй, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн мэдээлэлд тамга, тэмдэг бүрэн дарагдаагүй, тэдгээрийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурагдаагүй зэрэг бүрдэл дутуу, гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаагаас бусад гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзахыг та анхаарна уу.

Гомдол, мэдээллийг гаргагч нь аль болох биечлэн уулзаж гомдол, мэдээллээ гаргах нь тухайн гэмт хэргийн талаар бүрэн мэдээлэл өгөх, түүний дагуу хойшлуулшгүй ажиллагааг шуурхай явуулахад чухал ач холбогдолтой юм.

АТГ нь иргэдээсээс өгсөн гомдол, мэдээллийн нууцыг зохих хууль, журмын дагуу чандлан хадгална.

Эх сурвалж: http://www.iaac.mn

## СЭДЭВ 19: АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ХЭМЖИХ НЬ

Хүлээгдэж буй үр дүн:

- Авлигын олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс авлигатай тэмцэх талаар ямар хүчин чармайлт гаргаж байгааг мэдэх
- Авлигын нөхцөл байдал, түүнийг хэмжих чадвар эзэмших

Холбогдох хичээл: Нийгмийн тухай мэдлэг хичээлийн “Олон улсын харилцаа” бүлэг сэдвийн хүрээнд

Зорилтот бүлэг: 10-11 дүгээр ангийн сурагчид

Хэрэглэгдэхүүн: “Транспэрэнси интернэшнл” байгууллагын Авлигын олон улсын судалгааны дэлгэрэнгүй
Дэлхийн улс төрийн газрын зураг

Сургалтын арга: Нээлттэй хэлэлцүүлэг

Хичээлийн явц:

- “Транспэрэнси интернэшнл” байгууллагын Авлигын олон улсын индексийн талаар багшийн зүгээс товч танилцуулга хийнэ.
- Хэлэлцүүлэгт бэлтгэж сурагчид дараах ажлыг хийнэ. Үүнд:
  - Дор өгсөн нэмэлт мэдээллийг уншиж, агуулгыг ойлгосон байна.
  - Мэдээлэлд дурьдагдсан улс орнуудыг газрын зурагт олж тэмдэглэсэн байна.
  - Бусад шаардлагатай нэмэлт мэдээллийг сурвалжлан олсон байна.
- Сурагчдын зүгээс Авлигын индексийг судалж, дараах асуултуудын дагуу хэлэлцэнэ. Үүнд:
  - Ямар улс орнуудад авлига хамгийн түгээмэл илэрдэг вэ? Эхний 10 орныг жагсаан бичнэ үү.
  - Ямар улс орнуудад авлига хамгийн бага тохиолддог вэ? Эхний 10 орныг жагсаан бичнэ үү.
  - Авлига ямар улс орнуудад хамгийн түгээмэл тохиолдож байна вэ? Эдгээр улс орнуудын улс төр, эдийн засаг болон соёлын нийтлэг шинж чанар нь юу болохыг тодорхойлно уу
  - Авлига нь зөвхөн ядуу улс орнуудад байдаг үзэгдэл мөн үү?
  - Авлига үүсэх гол хөрс суурь болсон нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлно уу.
- Дүгнэлт:
  - Энэ сэдвээр хэлэлцүүлэг хийснээр сурагчид ямар ур чадвараа хөгжүүлсэн талаар
  - Авлигын хор холбогдол, түүнтэй тэмцэх талаар юу мэдэж авсан зэргийг нэгтгэн дүгнээрэй.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Авлига бол зөвхөн манай улсын асуудал биш бөгөөд дэлхийн улс орнууд авлигатай тэмцэх талаар олон тооны хүчин чармайлт гаргаж байна. Авлигатай тэмцэх энэхүү тэмцэлд манай улс мөн нэгдэх ёстой бөгөөд улс орнууд, байгууллага, нийт ард иргэдийн хүчин чармайлт нь энэхүү үзэгдлийг таслан зогсоох гол хүч болохыг сурагчдад таниулан мэдүүлэхэд оршино.

## НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ - АВЛИГЫН ИНДЕКС, ТҮҮНИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ

Дэлхийн олон оронд авлигын тухай олон нийтийн ойлголт, хандлагыг тодорхойлох судалгааг авлигатай тэмцэх арга хэрэгсэл болгон ашигласаар ирсэн. Авлигыг нарийн тодорхой хэмжих болон дүн шинжилгээ хийх арга зүйг тодорхойлох чиглэлээр улс орон, байгууллагууд хүч хөдөлмөрийг зарцуулж байна. Олон улсын түвшинд “Транспэрэнси интернэшнл” байгууллага 1995 оноос эхлэн дэлхийн улс орнуудын Авлигын төсөөллийн индекс (CPI)-ийг судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачдын үнэлгээ, төсөөлөлд үндэслэн тооцож, дэлхийн улс орнуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрсэн түвшинг үнэлэн эрэмбэлэн гаргадаг. Энэ үнэлгээ нь дэлхийн улс орнуудыг харьцуулан дүгнэх, олон улсын түвшинд байр суурийг тодорхойлоход ач холбогдолтой.

Манай улсын хувьд Авлигын индекс тооцох зорилгоор “Авлигын ерөнхий төлөв байдал”, “Оюутан залуучуудын шударга байдлын түвшин тогтоох”, “Улс төр хууль хяналтын хүрээн дэх авлигын төсөөлөл” судалгаанууд, “Хүүхэд, залуучуудын шударга байдлын индекс, мөн “Транспэрэнси интернэшнл” байгууллагатай хамтран “Дэлхий нийтийн авлигын боромeтр -2009” судалгааны ажлыг зохион байгуулж, авлигын эсрэг судалгаа шинжилгээний арга зүй боловсруулж, хэрэгжүүлсэн байна.

“Транспэрэнси интернэшнл”-ийн судалгаагаар авлига улс орнуудад нэмэгдэж байгаа нь тогтоогджээ. Тус байгууллагаас Авлигын олон улсын индексийг тодорхойлохын тулд жил бүр бизнес эрхлэгчид болон төрийн албан хаагчдыг оролцуулан өргөн хэмжээний санал асуулга авч, ямар улс оронд авлига ямар хэмжээнд тохиолдож байгааг тодорхойлдог. 2010 оны байдлыг төрийн байгууллагын хэмжээнд авч үзвэл:

- Хамгийн бага авлигатай 10 орон: Дани, Шинэ Зеланд, Сингапур, Швед, Швейцарь, Финланд, Нидерланд, Австрали, Канад, Норвеги
- Хамгийн их авлигатай 10 орон: Сомали, Афганистан, Бангладеш, Судан, Ирак, Чад, Узбекистан, Туркменистан, Гвиней, Бурунди

Харин Монгол Улсын хувьд нийт 0 - 10 хүртэлх (10 – авлигагүй, 0 – авлига ихтэй) индексийн энэхүү үзүүлэлтээр 2.7 оноотой буюу Этиофи, Мали, Мозамбик, Танзани, Вьетнам зэрэг орнуудтай адил үзүүлэлттэйгээр 116[7] дугаар байранд явж байна.

---

[7] www.transparency.org/policy_research/surveys_indices/cpi/2010/results Corruption Perception Index 2010 Results хуудаснаас үзнэ үү. 2010 оны 04 сарын 15-ны өдөр

Авлига нь ихэвчлэн улс төрийн засаглал нь тогтворгүй, дотоодын зөрчил, үймээнтэй улс орнуудад түгээмэл илэрч, улмаар бэхжин тогтдог. Харин жагсаалтын эхэнд буй улс орнуудад удаан хугацааны ардчилсан дэглэм, тогтвортой байдал, хуулийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын нээлттэй, ил тод үйл ажиллагаа зэрэг нийтлэг шинжүүд байгааг судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг.

Тус байгууллагын тэргүүн асан Петер Ейген "Авлига бол ядууралд хүргэх хамгийн гол нөхцөл бөгөөд мөн ядуурлыг бууруулахад хамгийн гол саад болж буй хүчин зүйл" гэж тэмдэглэжээ. Улмаар тус байгууллагын тэмдэглэснээр "Авлига бол байгалийн гамшигтай адил гэнэт тохиолдож болох давагдашгүй хүчин зүйл биш. Гэхдээ энэ үзэгдэл дэлхийн олон сая эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд залуусын өмнө буй олон олон боломжийг хулгайлж байгаа тул тэдний эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. 2015 он гэхэд дэлхийн ядуу хүн амын тоог хоёр дахин багасгана гэсэн Мянганы хөгжлийн зорилтод хүрэхийг дэлхийн улс орнууд хичээх хэрэгтэй. Хүмүүсийг ядуурлаас чөлөөлөхийн тулд авлигаас ангижрах нь нэн тэргүүний зорилго болж байна"[8] хэмээн мэдэгдсэн байна.

Авлигын индексийн ач холбогдол нь:

- Авлигатай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх,
- Авлигын цар хүрээ, хэлбэрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон цаашдын бодлого хөтөлбөрийг боловсруулах,
- Төрийн захиргааны төв байгууллага нутгийн өөрөө удирдах байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр өгөөж, авлигад өртөх эрсдлийг тодорхойлж харьцуулан шинжлэх,
- Төрийн ба төрийн бус байгууллагууд, судлаачид, олон нийтийг өргөн хүрээтэй мэдээллээр хангах.

## СЭДЭВ 20: ҮЗГИЙН ХҮЧ (ШУДАРГА ЁСНЫ ТУХАЙ ЗАХИДАЛ БИЧИХ)

Хүлээгдэж буй үр дүн:

- Нийгмийн шударга ёсны тухай өөрсдийн мэдлэг, ойлголтоо цэгцлэн бусадтай хуваалцах, өөрийн санал, шийдлийг олон нийтэд мэдээлэх чадварыг төлөвшүүлэх
- Сурагчид хувийн санаа, дүгнэлтийг танилцуулах

Холбогдох хичээл: Иргэний боловсрол, Монгол хэл, Уран зохиол

Зорилтот бүлэг: 7-9 дүгээр ангийн суралцагчид

Хэрэглэгдэхүүн: Захидлын дугтуй, цаас, шуудангийн марк

Хичээлийн явц:

А хэсэг: Захидлаа төлөвлөх нь:

---

[8] Транспэрэнси интернэшнл байгууллагын цахим хуудас http://ww1.transparency.org/cpi/2005/2005.10.18.cpi.en.html

Тодорхойлох: Оролцогчдод юуны талаар бичихийг хүсч байгааг тодорхойлоход нь тусална. Үүнд өөрийн орон нутгийн болон хувийн чанартай асуудал зэргийг илэрхийлнэ. Захидлыг хэнд хандан, юуны тухай бичихийг тодорхойлохын тулд 3-4 жижиг бүлгээр ажиллавал зохино. Үүнд анхаарах асуудлууд нь:

- Энэ асуудал нийт улс үндэстний асуудал уу, зөвхөн танай орон нутгийн асуудал уу?
- Энэ асуудал хэнд чиглэж байна вэ? Засгийн газарт хамаарах асуудал мөн үү? Ямар байгууллага, субъект хариуцах вэ?
- Энэ асуудлыг хүн бүхэн мэдэх нь зүйтэй юу?
- Энэ асуудлыг ямар хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх нь зүйтэй вэ?
- Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэвэл оновчтой вэ?

Судалгаа: Захидлаа үр дүнтэй, сайн болгохын тулд сайтар мэдээлэл цуглуулах шаардлагатай. Үүний тулд хичээлээр олж авсан мэдээллийг шалгаж баталгаажуулах ба мөн нэмэлт судалгаа хийж өргөжүүлнэ. Үүн дээр үндэслэн уг захидалд дурдсан асуудлыг хүлээн авч, шийдвэрлэж чадах байгууллага, албан тушаалтныг тодорхойлох шаардлагатай.

Б хэсэг: Захидал бичих нь:

Захидлаа хэрхэн үр дүнтэй бичих талаар бүлгээрээ зөвлөн хэлэлц. Ангийн бусад бүлэгтэйгээ захидлаа бичих төлөвлөгөө гаргаж, хугацаагаа тохирно. Бүгд захидлаа эхний хувилбараар боловсруулсны дараа бусад бүлгүүдтэй хуваалцаж, саналыг нь авна. Бүлэг бүр бусад бүлгийн захидлуудыг сайтар хянан редакторлож, шалгах үүргийг гүйцэтгэнэ. Захидлаа дугтуйлж, хүлээн авагчийн хаягийг зөв бичээд шууданд хүргэж өгнө.

С хэсэг: Сайн захидал бичих зөвлөгөө

Энэ хэсэгт өгүүлж буй зөвлөгөө нь та бүхний захидал үр дүнтэйгээр хэлэлцэгдэн, шийдвэрлэгдэх боломжийг дээшлүүлнэ хэмээн найдаж байна.

- Юуны өмнө өөрсдийгөө танилцуулна. Тухайлбал, өөрсдийн сургууль анги, нэрсээ бичээрэй.
- Захидлын агуулгыг маш товч бөгөөд ойлгомжтойгоор тодорхойл.
- Өөрсдийн шалгаж баталгаажсан мэдээллүүд дээр тулгуурла. Баримтгүй зүйлсийг оруулах хэрэггүй. Ямар нэгэн баталгаагүйгээр хэн нэгнийг шүүмжлэх, гүтгэж үл болно. Та нар асуудал шийдвэрлэхийг зорихоос бус дахин үүсгэх зорилгогүй гэдгийг санаарай.
- Хэрвээ та ямар нэгэн зүйлс хийх ёстой гэж үзвэл яагаад гэдэгт тайлбар өг.
- Хэрвээ та бүхэн хариу хүсч байгаа бол чухам ямар асуултад хариулт авахыг хүсч буйгаа онцол.
- Захидлын нэр хаяг, дугтуй зэргийг стандартын дагуу бичиж ашигла.
- Боломжтой бол захидлын хуулбарыг хадгал.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Энэхүү хичээл нь сурагчдад бичих чадвар эзэмшүүлэхэд туслах болно. Бичих, саналаа хэлэх зэргээр өөрийн үзэл бодлоо илэрхийлэх нь суралцагчдыг бие даасан үзэл бодолтой болох, аливаа үзэгдэл үйл явцыг өнгөц бус, гүн харах чадвартай болгоод зогсохгүй, хамт олны үзэл санааг төлөвшүүлэхэд тус дэм болдог. Бичих нь аливаа асуудалд ул суурьтай хандаж сургахын хамт өөрийн үзэл бодлыг бусдаар үнэлүүлэх боломж олгоно.

Нэмэлт мэдээлэл:

Бичих чадварыг төлөвшүүлэхийн тулд тавигддаг үндсэн шаардлага

Байнга бичих боломжтой байх. Тогтмол бичих нь олон шинэ шинэ санаа төрүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Сонирхолтой сэдэв. Сурагчид өөрсдийн сонирхсон сэдвээр бичихдээ тэр бүр оновчтой сонгож чаддаггүй. Бичих нь шинэ санаа болон сэдвээр судалгаа явуулах онцгой арга мөн.

Загварууд. Бичлэгийн олон хэлбэрийг олон янзын загварыг ашиглах нь бичих чадвар эзэмшихэд чухал ач холбогдолтой.

Уншигчдын цар хүрээ. Бичих үйл ажиллагаанд тавигдах нэг үндсэн шаардлага нь хэнд зориулж бичиж байгаагаа тодорхойлоход оршдог.

Нягтлан боловсруулах. Бичлэгийн эх нооргийг олон дахин засварлах нь сайн бичигч болоход нэн хэрэгтэй.

Хамтран ажиллах. Бичлэгийн талаар санаа бодлоо солилцох нь ихээхэн үр дүнтэй хэрэгсэл юм.

Бичих үйл явцын загвар:

Санаа төрөх үе шат-баримт мэдээлэл цуглуулах, бодол санаагаа цэгцлэх үе шат юм. Энэ үе шатанд тухайн сэдвээр ямар санаа бодлыг дэвшүүлэн гаргахыг эрэгцүүлэн бодож, бичих арга замаа төлөвлөдөг.

Эх бэлтгэх үе шат-санаа бодлоо цаасан дээр буулгах үе шат юм. Санаагаа бичсэнээр тухайн сэдвээр юу хэлэх гэснээ цэгцэлж ойлгомжтой болгодог.

Бичсэнээ хянах үе шат-ноороглосон эхээ боловсронгуй болгодог. Энэ үед хэлэх гэсэн санааг тодорхойлж, илүү ойлгомжтой илэрхийлэх аргаа сонгодог.

Бүтээлчээр бичих үйл явцын үе шат:

- санааг ерөнхийлөх;
- үндсэн санааг тодорхойлох;
- зохион байгуулах;
- бичих;
- засварлах.

## СЭДЭВ 21: ХҮҮХДҮҮД АВЛИГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ ЧАДНА

Хүлээгдэж буй үр дүн:

Авлигын гэмт хэрэг гарахад нөлөөлдөг шалтгааныг тодорхойлж, хувь хүн, байгууллага, хамт олноос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлж гаргана.

Шаардлагатай үед АТГ, шүүх, цагдаа зэрэг хууль сахиулах байгууллагуудад туслах, тэдний тусламжийг авах хэрэгтэйг ойлгож, хуулийг сахиулахад иргэдийн үүрэг, оролцооны ач холбогдлыг ойлгож авна.

Хичээлийн нэр: Нийгмийн ухаан хичээлийн «Эрх зүй» бүлэг сэдвийн хүрээнд

Зорилтот бүлэг: 8-9 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Тохиолдол шинжлэх, дүрийн тоглолт, давхар хэлэлцүүлэг, асуудал шийдвэрлэх, толь хөтлөх

Хэрэглэгдэхүүн: Цагдаагийн байгууллага, АТГ, шүүх зэргийн тухай зурагт хуудас, Хуулийн нэр томьёоны тайлбар толь бичиг

Хичээлийн явц:

Нийгмийн тогтсон хэв ёс, төр засгаас тогтоосон хууль дүрмийг зөрчвөл ямар үр дагаварт хүргэх тухай ярилцлагыг багшийн зүгээс хөтлөн явуулна.

Чиглүүлэх асуултууд:

- Цагдаа хүмүүсийн хоорондох ямар зөрчлийг яаж шийдвэрлэх вэ?
- Авлигын гэмт хэргийг таслан зогсоохын тулд цагдаагийн байгууллагын зүгээс юу хийх вэ?
- Та нар цагдаагийн байгууллагад туслах нь ямар ач холбогдолтой вэ?
- Та нарын амьдарч байгаа хороонд цагдаа байдаг уу? Тэд ямар үүрэгтэй вэ?
- Гэмт хэргийн гаралтын талаарх мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр яагаад долоо хоног бүр мэдээлдэг вэ?
- Чиний бодлоор ямар гэмт хэрэг хамгийн их хор уршигтай байдгийн учрыг тайлбарлана уу?
- Танай сургууль дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ямар зохиож байна вэ?

Эдгээр асуултад сурагчдын анхаарлыг төвлөрүүлэн хэлэлцүүлж гол шийдвэрийг ангиараа гаргана.

- АТГ, шүүх, прокурор болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг жишээн дээр ярилцан, ялгааг нь тайлбарлаарай.
- Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлж болох арга хэмжээнүүдийг жагсаан бич.
- Ялангуяа төрийн байгууллагаас хүнд суртал гаргасан, иргэдтэй шударга бусаар харилцсан тохиолдол гарвал ямар байгууллага, ямар арга хэмжээ авах вэ?
- “Хүүхэд ба хууль” тэмцээн танай сургууль дээр зохион байгуулбал танай анги болон та нар хэрхэн оролцдог вэ?
- Авлигын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд эцэг эхдээ хандан ямар зөвлөгөө өгөх вэ?

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт:

Авлигын гэмт хэрэг, нийгмийн шударга ёсыг зөрчих, хүнд суртал гаргах, иргэдийг чирэгдүүлэх зэрэг хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг арилгах ажилд хүүхдүүд оролцож, хувь нэмрээ оруулж болох тухай мэдлэг, ойлголтыг сурагчдад олгоход чиглэнэ. Ялангуяа хүүхдийн дунд гарч байгаа гэмт хэргийг бууруулах, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өргөжүүлэх, үүнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог сайжруулах шаардлагатай байдгийг мэдүүлэх нь чухал юм.

## НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ – АТГ-Т ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ НЬ:

АТГ нь авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, түүнийг бий болгож буй нөхцөл, шалтгаан болон өдөөгч хүчин зүйлсийг арилгах арга хэмжээ аван хэрэгжүүлж байна. Үүний нэг нь өргөдөл, 1969 тусгай дугаарын утас, цахим хуудсаар дамжуулан иргэдээс гомдол, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэх явдал юм. Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл /Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа

урвуулах/, 264 дүгээр зүйл /Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 265 дугаар зүйл /Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 266 дугаар зүйл /Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 268 дугаар зүйл /Хээл хахууль авах/, 269 дүгээр зүйл /Хээл хахууль өгөх/, 270 дугаар зүйл /Хээл хахууль зуучлах/, 273 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ гэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авна.

Хэрэв та гомдол, мэдээлэл гаргахыг хүсч байгаа бол доорх хаягийн аль нэгийг сонгон ирүүлж болно. АТГ нь иргэдээс гаргасан гомдол, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж, шуурхай шалган шийдвэрлэх үүрэгтэй.

| | |
|---|---|
| **Авлигатай тэмцэх газар:** | *Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 5 хороо Сөүлийн гудамж 41 Улаанбаатар-210644. Шуудангийн хайрцаг 428* |
| **Гомдол, мэдээлэл хүлээн авах утас:** | *976-11-311919, 1969* |
| ***Факс*:** | *70112444* |
| **Вэб сайт:** | *www.iaac.mn* |

СЭДЭВ 22. ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ХЭРХЭН БОЛОВСРУУЛАХ ВЭ?

Хүлээгдэж буй үр дүн:

- Нийгмийн бүлэг, байгууллага, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд ёс зүйн дүрмийн үзүүлэх нөлөөг танин мэдэх
- Ёс зүйн дүрэм нь үнэт зүйлс ба хэм хэмжээг агуулж, хүмүүсийн харилцааг зохицуулж байдгийг ойлгох, түүнийг баримтлах

Хичээлийн нэр: Нийгмийн ухаан хичээлийн “Ёс зүй” бүлгийн хүрээнд

Зорилтот бүлэг: 8-9 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Хэлэлцүүлэг, баримт бичигтэй ажиллах, боловсруулах

Хэрэглэгдэхүүн: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм

Хичээлийн явц:

Ёс зүйн тухай ойлголтын талаарх нэмэлт мэдээллийг сурагчдаар уншуулна.

Хүмүүс өөрсдөдөө зориулан (ангийн, сургуулийн, багшийн, өмгөөлөгчийн гэх мэт) ёс зүйн дүрэм яагаад гаргадаг талаар “Бидэнд яагаад туйлын эрхэмлэл хэрэгтэй болдог вэ?” асуултын хүрээнд ярилцлага хийнэ.

Сурагчид ёс зүйн дүрэм боловсруулахад бэлтгэж дараах даалгаврыг гүйцэтгэнэ. Үүнд:

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинжлэх. Үүний тулд дараах асуултыг ашиглана. Үүнд:

- Ёс зүйн дүрэм үйлчилж буй тухайн байгууллага ямар зорилготой, нийгэмд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
- эдгээр дүрмээр ёс зүйн ямар хэм хэмжээг тогтоож өгсөн бэ? авлигатай холбоотой ямар зүйл, заалтууд байна вэ?
- яагаад эдгээр хэм хэмжээг тогтоох шаардлагатай болсон бэ?
- эдгээрийн адил зүйл юу вэ?
- эдгээр дүрмүүд хоорондоо ямар ялгаатай вэ?
- ижил ба ялгаатай байгаа нь юутай холбоотой гэж үзэж байна вэ?
- энэ 2 ёс зүйн дүрмээс би юуг шинээр мэдэж авсан бэ? (ёс зүйн дүрмийн бүтэц, агуулга гэх мэт)

Сурагчид дараах 7 алхмын дагуу сурагчдын ёс зүйн дүрэм боловсруулна.

а) Танай байгууллага буюу сургуулийнхаа гол зорилгыг олж тодорхойлох

б) Сурагч хүний ажилд баримталбал зохих гол зарчмуудыг жагсаан бичих, тухайлбал, гол эрхэмлэх зүйл, шударга зүйл, үүрэг хариуцлага, үнэнч байдал, найрсаг хүлээцтэй байх гэх мэт

в) Өөрийн тодорхойлсон зарчмуудыг бусадтай ярилцаж, харьцуулж, гол чухлыг нь ялган тодорхойлох

г) Бусад байгууллага, хүмүүсийн ёс зүйн дүрмийг унших. Магадгүй Та тэндээс мартсан болон сайтар томьёологдсон зарчмыг олж өөрийн жагсаалтад нэмж болох юм.

д) Ёс суртахууны асуудлуудыг бод, тэгээд тэдгээрийг тодорхойлоорой.

е) Таны тодорхойлсон зарчмуудыг хүмүүс зөрчиж болох хийгээд болохгүй нөхцөл байдлуудыг тодорхойлон бичээрэй.

ё Та юу хийснээ эргэн нягтлаарай. Тухайлбал,

- Та тодорхойлсон заалтууддаа итгэлтэй байна уу?
- Таны бичсэн дүрмийн үг хэллэг бусдад ойлгомжтой байна уу?
- Товч, тодорхой болж чадаж уу, дахин сайжруулахаар байна уу?
- Дахин томьёолох хэрэгтэй байна уу гэх мэтээр

Өөрсдийн боловсруулсан ёс зүйн дүрмийг ангидаа хэлэлцүүлнэ.

Авлигын эсрэг боловсролд холбогдох гол ойлголт: Ёс зүйн дүрэм нь ажилтнуудын зан үйлийн жишгийг тогтоодог авлигаас урьдчилан сэргийлэх гол хэрэгсэл бөгөөд байгууллага доторх үнэт зүйл, зан үйлийн хүлээгдэж буй жишгийг тогтоосон үндсэн баримт бичиг юм. Ёс зүйн дүрмийн тусламжтайгаар байгууллага доторх зан үйлийг залах энэ дүрэм нь авлигаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

## НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ – ЁС ЗҮЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Ёс зүй хэмээх ойлголт нь эртний Грекийн “ethos” гэдэг үгнээс гаралтай бөгөөд хамтран амьдрах, орон байр, оршин амьдрах газар гэдэг утгыг илэрхийлж байжээ. Хожим энэ ойлголт нь хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл ёс заншил зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг гэх мэт шинэ утга агуулгатай болж тэдгээрийн дотоод мөн чанарыг илэрхийлэх болсон. Эртний

Грекийн “этика” гэдэг үгнээс латин хэлний “мораль” нь ёс суртахуун гэсэн хоёр өөр утгатай, хоёр өөр ойлголт болжээ. Харин Я.Цэвэлийн “Монгол хэлний тайлбар толь”-д “ёс зүй гэдэг ойлголтыг “юмны зайлшгүй зүй тогтол жам тавилан” гэж тайлбарлажээ. Харин хүний ёс журам, заншил сурталд нийцүүлж чадахгүй үйлийг “ёсгүй” хэмээн тодорхойлсон байдаг.

Ёс суртахууны үйлдэл нь тодорхой зорилготой байхаас гадна ёс суртахууны алтан зарчмын дагуу хэрэглэнэ. Ёс зүй бол тухайн орны ард түмний зан заншил, харилцаанд бичигдээгүй хууль маягтайгаар тогтсон хариуцлагын хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, тодорхой ажил үйлс эрхэлж байгаа хүний зүгээс нийгэмтэйгээ харилцах, хариуцлага хүлээх, олны дунд биеэ авч явах, хүнтэй харилцах соёл сайн сайхан зан үйлийн уламжлалт хэм хэмжээний нэгдмэл системийг хэлдэг гэж болно. Хүмүүс өдөр тутмынхаа ажил амьдралд эрх зүйн төдийгүй, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөгө болгодог. Ёс зүй нь зарим тохиолдолд эрх зүйгээс ч ихээхэн хүчтэй байдаг нь хүмүүс түүнийг ямар нэгэн албадлагагүйгээр өөрсдөө тогтоож, урт удаан хугацааны туршид зан үйлээрээ журамлан зохицуулж ирсэнд оршдог. Нийгмийн уур амьсгал бүрэлдэн тогтоход ёс зүй нь хоёр талт нөлөө үзүүлсээр ирсэн.Ёс зүй цэвэр байвал нийгэмд эерэг нөлөө үзүүлж, хөгжин бэхжихийн нөхцөл болох бөгөөд хэрэв доройтвол сөрөг нөлөө үзүүлж, нийгэм уруудахын үндэс болдог.

Ёс зүй зөрчигдөхөд тухайн бие хүний зан чанарын онцлогууд нөлөөлдөг гэж судлаачид үздэг. Тухайлбал, үзэн ядах, хайрлах сэтгэл, мөнгө, алдар хүнд, нэр төртэй байх хүсэл эрмэлзэл, атаархал, хардалт, сэрдэлт гэх зэрэг хувь хүний зан чанарууд нь ёс зүй зөрчил гарахад нөлөөлдөг гэсэн үг. Аливаа нэг шийдвэр гаргахад хувь хүний зан чанар нь заавал нөлөөлж байдаг бөгөөд хувийн зан чанараасаа давж ёс зүйн дагуу шийдвэр гаргах нь тухайн ажилтны эр зоригоос ихээхэн шалтгаалдаг. Ямар ч албан тушаалтан, албан хаагчид мэргэжил дээрээ алдахаас илүү ёс зүйн алдаа гаргах нь илүү байдаг. Ёс зүйн алдаа нь цаашлаад мэргэжлийн алдаанд хүргэдгийг сануулштай.

Ёс зүйн алдаа гаргасан албан тушаалтны үйлдэл болон эс үйлдэхүйд гомдол гаргавал хаана, хэнд, ямар хэлбэрээр гаргах вэ? Ёс зүйн дүрэмтэй төрийн байгууллагууд бүгд өөрийн байгууллага дээр ёс зүйн хороотой байдаг. Гомдлоо иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах журмын тухай хуулийн дагуу гаргана. Энэ хууль нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулдаг.

Деонтологи гэж юу вэ? Деонтологи (Деонтология. Deontology). Геркийн deon – “үүрэг, хариуцлага”, logos – “сургаал үг” гэсэн үгнээс гаралтай. Үүрэг, хариуцлагатай холбоотой асуудлыг авч үздэг ёс зүйн онолын үзэл баримтлал, хэсэг мөн. Энэхүү нэр томьёо, ойлголтыг анх Английн гүн ухаантан, хуульч И.Бентам (1748-1832) боловсруулж, шинжлэх ухаанд оруулжээ. Деонтологи өөрийн гэсэн ойлголтын тодорхой аппараттай байдаг. Тэдний дотор үүрэг, хариуцлага, практик сонирхол, аз жаргалтай, сэтгэл ханамжтай, амь бие хайрлахгүй байх зэрэг ойлголт гол байр эзэлдэг. Деонтологийн үзэл баримтлалын үндсэн зорилго нь хувь хүний соёлд бодитой оршиж буй албан үүрэг, хариуцлагын үзэгдэлтэй ямар нэг хэмжээгээр тохирсон үүргийн “хамгийн шилдэг хэв маяг”-ийг боловсруулахад оршино.

Эх сурвалж: http://www.iaac.mn

# СЭДЭВ 23: МОНГОЛ ХҮҮХДҮҮД ШУДАРГА УУ?

Хүлээгдэж буй үр дүн:

Судалгааны баримтад дүгнэлт хийх, график болон тоон үзүүлэлтийг тайлж унших чадвартай болох

Олон улсын үе тэнгийнхэн болон өөрсдийнхөө тухай эргэцүүлэх

Хичээлийн нэр: Нийгмийн ухааны хичээлийн “Ардчиллын үнэт зүйлс” сэдвийн хүрээнд

Зорилтот бүлэг: 10-11 дүгээр ангийн сурагчид

Хичээлийн арга: Судалгааны баримтыг шинжлэх, хэлэлцүүлэг хийх

Хэрэглэгдэхүүн 1: О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг нар., Нийгмийн ухаан X-XI, УБ., 2010., 112-114,169-174 тал

Хэрэглэгдэхүүн 2: 2008 онд Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албанаас БНСУ, Бангладеш, Энэтхэг Улсын “Транспэрэнси интернэйшнл” байгууллага болон “Хьюндай” судалгааны төвтэй хамтран анх удаа олон улсын хэмжээнд судалгаа хийж, түүнд тулгуурлан Хүүхэд, залуучуудын шударга байдлын индексийг гаргажээ. Шударга байдлын индекс нь 0-10 гэсэн үзүүлэлтээр хэмжигдэх бөгөөд тус үзүүлэлт нь 10-т ойртох тусам маш сайн, 0 руу ойртох тусам маш муу гэсэн үзүүлэлтийг илэрхийлнэ.

Монгол Улсаас 5 аймаг, 6 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 13-18 насны 726 хүүхдийг хамруулан 2008 оны 9 дүгээр сард тус судалгааг авчээ.

Хүйсийн байдлаар харьцуулсан үзүүлэлт

Хот, орон нутгийн байдлаар харьцуулсан үзүүлэлт

Насаар нь харьцуулсан үзүүлэлт

Хичээлийн явц:

1. Судалгаанд оролцсон улсуудын тухай мэдээлэл цуглуулж, солилцох, улс тус бүрийн газар зүйн байрлалыг тодорхойлох, газрын зурагт тэмдэглэх
2. Судалгааны графикуудыг тайлж унших, тайлбар, дүгнэлт бэлтгэх
3. Бэлтгэсэн тайлбар болон дүгнэлтээ анги нийтэд танилцуулах, бусад хүүхдүүдийн тавьсан асуултад хариулах
4. Хичээлийн явцыг дүгнэх. Дараах асуултаас ашиглаарай. Үүнд:
   Шударга ёс гэж юу вэ? Шударга байгаа эсэх нь юугаар илрэх вэ?
   Судалгаанд ямар улсын хүүхдүүд оролцсон бэ?
   Ийм судалгаа хийх нь ямар ач холбогдолтой вэ?
   Бид өөрсдийнхөө шударга эсэхийг үнэлэхийн тулд ямар судалгаа явуулж болох вэ?

ХИЧЭЭЛИЙН НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 41 дүгээр тушаалын хавсралт

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн
багшийн ёс зүйн дүрэм

Нийтлэг үндэслэл

Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэмд бүтээлч, хариуцлагатай ажиллаж амьдрахад нь суралцагчдад шаардагдах цогц чадамж эзэмших хэрэгцээг хангах, бүх нийтийн боловсролын үйлчилгээг тэгш хүртэх эрхийн нэг баталгаа нь багшаас мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх явдал юм.

Энэхүү ёс зүйн дүрмийн эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Боловсролын тухай багц хуулиар тогтоосон багшийн эрх, үүрэг, түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенци-д заасан хүүхдийн эрх, ялангуяа боловсрол эзэмшихтэй холбогдсон эрхийн заалтууд байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсролын үйлчилгээ эрхэлж байгаа төрийн болон хувийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, туслах багш энэхүү “Багшийн ёс зүйн дүрэм”-д захирагдана.

Нэг. Багшийн ёс зүйн дүрмийн зорилго

1.1 Боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад багш ба боловсролын байгууллагаар үйлчлүүлэгчдийн хооронд үүсэх ёс суртахууны харилцааг зохицуулж, багшийг ёс зүйн зөрчлөөс сэргийлэн, мэргэжлийн нэр төрийг нь хамгаалахад оршино.

1.2 Багшийн ёс зүйн зөрчил нь нийгмийн болон үндэсний соёлоор дамжуулан нийт иргэдийн хөгжих тэгш боломжийг алдагдуулан, өсвөр үеийнхний өөртөө итгэх итгэлийг бууруулдгийг харгалзан багш бүр мэргэжлийн ёс зүйн дүрмийг заавал мөрдөх үүрэгтэй.

Хоёр. Багшийн ёс зүйн хэм хэмжээ

2.1 Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд заасан эрх, үүргээ биелүүлж, суралцагчид чанартай боловсрол эзэмшүүлэх хүрээнд:
2.1.1 Суралцагчдын нийгэм-соёлын ялгаатай байдал, нийгмийн гарал, эцэг эх, асран хамгаалагчдынх нь боловсрол, амьжиргааны түвшин, өөрийн нь суралцах чадвар, гадаад өнгө үзэмжээр нь ялгаварлахгүй хандан сурлагын амжилтыг бодитой үнэлэх,
2.1.2 Багшаас суралцагчид тавих шаардлага нь тэдний бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн онцлог байдалд тохирсон байх бөгөөд тогтоосон журмыг зөрчиж, гэр бүлийн байдал, хүүхдийн хөгжил, суралцах чадвараар нь ялгаварлан сургууль, цэцэрлэгт элсүүлэхээс татгалзах, хичээл, сургуулиас хөөх, шилжүүлэх зэргээр сургууль завсардуулахгүй байх,
2.1.3 Суралцагчийн хувийн нууцыг чанд хадгалан, тэдний нэр төр, үзэл бодлыг үгээр басамжлан доромжлох, бие махбодийн шийтгэл үзүүлэхгүй байх,
2.1.4 Суралцагчийн хичээл сонголтын эрх, эрүүл мэндийг хохироох, амралт чөлөөт цагийг хасах замаар тэдний сурлага болон өөрийн ажилд амжилт гаргаж нэр төр олох, уралдаан тэмцээнд илүүтэй анхаарснаар бүх нийтийн боловсролын чанарыг бууруулахгүй байх,
2.1.5 Ном, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад зүйлийг тулган борлуулах, хуульд заагаагүй төлбөр, хураамж, хандив өгөхийг шаардах, багшийн санаачилгаар төлбөртэй сургалт, давтлага хийхгүй байх,
2.1.6 Багшийн нэр хүндийг ямагт дээдлэн, биеэ авч явах байдал, сургах үйл ажиллагаа, хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээж, хичээл, сургалтын үйл явцад идэвхгүй хандах, сургууль, цэцэрлэгийн орчинд согтууруулах ундаа хэрэглэхгүй байх,
2.1.7 Сургууль, цэцэрлэгийн орчин, сургалтын цаг суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, бэлгийн дарамт, гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийнхэн болон гэр бүл, нийгмийн орчны сөрөг нөлөөнд автахгүй байхад нь анхаарах.
2.2 Мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэн, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах хүрээнд:
2.2.1 Суралцагчийн эцэг эхийг нас, хүйс, яс үндэс, боловсрол, шашин шүтлэг, улс төрийн үзэл, амьдралын нөхцөлөөр үл ялгаварлан, боловсролын харилцаанд гэр бүл, эцэг эхийг нээлттэй тэгш оролцуулах,
2.2.2 Суралцагчид цогц чадамж эзэмшүүлэх явдлыг эцэг эхийн өмнө хариуцаж, суурин болон хөдөөгийн амьдралын хэв маяг, эрхэлж байгаа ажил хөдөлмөрийн нь онцлогт тохирсон арга зүйн туслалцааг эцэг эх, асран хамгаалагчид тогтмол үзүүлэх,
2.2.3 Боловсролын үйлчилгээ, түүний чанартай холбоотой эцэг эхийн санал, шаардлагыг хүлээн авч, хүүхдэд нь хамаарах асуудлаар эцэг эхэд зөв шаардлага тавих,
2.2.4 Багшлах үүргээ хэрэгжүүлсний төлөө эцэг эхээс шан харамж авах, төгсөлт, элсэлт зэрэг албан ёсны арга хэмжээ, баяр ёслолын үед үнэтэй бэлэг өгөхөөс аргагүй байдалд суралцагчид болон тэдний асран хамгаалагчид, эцэг эхийн зөвлөлийг хүргэхгүй байх,
2.3 Хамт олны бүтээлч, нөхөрсөг, шударга өрсөлдөөнийг хангасан орчин төлөвшүүлэхийг эрмэлзэж, хамтран ажиллах хүрээнд:
2.3.1 Хамтран ажиллагчдынхаа нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг, туршлагаар нь ялгаварлахгүйгээр хүндэтгэлтэй харилцах,
2.3.2 Өөрийн болон байгууллагын нэр хүнд, амжилтын төлөө хамт олон, хувь хүний нэр төр, эрүүл мэнд, сэтгэл санаа, хувийн өмчид хохирол учруулахгүй байх,
2.3.3 Сурган хүмүүжүүлэх туршлагаа бусадтай хуваалцан, хувийн болон байгууллагын эрх ашгийг зөв хослуулж, хамт олны эв нэгдлийг дээдлэх,
2.3.4 Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохдоо хариуцлагатай хандаж, хамтын хариуцлага хүлээн, хөдөлмөрийн сахилгыг чанд сахин ажиллах,

2.3.5 Хууль тогтоомжийн хүрээнд хөдөлмөрлөх нөхцөлөө сайжруулахад санаа тавьж, мэргэжлийн цогц чадамжаа хөгжлийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлж, онол, арга зүйн хоцрогдлоос сэргийлэх,
2.3.6 Удирдлага, хамт олон, суралцагч, эцэг эх, олон нийтийн зүгээс учруулж болзошгүй зүй бус эрсдлээс хамт олны болон өөрийн нэр төрийг хамгаалах.
2.4 Бүх нийтийн боловсролын нийтлэг эрх ашгийг дээдлэх үзэл санаагаар нийгэмтэй харилцах хүрээнд:
2.4.1 Багш нь төрийн бус байгууллагын ажилд оролцон, орон тооны бус албан тушаалд сонгогдон ажиллаж болох боловч, энэ нь үндсэн ажил үүргээ гүйцэтгэхэд саад болохгүй байх,
2.4.2 Багшлах үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн үзэл бодол, улс төрийн байр сууриа суралцагч, эцэг эх, хамт олонд тулган хүлээлгэх, уриалах, үүний улмаас өөрийн болон бусдын үндсэн ажил орхигдоход хүргэхийг цээрлэх,
2.4.3 Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг ашиглах, сургалтын тоног төхөөрөмж, сурах бичиг, дүрэмт хувцас зэрэг бараа бүтээгдэхүүнийг сонгох, нийлүүлэлтэд оролцохдоо боловсролын чанар, сургалтын байгууллага, суралцагчдын эрх ашгийг урьдал болгох.

Гурав. Багшийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт
3.1 “Багшийн ёс зүйн дүрэм”-ийн заалтуудыг зөрчсөн багшид, Хөдөлмөрийн хууль “Багшлах эрх олгох, хасах журам”, “Багшид мэргэжлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ын хүрээнд хариуцлага хүлээлгэх ба энэ талаарх заалтыг байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгана.
3.2 Ёс зүйн зөрчил гаргасан багшид хүлээлгэх хариуцлага нь нийгэм, байгууллага, суралцагчдад учруулсан хор хохиролд нь тохирсон байна.
3.3 Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дэргэд “Багшийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хянан шийдвэрлэх үүрэг бүхий орон тооны бус “Ёс зүйн зөвлөл” (Цаашид “зөвлөл” гэнэ) ажиллана.
3.3.1 Зөвлөлийн гишүүдийг аймаг, нийслэлийн багш нарын бага хурлаас сонгоно. Зөвлөлийн бүрэлдэхүүнд аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын арга зүйч, сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын ажилтан, эцэг эх, төрийн бус байгууллагын төлөөлөл орно. Зөвлөл 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байна.
3.3.2 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журамд үндэслэн аймаг, нийслэлийн зөвлөлийн ажиллах журмыг нарийвчлан боловсруулж, Боловсрол, соёлын газрын дарга батална. Энэ журамд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд тавигдах шаардлага, тэдний бүрэн эрхийн хэмжээ, хугацаа, багшийн ёс зүйн асуудлаар шийдвэр гаргах хуралдааны журам зэргийг тусгасан байна.
3.3.3 Зөвлөл нь ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн эрхлэгч, нийгмийн ажилтан, багш, цэцэрлэгийн арга зүйч, багш, туслах багш, албан бус боловсролын багшийн ёс зүйн байдлын талаар цэцэрлэг, сургууль, эцэг эх, багш, суралцагч төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичиг, бичгээр гаргасан гомдлыг үндэслэн ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж, холбогдох байгууллага болон гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.
3.3.4 Багшийн ёс зүйн байдлын талаарх дүгнэлтэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын алба, орон нутгийн төр, захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, нийслэлийн дүүргийн Боловсролын хэлтсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгалтын дүнг харгалзаж болно.

3.3.5 Зөвлөл нь багшийн ёс зүйн байдлын талаарх дүгнэлтийг сургууль, цэцэрлэгийн удирдлага, аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга болон багшид өөрт нь хүргүүлэх ба дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээнд хяналт тавьж ажиллана.
3.3.6. Ёс зүйн зөрчилд ногдуулсан хариуцлагыг үндэслэлгүй эсвэл, хүндэдсэн гэж үзвэл тухайн багш 30 хоногийн дотор зөвлөлд бичгээр гомдлоо гаргаж болно.

## Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн захиргааны албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.
1.2.Төрийн захиргааны байгууллага бүр энэхүү дүрмийг дагаж мөрдүүлэн байнгын хяналт, хариуцлагын тогтолцоог дотооддоо бүрдүүлж ажиллана.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү дүрэм нь Төрийн албаны тухай хуулийн 7.1-д заасан төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа албан хаагчдад хамаарна.
2.2. Аливаа байгууллага, албан тушаалтан нь хууль тогтоомжид заасны дагуу төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэхдээ энэхүү дүрмийг жишиг болгож болно.

### Гурав. Ёс зүйн зарчим

3.1. Төрийн захиргааны албан хаагч нь үйл ажиллагаандаа дор дурдсан зарчмыг баримтална:

- шударга ёсны;
- хууль дээдлэх;
- тэгш байдал;
- хариуцлага хүлээх;
- олон нийтэд үйлчлэх.

### Дөрөв. Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс

4.1. Төрийн захиргааны албан хаагч нь энэ дүрмийн 3.1-д заасан зарчмын хүрээнд төрийн бодлого, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дор дурдсан зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ:
4.1.1. шударга ёсны зарчмын хүрээнд: хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах;
4.1.2. хууль дээдлэх зарчмын хүрээнд: төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг ямагт дээдлэн сахих;
4.1.3. тэгш байдлын зарчмын хүрээнд: бусад төрийн албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харилцан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах;
4.1.4. хариуцлага хүлээх зарчмын хүрээнд: албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;

4.1.5. олон нийтэд үйлчлэх зарчмын хүрээнд: төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах.

Тав. Ёс зүйн хэм хэмжээ
5.1. Төрийн захиргааны албан хаагч нь энэхүү дүрмийн 4.1.1-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:
5.1.1. өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт, орлогын талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;
5.1.2. Хөдөлмөрийн хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашиглах;
5.1.3. үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх;
5.1.4. өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;
5.1.5. албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх.
5' Төрийн захиргааны албан хаагч нь энэхүү дүрмийн 4.1.2-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:
5.2.1. Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлах;
5.2.2. харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах;
5.2.3. хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;
5.2.4.албан үүргээ гүйцэтгэж байхдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;
5.2.5.төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг албаны бус зорилгоор ашиглахгүй байх.
5.3. Төрийн захиргааны албан хаагч нь энэхүү дүрмийн 4.1.3-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:
5.3.1. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;
5.3.2. төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;
5.3.3. танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх;

5.3.4. албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглох;
5.3.5. бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох.
5.4. Төрийн захиргааны албан хаагч нь энэхүү дүрмийн 4.1.4-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:
5.4.1. өөрийн мэдлэг чадвар, дадал туршлагаа байнга хөгжүүлж, төрийн албаны нэр хүндийг ямагт дээдлэх;
5.4.2. ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг биечлэн хангах;
5.4.3. удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;
5.4.4. захирах, захирагдах ёсны зарчмыг баримталж, тодорхой асуудлаар өөр саналтай байсан ч удирдлагаас гаргасан хуульд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;
5.4.5. албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх;
5.4.6. албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх;
5.4.7. байгууллагынхаа зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх.
5.5. Төрийн захиргааны албан хаагч нь энэхүү дүрмийн 4.1.5-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:
5.5.1. албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;
5.5.2. төрийн албаны соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй төлөв төвшин харилцах;
5.5.3. иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг зохих дүрэм, журмын дагуу цаг алдалгүй, ил тод, түргэн шуурхай хүргэх.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

## АВЛИГЫН ТАЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

БИД ЯАГААД АВЛИГЫН ТУХАЙ ЯРИХ ЁСТОЙ ВЭ?

Авлигаас хамгийн их хохирогч нь олон нийт болдог. Тэдний эрх, эрх чөлөөгөө эдлэх, шаардлагатай үйлчилгээгээ хүртэх үндсэн нөхцөл алдагдаж, нийгмийн сайн сайхан орчин бүрдэх боломж багасан, ард түмний үнэт зүйл, итгэл үнэмшил, ёс зүйд аюул учран аюулгүй байдал эрс алдагддаг.

Авлига нь хүний эрх, засаглалын хомсдлын илрэл бөгөөд ядуурал, хүний аюулгүй байдлыг хангахад ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Түүнчлэн ардчилсан байгууллагуудыг тогтворгүй байдалд оруулж, төрийн үйлчилгээг хүргэхэд ялгаварлал үүсгэн, хүний эрх ялангуяа хүн амын ядуу хэсгийн эрхийг зөрчихөд хүргэж байна.

Авлига нь өнөөдөр өрх, гэр бүлийн амьдралд хүчтэй хор уршиг тарьж байгаа нь 2010 онд хийгдсэн авлигын түвшинг тогтоох судалгааны дүнгээс тодорхой харагдаж байна[9]. Авлига танай өрхийн төсөвт хэр нөлөөлсөн бэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 33.6 хувь нь ноцтой хэмжээгээр, нөлөөлсөн гэж хариулжээ.

Авлига нь тухайн орны өр зээлийг нэмэгдүүлээд зогсохгүй стандартын бус барааг худалдан авахад хүргэж, шаардлагагүй технологийг оруулан, үнэ ихтэй төслүүдийг дэмжихэд хүргэдэг байна. Эдийн засгийн хувьд ашиггүй төслүүдийг хэрэгжүүлснээр тухайн орон өр зээлийнхээ хэмжээг ихэсгэх ба хөрөнгө нөөц гол төлөв ашиггүй салбар руу төвлөрч, хүчний байгууллагууд, нийгмийг хянах дарангуйлах бүтцүүд өөрсдийгөө хамгаалах, эд хөрөнгө болон эрх мэдлээ хамгаалахад илүү их анхаарлаа хандуулж эхэлнэ.

Авлигаар авсан мөнгө нь хөрөнгө оруулалт руу очдоггүй бөгөөд хууль бусаар орж авсан мөнгийг гол төлөв нууц хэрэглээнд, эсвэл гадаад орны банкны данс руу шилжүүлэх нь олонтаа. Дээр нь худалдаж авч буй барааны үнэд авлигын үнэ өртөг нэмэгдсэнээр бүтээгдэхүүн нь чанаргүй болохоос гадна олон нийт уг хүнд ачааг үүрч хохирлыг нь амсч байдаг.

Нөгөө талаар улс орны эдийн засагт далд эдийн засгийн нөлөө хүчтэй болж, газар авах хандлага илэрнэ.[10]

[9] Монголын авлигын түвшин тогтоох судалгаа. Азийн сан. УБ.,2010.

[10] Д.Зүмбэрэллхам. Авлигатай тэмцэхүй. Зууны мэдээ. 2006.№284

Авлигын нийгмийн хор аюулыг онолын хувьд улс орнуудад дараах байдлаар тодорхойлсон байдаг.

- Авлига нь төрийн захиргааны үнэ өртгийг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл татвар төлөгч нь татвараас гадна авлига төлснөөр нэг үйлчилгээнд давхар төлбөр хийнэ.
- Нийгмийн хэрэгцээнд зориулагдах ёстой хөрөнгийн хэмжээг багасгана.
- Ард түмнээс Засгийн газарт итгэх итгэлийг бууруулдаг
- Улсын тодорхой захиалгат төслүүдээс авлига хэлбэрээр хувь хүртсэнээр нийгмийн сайн сайханд зарцуулах мөнгөний нийт хэмжээ буурна.

Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог сайжруулахад олон нийтийн чадавх чухал үүрэгтэй. Монгол Улсын Үндсэн хуульд[11] иргэдийн оролцооны ардчилсан хэлбэрүүдийг баталгаажуулсан хэдий ч иргэдийн амьжиргааны түвшин, орлогын болон ахуйн ялгааг арилгах, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар зэрэг төрийн зүгээс бүрдүүлэх оролцооны суурь нөхцөл төдийлөн хангагдаагүйн улмаас олон нийтийн оролцооны тэгш боломж хязгаарлагдмал байна.

Нөгөө талаар иргэдийн нийгмийн ухамсар төлөвшөөгүй, эзэмшсэн боловсролын чанар, чансаа сул, идэвх санаачилгагүй, эвлэлдэн нэгдэх, шүүмжлэх, шаардлага тавих, эрх ашиг, сонирхлоо илэрхийлж хамгаалах чадавх, соёл дутагдаж байна. Хүний эрхийн наад захын шаардлагыг тавих иргэний оролцооны энгийн хэлбэрүүд ч олон нийтийн дунд хөгжиж чадаагүй байна. Иймд тэдний өөрсдийн нь амьдрал, хойч үед асар их хор хохирол үзүүлж буй авлига зэрэг нийгмийн зүй бус үзэгдлүүдийг үл тэвчигч, түүнтэй тууштай тэмцэгч болоход нь дэмжлэг үзүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Авлигын эсрэг Монгол Улсын хууль (2006)[12]-д олон нийтийг соён гэгээрүүлэх; УИХ-д хэлэлцэгдэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах, энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулахаар заасан байна. Түүнчлэн уг хуульд боловсролын болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын олон нийтийг соён гэгээрүүлэх талаар хийх үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх;
- Албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуур сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, үүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх;

---

[11] Монгол Улсын Үндсэн хууль 1 дугаар бүлгийн 3 дугаар зүйл, 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 9, 10, 12, 17, 19 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1, 3 дугаар заалт

[12] Авлигын эсрэг Монгол улсын хууль 2 дугаар бүлэг, 5 дугаар зүйл

Хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах

Монгол Улсад авлигатай тэмцэх олон чиглэлт стратеги буюу үндэсний шударга ёсны тогтолцоо нь:

Чөлөөт шударга сонгууль;
Парламент;
Гүйцэтгэх засаглал;
Хараат бус шүүх;
Хяналтын байгууллагууд;
Төрийн алба;
Хэвлэл мэдээлэл;
Иргэний нийгэм;
Хувийн хэвшил;
Орон нутгийн удирдлага;
Олон улсын байгууллага гэсэн тогтолцоог зохистой төлөвшүүлэх замаар авлигатай тэмцэх үзэл баримтлал цогц, үр дүнтэй болно.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд дээрх үзэл баримтлалыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын онцлог нөхцөл байдлыг харгалзан:

1. Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх;
2. Төрийн ил тод байдлыг хангах;
3. Ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах;
4. Авлигын хэргийг илрүүлж хариуцлага тооцох;
5. Төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх;
6. Иргэний нийгмийн оролцоо дэмжлэгт тулгуурлах

гэсэн үйл ажиллагааг чухалчлан авч үзэж байна. Үүний зэрэгцээ авлигатай тэмцэх бие даасан байгууллага гэсэн нэмэлт хөшүүргийг мөн ашиглаж байгаа болно.

Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь авлигын мөн чанар, хор уршгийн талаар олон нийтийг мэдлэгтэй болгож, иргэдийг авлигыг үл тэвчих үзэл санаа, авлигатай тэмцэх аргад сургах зорилготой.[13]

Авлига нь шударга бус байдлын хамгийн тодорхой илэрхийлэл юм. Аливаа сайн сайхны талаарх үндсэн шалгуур нь шударга ёс байдаг. Ялангуяа хүүхэд залуучууд бол гэгээн саруул хүсэл тэмүүлэлтэй, урам зоригоор дүүрэн итгэл үнэмшилтэй байдаг. Гэтэл энэ байдал алдагдсаар байгаа нь ирээдүйн иргэдийн авлигыг үл тэвчих чадамжид сөргөөр нөлөөлж байна.

## 2. АВЛИГА ГЭЖ ЮУ ВЭ?

Монгол Улсад авлигыг олон янзаар нэр томъёо өгдөг ч олон улсын хэмжээнд “corruption” гэсэн нэгдмэл нэр томьёо хэрэглэдэг. “Corruption” гэдэг нь гажуудал, эвдрэл гэсэн утгатай латин үгнээс

---

[13] С. Нарангэрэл нар. Авлига, түүнтэй тэмцэх нь. УБ., 2007.34-37-р тал.

гаралтай бөгөөд албан тушаалтан хууль бус шан харамж авах, эрх мэдлээ худалдах, албан тушаалын байдлаа хувийн ашиг сонирхлын үүднээс урвуулах, хэтрүүлэх зэргийг багтаасан өргөн ойлголт юм. Монгол Улсын Авлигын эсрэг хууль батлагдснаар бид авлига хэмээх нэр томьёог тууштай хэрэглэж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34 дүгээр чуулганаас "Албан тушаалтан ямар нэг хэлбэрээр шан харамж авсныхаа төлөө өөрийн албан тушаалын эрх мэдлийн хүрээнд шан харамж өгөгч этгээдийн тусын тулд албаны дүрэм журмыг зөрчих буюу зөрчихгүйгээр ямар нэг үйлдэл хийх, эсвэл хийхгүй байхыг авлига гэнэ" хэмээн тодорхойлжээ.

Олон улсад авлигыг хэлбэрийн хувьд олон янзаар тодорхойлдог байна. Arnold J. Heidenheimer, Michael Johnston and Victor T.LeVine (ред), Улс төрийн авлига: Гарын авлага[14] (1989), мөн Johann Graf Lambsdorff (2007), Авлигын эдийн засаг ба шинэчлэл: Онол, баримт ба бодлого[15] гэсэн бүтээлүүдэд авлигыг онолын хувьд дараах хэлбэрт ангилжээ. Үүнд:

"Bribery" буюу хахууль өгч, авалцах хэлбэр. Энэ нь заавал хахууль өгч байгаа болон авч байгаа хоёр талын оролцоогоор илэрнэ.

"Extortion" буюу төрийн эрх бүхий албан тушаалтан өөрийн эрх мэдлээ хууль бусаар ашиглан бусдыг далайлган сүрдүүлж хахууль авах хэлбэр

"Cronyism and nepotism" буюу найз нөхөд болон садан төрлийн хүмүүсээ төрийн аливаа албан тушаалд томилох, томилуулах зэргээр тэдэнд сайн үйл бүтээх хэлбэр

"Graft" буюу тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн бэлэг авах, түүнчлэн өөрийн эрх мэдлээ урвуулан ашиг олох зорилгоор нийтэд мэдээлэгдэхээс өмнө олж авсан мэдээллийг ашиглан өөртөө болон бусдад давуу эрх бий болгох хэлбэр

"Embezzlement" буюу өөрт итгэмжлэн хариуцуулсан төрийн хөрөнгийг хувьдаа завших хэлбэр

"Patronage" буюу ямар нэг нам ба албан тушаалтан аливаа сонгуулийн үеэр болон дараа мөнгө болон бусад хэлбэрээр өөрийг нь дэмжсэн этгээдэд нөхөн төлбөр болгон төрийн аливаа албан тушаалд томилох буюу томилуулах хэлбэр.

"Kickbacks" буюу төрийн эд хөрөнгийг хувийн аж ахуйн нэгжид хууль бусаар олгох хэлбэр. Тодруулбал, төрийн өмчийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан өөрийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад гэрээний үндсэн дээр төрийн хөрөнгийг шилжүүлэхдээ тендерт шударгаар ялаагүй талд шилжүүлэх, эсвэл тухайн аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэсэн ажлын үнийн дүнгээс илт их хэмжээний төлбөрийг төлж буйг ойлгоно.

---

[14] Arnold J. Heidenheimer, Michael Johnston and Victor T.LeVine (eds), Political Corruption: A Handbook

[15] The Institutional Economics of corruption and Reform: Theory, Evidence and Policy

Дээр дурдсан онолын болон хууль зүйн тодорхойлолтуудаас харахад авлига, хээл хахууль, шан харамж гэсэн 3 үндсэн ойлголт байна. Авлига гэдэг нь эрх олгогдсон этгээд эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд урвуулан ашиглах явдал бөгөөд энэ нь өөртөө хээл хахуулийг багтаасан ойлголт болж байна. Харин хээл хахууль нь түүнийг өгөх, авах, зуучлах гэсэн үйлдлүүдийг өөртөө агуулсан байна.

> “... энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно”

Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар тольд авлига гэдэг үгийг нэгд, эдэд шунах, ёсон бусын аргаар юмыг олзолж авах, хоёрт, хээл хахууль гэжээ. Судлаач Р.Баттөр “Авлига гэж төрийн албан хаагч, улс төрчид нийгмийн эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж, өөрийгөө буюу өөрийн дотнын хүмүүсийг шударга бус хуулиас гадуур баяжуулах үйл ажиллагааг хэлнэ” гэжээ.

Академич С.Нарангэрэл авлигыг “төрийн албаны болон бусад албан тушаалтан өөрийн албаны бүрэн эрх, нийгэмд үзүүлэх үйлчилгээ, албан тушаалаараа олж авсан алдар хүнд, хүмүүст нөлөөлөх боломж, хэлхээ холбоогоо бусдад хууль бусаар худалдах, худалдан авах хоёр талын хэлцэл” хэмээн, доктор Ж.Бямбаа “Авлигын гэмт хэрэг нь эд материалын болон эдийн бус баялаг, давуу талыг өөртөө бий болгох, бусдад олгох, аль эсхүл тийм нөхцөл боломж бүрдүүлэхэд чиглэсэн санаатай үйлдэл, эс үйлдлээр илэрч, янз бүрийн хэлбэрээр мөн чанараа нууж далдалдаг нийгмийн хорт үзэгдэл мөн”, доктор Д.Зүмбэрэллхам “Албан үүргийнхээ дагуу аливаа эрх олгогдсон этгээд бусдаас хээл хахууль авсныхаа төлөө өөртөө хувийн материаллаг болон материаллаг бус ашиг хонжоо олох үүднээс тэрхүү боломжоо урвуулан ашигласан үйлдэл, эс үйлдэхүй, мөн албан үүргээ биелүүлснийхээ төлөө хууль бус шан харамж авах, иргэд, хуулийн этгээдийн зүгээс энд дурдсан үйлдэл ба эс үйлдэхүйг хийлгэх гэж хээл хахууль, шан харамж өгөх явдлыг бүхэлд нь авлига” гэж тодорхойлсон байна.

Бүхий л тодорхойлолтоос үзэхэд авлига нь

- нийгэмд хортой үр дагавар бүхий үзэгдэл
- төрийн алба, улс төр, бизнесийн хүрээн дэх худалдагдсан эрх мэдэл
- албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоогоор солих
- бусдад давуу байдал олгох
- хууль бусаар албаны эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах явдал юм.

Авлига нь нийгмийн шударга ёс, хууль тогтоомжийг тойрон гарч, албан тушаалтнаар хууль бус үйлдлийг хийлгэж алхам тутамдаа хүний эрхийг зөрчиж байдаг. Төрийн байгууллагуудын хүнд суртал, нүсэр шат дамжлага, хөшүүн хойрго байдал, дутагдал зөрчил гаргасан ажилтнуудтайгаа хариуцлага тооцох тогтсон, үр нөлөө бүхий арга механизм байдаггүй, үйл ажиллагаа нь хаалттай орчинд явагддаг зэрэг нь авлига, хээл хахууль хавтгайрах үндсэн нөхцөл, шим тэжээлт хөрс нь болдог байна.

Авлига нь төрийн албан хаагчийн зүгээс (улс төрийн болон улс төрийн бус албан тушаалтан) өөрт олгогдсон эрх мэдлийг урвуулан ашиглаж, өөрөө ашиг олох, өөрийн дотын хүмүүсийг зүй

бусаар хууль зөрчин баяжуулах, хууль бусаар мөнгө төгрөг, эд бараа, эзэмшлийн бусад эрхийг шууд олж аваад хариуд нь бусдад давуу эрх олгох, явдлаар илэрнэ.

Авлигын түгээмэл хэлбэрүүд:

- Гадаадад хууль бусаар мөнгө шилжүүлэх, хил давуулж хориотой наймаа хийх,
- Төрийн өмчийг хууль бусаар хувьчлах,
- Хууль бусаар хөрөнгө эзэмших, хуурамч зүйл үйлдвэрлэх, дансны аргаар мөнгө завших, өмч хөрөнгийг зүй бусаар зарцуулах,
- Эрх мэдлээ урвуулан ашиглах, айлган сүрдүүлэх, дарамтлах, ул үндэсгүй өршөөл уучлал үзүүлэх,
- Шүүхийн шийдвэрийг мушгин гуйвуулах, хуурамч нотолгоо гаргах,
- Үүрэг үл биелүүлж, ажил цалгардуулах, бусдын хүчийг мөлжих,
- Хээл хахууль, шан харамж авах, бусдын хөрөнгийг сүрдүүлж авах, хууль бус ашиг хонжоо олох, орлогоо хуваах,
- Сонгуулийн булхайтуулах, санал будилаантуулах,
- Дотоодын нууц мэдээллийг зүй бусаар ашиглах, бичиг баримтыг хуурамчаар үйлдэх,
- Төрийн албан тушаал, өмч хөрөнгө, аливаа зөвшөөрлийг дур мэдэн худалдах, уралдаант шалгаруулалт, гэрээ, тендер болон зээлийг ов мэх гарган будилаантуулах,
- Эрх мэдлээ ашиглан нөлөөлөх оролдлого гаргах, тал засч зуучлах, ашиг сонирхлын зөрчилтэй байх,
- Зүй зохистой хэмжээнээс хэтэрсэн бэлэг сэлт, мөнгөн төлбөр, үзвэр үйлчилгээ, дайллага цайллага зохион байгуулах.
- Хууль бус хяналт шалгалт хийх, харилцаа холбоог зүй бусаар ашиглах,
- Албаны тамга тэмдэг, бичиг хэрэг, орон байр, үйлчилгээ болон давуу эрхийг урвуулан ашиглах зэрэг болно.[16]

Жишээ нь: бэлэг сэлтийн хязгаарлалтын хувьд төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэх үед бусдаас өгсөн бэлэг сэлтийн үнэлгээг гаргаж хувьд нь үлдээж болох бэлгийн үнийн дээд хэмжээг хуулиар тогтоосон байдаг. Илүү гарсан үнэтэй бэлгийг төрийн албан хаагч төсөвт зөрүүг төлж уг бэлгийг хувьдаа авч болох бөгөөд эсвэл улсад тушаах ёстой. Хээл хахууль байнгын бэлэг сэлтээс эхлээд өдрийн хоол, урлаг спортын тоглолтын тасалбар, компаний хувьцаа, амралтаараа гадаадад аялж жуулчлах, хүүхдийн сургалтын төлбөр гэх мэт маш олон хэлбэртэй байж болно. Эдгээрийн зарим нь байж болох боловч нэлээд нь үгүй. Болох, болохгүйн зааг нь бэлэг сэлт хүлээн авч байгаа хүн бэлэглэгчийн аманд орохгүй байхад л оршино. Энэ хүрээ зааг нь орон бүрт өөр өөр байх ба түүнийг тогтоосон хэмжээнээс илүү байж болохгүйг заасан мөнгөний хэмжээгээр илэрхийлдэг байна[17].

Авлигыг хэмжээгээр нь жижиг ба том хэмжээний авлига гэж ангилах нь бий. Жижиг авлига нь бага тушаалын албан хаагчидтай хамаатай, бага мөнгөн дүнтэй тохиолдолд тооцогдоно. Төрийн

---

[16] С.Баяраа, Д.Ганбат, Ч.Ган-Өлзий, А.Саруул, Д.Төмөртогоо, Г.Чулуунбаатар. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2006. 1-2 дахь тал.

[17] Мөн тэнд. 29 дэх тал.

албан хаагчид хясан боогдуулах замаар шан харамж авах байдлаар илэрнэ. Жижиг авлигын хохирогчид нь жирийн иргэд байдаг. Жижиг авлигыг бюрократ авлига буюу хүнд суртлын хэмээн нэрлэх нь ч бий. Жижиг авлигын хамгийн түгээмэл тохиолддог салбарууд:

Боловсрол
Эрүүл мэнд
Татварын алба
Хөдөлмөр зохицуулалтын алба
Газрын алба
Байгалийн баялаг (ой, байгаль хамгаалал)
Нийгмийн халамжийн алба
Нутгийн захиргаа
Жижиг авлига авдаг ажил мэргэжил
Цагдаа, хэв журам сахиулагч
Банк, санхүүгийн ажилтан
Аудитор
Байгаль хамгаалагч
Зам, харилцаа холбооны ажилтан

Том авлига гэдэг нь улс төр, санхүү, захиргааны томоохон албан тушаалтнууд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад албан тушаалаа ашиглан их хэмжээний мөнгөн дүнтэй хувийн ашиг хонжоо олох явдал юм. Жишээ нь:

Зөвшөөрлийг хүчингүй болгох, хэн нэгэнд ямар нэг салбарт давуу эрх эдлэх зөвшөөрөл олгох,
Төр, засгийн шийдвэр гаргагчид уралдаант шалгаруулалт (тендер)-ын нөхцөл болон жишиг стандартыг өөрчлөх,
Гадаадын иргэн, хуулийн этгээдээс хахууль авч гадны банкинд данс нээлгэх,
Татвараас чөлөөлөх,
Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зэрэг болно.[18]

Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал, түүний эсрэг тэмцэл:

2007 оны байдлаар “Транспэрэнси интернешнл”-аас 179 орныг авлигын түвшингээр индексжүүлснээр Монгол улс 3,0 оноотойгоор 99 дугаарт жагсч байсан. 2008 онд 180 улсыг авлигын түвшингээр индексжүүлэхэд Монгол Улс 3,0 оноотой буюу 102 дүгээрт жагссан үзүүлэлт гаргасан байна. Харин 2010 оны үзүүлэлтээр 2.7 оноотой буюу Этиофи, Мали, Мозамбик, Танзани, Вьетнам зэрэг орнуудтай адил үзүүлэлттэйгээр 116[19] байранд орсон нь даруй 0.3 хувиар ухарсан хэрэг болсон байна. Монгол Улс дахь авлигын байдлыг судалсан олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар монголчуудын зан заншил, түүний дотор нутгархах, найзархах, гэр бүлсэх үзэл хандлага нь авлигыг өөгшүүлэх нийгмийн болон соёлын суурь нөлөө болж

---

[18] Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажилагааны гарын авлага. УБ., 2010.3-4 дэх тал.

[19] www.transparency.org/policy_research/surveys_indices/cpi/2010/results Corruption Perception Index 2010 Results хуудаснаас үзнэ үү. 2010 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

байгааг тэмдэглэхийн сацуу улс төр, эдийн засгийн гадаад болон дотоод байдал ихээхэн нөлөөлсөн гэж үзэж байна.

Мөн Монгол Улсын Их Хурал 2006 онд Авлигын эсрэг хуулийг баталж бие даасан, хараат бус Авлигатай тэмцэх газрыг байгуулсан. Авлигын эсрэг Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индекс гарган олон нийтэд мэдээлэх" үүргийг Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд даалгажээ.

УИХ-ын 2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 25 дугаар тогтоолоор "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд"-ыг баталсан билээ. Монгол Улс 2000 оны 9 дүгээр сард АНУ-ын нийслэл Вашингтон хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын дээд хэмжээний уулзалтаас гаргасан "Мянганы тунхаглал" дахь Мянганы хөгжлийн найман зорилго дээр "Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх" гэсэн 9 дэх зорилгыг шинээр нэмж баталсан. Энэхүү зорилгын "Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх" гэсэн 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх гурван төрлийн үзүүлэлт байгаагийн нэг нь авлигын индекс юм. Авлигын индекс гэдэг нь авлига хэмээх гэмт явдлын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц бөгөөд уг үзэгдлийн орон зайн болон цаг хугацааны өөрчлөлтийг илтгэн харуулах юм. Авлигын индексийг тооцож мэдээлэх нь авлигын эсрэг үйл ажиллагааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах; хэрэгжилтийг үнэлж дүгнэх; олон нийтийг авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах ач холбогдолтой байдаг.

Авлигын индексийг тооцох чиглэлээр Олон нийтийн төсөөллийн судалгааг 2009 оны 10 дугаар сард, Шинжээчдийн төсөөллийн судалгаа болон Төрийн байгууллагын авлигын эрсдлийн өөрийн үнэлгээний судалгаа буюу авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн судалгааг 2009 оны 11 дүгээр сард зохион байгуулан явуулж үр дүнг нэгтгэн гаргажээ. Мөн баримтын судалгааг сүүлийн 2 жилийн буюу 2008-2009 оны тоо мэдээллийг хамруулан хийсэн байдаг. Батлагдсан аргачлалын дагуу түүнд дурдсан үзүүлэлтүүдээр авлигын индексийг тооцоход 0.64 гарчээ. Авлигын индексийг бүрдүүлэгч авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт 0.74 гарсан бол авлигын цар хүрээний үзүүлэлтийг тус бүрээр нь авч үзэхэд олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт 0.75 гарч байна. Өөрөөр хэлбэл, олон нийт, шинжээчид дунджаар Монгол Улсад авлига түгээмэл байна гэж 75 хувь нь үзжээ.[20]

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь Монгол Улсад авлигатай тэмцэх үйл ажиллагааны олон улсын эрх зүйн үндэс болж байна. Монгол Улс тус конвенцийг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөгдөхөөр болсон.

Энэхүү конвенцийн зорилго нь авлигаас урьдчилан сэргийлэх нь илүү үр ашигтай бөгөөд үр дүнтэй тэмцэх арга хэмжээг дэмжиж, бэхжүүлэх; авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх тухайлбал хөрөнгө буцааж олгох талаар олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг хөгжүүлэх, хөнгөвчлөх, дэмжих; төрийн хэрэг, төрийн эд хөрөнгийн шударга, хариуцлагатай, зохистой удирдлагыг дэмжихэд чиглэгдсэн юм. Эл конвенцид авлигаас урьдчилан сэргийлэх арга

[20] http://www.iaac.mn/pdf/ssha/Avligiin_indexiin_ur_dun_2009.pdf

хэмжээ, гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах, олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө буцааж олгох арга хэмжээ, техникийн туслалцаа ба мэдээлэл солилцоо зэргийг заасан юм.

Үндсэн хууль бол аливаа улсын хамгийн дээд хүчин чадалтай эрх зүйн баримт бичиг бөгөөд түүнд авлигатай тэмцэх төрийн бодлогыг хуульчилсан заалтууд бий. Тухайлбал, Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь шударга ёс, хууль дээдлэх ёс болохыг заасан юм. Мөн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч ...Үндсэн хууль, бусад хуулийг чанд баримтлан ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана” хэмээсэн нь авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хуулийн эрх зүйн үндэс болдог.

УИХ 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр батлан гаргасан Авлигын эсрэг хууль нь Монгол Улсад авлигатай тэмцэх эрх зүйн зохицуулалтыг тогтоосон гол хууль юм. Эл хуулиар авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний дагуу авлигатай тэмцэх бие даасан байгууллагыг байгуулжээ.

Энэ хууль нь 6 бүлэг, 35 зүйлээс бүрдэнэ.

- Нийтлэг үндэслэл гэсэн I бүлэгт хуулийн зорилт, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, хуулийн үйлчлэлд хамаарагдах этгээдийн тухай заажээ.
- Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэсэн II бүлэгт олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглох зүйл, авлигын тухай мэдэгдэх, авлигын талаар өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх тухай заасан байна.
- Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах гэсэн III бүлэгт хөрөнгө, орлогын мэдүүлэг, тэдгээрийг бүртгэх, хадгалах, нууцлал, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл, хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх тухай зохицуулалт бий.
- Авлигатай тэмцэх байгууллага, түүний бүрэн эрх гэсэн IV бүлэгт авлигатай тэмцэх газар, түүний үйл ажиллагааны зарчим, бүтэц, авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх, авлигатай тэмцэх газрын албан хаагчид тавигдах шаардлага, авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа, чөлөөлөх, түдгэлзүүлэх, огцруулах, авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил, хэрэг бүргэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн эрх, авлигатай тэмцэх газрын албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд тавих хяналт, олон нийтийн зөвлөлийн тухай хэм хэмжээг тогтоожээ.
- Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны баталгаа гэсэн V бүлэгт улс төр, эдийн засаг, нийгэм, хууль зүйн ба бусад баталгааны тухай заасан байна.
- Бусад зүйл гэсэн VI бүлэгт авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, авлигын гэмт хэргийн улмаас учирсан үр дагаврыг арилгах тухай заажээ.

Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг тогтоосон бөгөөд тэдгээрээс нэлээд нь авлигатай холбоотой байна. Жишээлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах; Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон

Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих; албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэх; нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэх, бусдад зуучлах; хувийн ашиг сонирхлын үүднээс дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, санхүүгийн болон бусад туслалцаа авахыг хоригложээ.

Эрүүгийн хууль нь нийгэмд аюултай ямар хэргийг гэмт хэрэгт тооцох, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулах ял, түүнээс чөлөөлөх журмыг зохицуулна. 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд авлигатай холбоотой хэд хэдэн гэмт хэргийн (хахууль авах, хахууль өгөх, хахууль зуучлах, эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, эрх мэдлээ хэтрүүлэх зэрэг) тухай зааснаараа авлигатай тэмцэх эрх зүйн зохицуулалтын нэгэн эх сурвалж болдог.

Бусад хууль нь авлигыг илрүүлэх, түүнийг таслах зогсоох, учирсан хохирлыг арилгах явцад Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Иргэний хууль зэрэг хэд хэдэн хуулийг хэрэглэх зайлшгүй шаардлага үүдэн гарна.[21]

Монгол оронд авлига гарах гол шалтгаанууд нь судалгааны тайлангуудаас авч үзвэл дараах байдлаар илэрч байна. Манай орны хувьд нэг талаас нийгмийн байгууллын өөрчлөлт буюу зах зээл, ардчилалд шилжих шилжилт нь авлига өргөжин хөгжих нийгэм эдийн засгийн үндэс болж, нөгөө талаас төрийн бодлого, шийдвэрийн оновчтой бус байдал, төрийн механизмын алдаатай үйл ажиллагаагаас үүдэлтэй байна. Өнөөдөр манай төрийн аппаратад эрх мэдлийн төвлөрөл хүчтэй байгаа бөгөөд эдийн засгийн харилцааг зохицуулахад төрийн оролцоо давамгайлж, хүнд сурталжсан үр ашиггүй тогтолцоог бий болгосон. Авлига даамжирч байгаа өөр нэг шалтгаан нь төрийн албан хаагчдын эрх мэдэл, үүрэг хариуцлагын уялдаа холбоо сул, эрх мэдэл эзэмшихийн хэрээр нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарлах явдал тааруу байгаа явдал билээ.

Түүнчлэн Монгол Улсад хууль хэрэгждэггүй, хуулийн дагуу ногдуулдаг шийтгэл нь бодит үр дүнгээ өгдөггүй болтлоо хээл хахуулийн асуудал хавтгайрсан болохыг онцлон тэмдэглээд хээл хахуулийг арилгах талаар "Шийдвэртэй арга хэмжээ авахгүй бол байдал улам даамжирч, Монгол Улсын цаашдын хөгжилд нөлөөлж болзошгүй"[22] гэж дүгнэжээ. Ялангуяа төрийн албан хаагчид авлига авагчдыг тэргүүлж, бусдад нийгмийн үйлчилгээ үзүүлдэг эмнэлэг, боловсролын байгууллагууд ч авлигад автсан байгаа нь олон түмнийг хохироогоод зогсохгүй тэднийг түүнтэй эвлэрэхэд хүргэж, нийгэмд авлига байх ёстой, хэвийн үзэгдэл мэт сэтгэгдлийг суулгаж байгаа нь өнөөгийн Монголын нийгмийн эмгэнэл болсон байна.

---

[21] С. Нарангэрэл нар. Авлига, түүнтэй тэмцэх нь. УБ., 2007.3-6 дахь тал.

[22] Үндэсний шударга ёсны үзүүлэлтийн èíâåêñ

2004 оны судалгаагаар авлигын дараах хэв маягийг тодорхойлсон байна. Үүнд:

- Авлигын хамгийн түгээмэл хэв маяг нь тусгай зөвшөөрөл лиценз авах, УИХ, Засгийн газраар тогтоол гаргуулах, тендэр шалгаруулалтад нөлөөлөх, хувийн компани засгийн газрын захиалга авч ажил гүйцэтгэх зэрэг хэлбэрүүд бүрдүүлдэг бөгөөд ил, далд хэлбэрээр шийдвэрт шахалт үзүүлэх улс төрийн лоббитой холбон авч үзэж болно.
- Хоёр дахь хэв маягийн авлигыг "бизнесийнх" гэж нэрлэж болох бөгөөд газрын зөвшөөрөл олгох, хувьчлалд давуу нөхцөл олж авах, банкны хууль тогтоомжоос гадуур зээл олгох, ах дүү танил талаа албан тушаалд томилох дэвшүүлэх зэрэг хэлбэрүүд энэхүү хэв маягийг бүрдүүлдэг юм.
- Авлигын гурав дахь хэв маягт хилээр их хэмжээний бараа оруулах гаргах, хилээр машины наймаа хийх, спирт тамхи оруулах хэмээх гэмт хэрэг, луйварын шинжтэй төрлүүд ордог.
- Дөрөв дэх хэв маягт сургууль курс явуулах эрх олгох, хүүхэд сургуульд элсүүлэх, цэргийн албанаас чөлөөлөх гэх мэт төрлүүд ордог. Өөрөөр хэлбэл, энэ хэв маягийг нийгэмд байр сууурь, статусаа бэхжүүлэхэд чиглэсэн авлигал гэж нэрлэж болно.
- Эцэст нь УИХ-ын суудлын мөнгө, нам болон сонгуулийн авлигын хэв маягийг бүрдүүлдэг байна.

Монгол Улсын хувьд захиргааны болоод улс төрийн түвшний аль алинд нь буй авлигыг хазаарлах талаар дараах арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай байна. Үүнд:

- Засгийн газрын агентлагуудын доторх хяналт шалгалт, ил тод байдлыг бий болгох,
- Иргэдийн үр дүнтэй хяналтын механизм, мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх
- НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, авлигатай тэмцэх чиглэлээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих
- Сонирхлын зөрчилдөөнийг хязгаарлах, иргэдэд үзүүлэх үйлчилгээнд шинэчлэл хийх
- Иргэд, бизнес эрхлэгчид болон Засгийн газрын хооронд хийгддэг хэлцлүүдийг тухайлбал бараа үйлчилгээ худалдан авах, гааль, газар ашиглалт зэргийн зөвшөөрөл, лицензийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх
- Засаг төрийн ихэнх үйл ажиллагаа ил тод бус, энэ талаар мэдээлэл авах боломжгүй байгаа нь хариуцлагыг бүхий л талаар сулруулж, энэ нь улмаар хэвлэл мэдээллийн үр ашиггүй байдалд нэрмээс болж, бодлого хэлэлцэх, төрийн байгууллагад хяналт тавих үйл явцад иргэд оролцох боломжийг хязгаарлаж байна.

ТББ-уудаас санаачлан хэрэгжүүлсэн зарим судалгаа, нөлөөллийн ажлуудыг дэлгэрүүлэн авч үзье. АТГ-аас төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, иргэдийн оролцоог хангах талаар 18 зүйл бүхий зөвлөмж бичиг боловсруулж 2007 оны дөрөвдүгээр сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн билээ. Дээрх зөвлөмжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тандах зорилгоор төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагад ажиглалт, сурвалжлагын болон баримт бичгийн судалгаа хийж, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаарх гомдол саналыг хүлээн авах 1977 /энгийн ярианы тарифтай/ утсыг нээлттэй ажиллуулан ирсэн мэдээллийг судлан үзэж, тухайн байгууллагын удирдлагад АТГ-аас үйл ажиллагаандаа гаргасан зөрчлөө нэн даруй арилгах арга хэмжээ авч, эргэж мэдээлэхийг сануулсан шаардлага хүргүүлэн ажиллажээ. Энэхүү судалгааны хүрээнд 2007 оны 07 дугаар сард 1977 утсаар иргэдээс нийт 46 гомдол, 4 саналыг авч цаг тухайд АТГ-т хүргүүллээ. Үүнийг төрийн байгууллагууд үндэслэлгүйгээр нэмэлт

төлбөр авах, хүнд суртал гаргах, хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй, хүнд суртал гаргах, хууль дүрмийн дагуу асуудлыг шийдэж өгөхгүй удах зэрэг зөрчлүүд элбэг тохиолдож байна.

Авлигатай тэмцэх сэтгүүлчдийн клуб төрийн бус байгууллагаас Нээлттэй нийгэм форумын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийн мониторингийг төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд дээр хийжээ. Энэ мониторинг Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар хийгдэж Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл буюу албан тушаалтнуудад хориглосон заалтууд, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хэрэгжилтийг голлон анхаарч, судалсан байна.

Авлигын нийгмийн хор аюул

Авлигад идэгдсэн улс хэзээ ч хөгжин дэвждэггүй. Авлига нь нийгмийн тогтвортой ба аюулгүй байдалд хүндрэл бэрхшээл учруулж, ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс суртахууны үнэт зүйлсэд аюул заналхийлэл учруулж, шударга ёс, хууль дээдлэх ёсны үнэлэмжийг нийгэмд үлэмж хэмжээгээр сулруулдаг. Төрийн албаны ашиг сонирхол, нэр хүндийг үлэмж доройтуулж, иргэдийн хууль ёсны эрх ба ашиг сонирхлыг ноцтой хөнддөг.[23]

Авлига гэгч хэдийгээр дэлхийн аль ч улс оронд ямар нэгэн хэмжээгээр байгаа боловч тухайн улсын улс төр, эдийн засгийн тогтолцоо, засаглалын арга барил, олон нийтийн сэтгэл зүйгээс шалтгаалан харилцан адилгүйгээр илэрч байдаг. Өнөөдөр авлига нь тухайн орны хөгжил, эдийн засгийн өсөлтөд сүйрэл нүүрлүүлж байгаа нь нэгэнт тодорхой болж, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь Монгол Улс төдийгүй дэлхий нийтийн анхаарал татсан чухал асуудлын нэг болжээ.

Судлаачид авлигыг төрөл бүрийн шалгуураар ангилдаг. Тухайлбал, авлигын хэргийн криминаль шинжээр нь авлигачдыг махан идэшт, өвсөн идэшт гэсэн бүлэгт хуваадаг. Харин нийгэмд үзүүлэх нөлөөгөөр нь үндсэн гурван хэлбэрт авч үздэг.

Тохиолдлын хэлбэр. Авлига тохиолдлын хэлбэрт байхад хааяа гарсан ганц хоёр удаагийн өгөө, авааг дарга, захирлууд нь тэр орчинд нь шийдвэрлэж чадна. Авлигад өртсөн ажилтныг ажлаас халж шүүхэд шилжүүлэх, гар цайлгахыг оролдож байгаа хүмүүсийг илчилж үйлдлийг зогсоосноор авлигын асуудлыг шуурхай шийдвэрлэх боломжтой.

Зохион байгуулалттай хэлбэр. Авлигын энэ хэлбэрт өндөр тушаалын албан тушаалтнууд хоорондоо болон доошоогооо хуйвалдааны шинжтэй зохион байгуулалтад орж авлигын хүрээ, өглөг авлигын хэмжээг нэмэгдүүлдэг. Намайг илчилбэл чамайг ч адил илчилнэ гэсэн сүрдүүлгийн уур амьсгал төрийн ажилтнуудын дунд, байгууллагын орчинд бий болсон байна. Гэхдээ авлигатай тэмцэх хатуу бодлоготойгоор гарч ирсэн шинэ удирдагчийг дэмжих, байгууллагыг бүтцийн өөрчлөлтөд оруулах зэрэг салбарын шинэтгэл явуулснаар энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой.

---

[23] Авлига, түүнтэй тэмцэх нь. УБ.,2007. 2 дахь тал.

Хямралт хэлбэр. Энэ шатанд хувийн болон төрийн салбарынхны хоорондын эдийн засгийн солилцоо ердийн үзэгдэл болж авлигыг арилгах боломж, нөхцөл байхгүй мэт сэтгэгдэл нийтэд төрнө. Дарга, албан тушаалтнуудыг солиод ч, байгууллагыг бүтцийн өөрчлөлтөд оруулаад ч тэр болгон байдал өөрчлөгдөхгүй, хувийн салбарынхан улс төрд эрээ цээргүй хутгалдаж, төрийн ёс зүй гэсэн ойлголт үндсэндээ устана.

Авлигын хор уршиг нь дараах нөхцөл байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Нийгмийн тогтворгүй байдал үүсч, ардчилсан тогтолцоо, түүний үнэт зүйлс, шударга ёс болон нийгэмд тогтсон ёс зүй үгүйсгэгдэж, хүмүүс хуулийг дээдлэхгүй болдог;
- Мөнгө угаах, хүн худалдах зэрэг эдийн засгийн зохион байгуулалттай гэмт хэрэг өсдөг;
- Авлигачид улсын нөөц баялагт хохирол учруулдаг. Ингэснээр нийгмийн тогтвортой байдал, хөгжилд аюул заналхийлдэг.

Авлига нь гэмт явдал болохын хувьд бүх л гэмт хэрэгт байдаг нийтлэг болон зөвхөн авлигатай холбогдох тусгай шинжтэй. Авлига нь нуугдмал шинжтэй, хор уршиг нь шууд тодорхой хүнд тусдаггүй, далдуур улс орны нийтлэг эрх ашигт хохирол учруулж байдаг, эдийн засгийн болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй нягт уялдаатай зэрэг онцлог шинжүүдтэй.[24]

Авлигатай тэмцэх олон улсын хандлага, туршлага

Авлигатай тэмцэх олон улсын байгууллага болох “Транспэрэнси интернэшнл”-ийн судалгаагаар авлига улс орнуудад нэмэгдэж байгаа нь тогтоогджээ. Тус байгууллагаас Авлигын олон улсын индексийг тодорхойлохын тулд жил бүр бизнес эрхлэгчид болон төрийн албан хаагчдыг оролцуулан өргөн хэмжээний санал асуулга авч, ямар улс оронд авлига ямар хэмжээнд тохиолдож байгааг тодорхойлдог.

Авлига нь ихэвчлэн улс төрийн засаглал нь тогтворгүй, дотоодын зөрчил, үймээнтэй улс орнуудад түгээмэл илэрч, улмаар бэхжин тогтдог. Харин жагсаалтын эхэнд буй улс орнууд нь удаан хугацааны ардчилсан дэглэм, тогтвортой байдал, хуулийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын үр дүнтэй үйл ажиллагааны үр дүнд амжилтад хүрснийг харуулж байдаг.

Тус байгууллагын тэргүүн Петер Ейген “Авлига бол ядуурald хүргэх хамгийн гол нөхцөл бөгөөд мөн ядуурлыг бууруулахад хамгийн гол саад болж буй хүчин зүйл” гэж тэмдэглэжээ. Улмаар тус байгууллагын тэмдэглэснээр “Авлига бол байгалийн гамшигтай адил гэнэт тохиолдож болох давагдашгүй хүчин зүйл биш. Гэхдээ энэ үзэгдэл дэлхийн олон сая эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд залуусын өмнө буй олон олон боломжуудыг хулгайлж байгаа тул тэдний эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. 2015 он гэхэд дэлхийн ядуу хүн амын тоог хоёр дахин багасгана гэсэн Мянганы хөгжлийн зорилтод хүрэхийн тулд дэлхийн улс орнууд хичээх хэрэгтэй. Хүмүүсийг ядуурлаас чөлөөлөхийн тулд авлигаас ангижрах нь нэн тэргүүний зорилго болж байна”[25] хэмээн мэдэгдсэн байна.

---

[24] С. Нарангэрэл нар. Авлига, түүнтэй тэмцэх нь. УБ.,2007.24-26 дахь тал.

[25] * http://ww1.transparency.org/cpi/2005/2005.10.18.cpi.en.html

Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал нь үндэсний төдийгүй дэлхийн нийтийн засаг төрийн бодлогын салшгүй хэсэг, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах нэгэн шалгуур болж байна.

Хөгжлийн тогтвортой байдлыг хангаж, ядуурлыг бууруулахад сайн засаглал нэн тэргүүнд ач холбогдолтой гэсэн нийтлэг зөвшилцөл олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд бий болсон билээ. Ардчилсан засаглалыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц 2005 оны 9 дүгээр сараас эхлэн хүчин төгөлдөр болсон явдал ба конвенцид нэгдсэн улс орны хүлээх нэг үүрэг нь авлигаас урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэх зохих ёсны бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авах явдал юм. Манай улс энэхүү конвенцид нэгдэн орсон бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудлаар эрх зүйн орчин, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх олон улсын хамтын ажиллагаа нь гэрээ, конвенцийн, олон улсын байгууллагын, хандивлагч байгууллагын, улс дамнасан корпорацийн түвшинд мөн хэрэгжиж байна. Авлигатай тэмцэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байгаа олон улсын гэрээ, хэлэлцээрүүд:

- Олон улсын бизнес гүйлгээ хийхэд гадаадын төрийн албан хаагчдыг хахуульдах явдалтай тэмцэх Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) -ын конвенц. 1997 он, Дэлхийн гаалийн газрын тунхаг 1993 он
- Авлигын эсрэг Лимагийн тунхаг 1997 он
- Гэмт хэргээс олсон орлогыг хураах, баривчлах, нэгжлэг хийх, мөнгө угаах үйл ажиллагааны тухай конвенц 1990 он
- Авлигын эсрэг Америкийн хамтын хэлэлцээр 1996 он
- Авлига, хээл хахуулийн эсрэг НҮБ-ын конвенц 1999 он[26] зэргийг нэрлэж болно.

Энэхүү олон улсын гэрээ болон хамтын ажиллагаанд нэгдэн орж авлигад тавих хяналтын механизм бүрдүүлэх, нэгдэн орсон олон улсын гэрээгээр тогтоосон стандартад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх нь илүү үр дүнд хүрдэг байна.

Дэлхийн улс орнуудын Авлигатай тэмцэж буй туршлага, бодлогын чиглэлийг дараах чиглэлд ангилан үздэг.

Эрүүгийн болон захиргааны хяналтын хандлага

Авлигатай тэмцэх явдалд эрүүгийн болон захиргааны хяналтын хөшүүрэг чухал үүрэгтэй хэвээр байна. Энэ хандлагын хүрээнд Авлигатай тэмцэх бодлого нь төрийн захиргааны үр дүнтэй хяналтын механизмыг эрүүгийн хуулийн заалттай хослуулж, улмаар тогтоон сахиулах явдлыг чухалчилдаг. Тухайлбал, төрийн алба хаагч хөрөнгийн эх үүсвэрээ тайлбарлаж чадаагүй тохиолдолд “хууль бусаар баяжсан” гэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн заалтууд батлагдаж байна.

“Жижиг төр”-ийн хандлага

[26] http://www.ifs.univie.ac.at/~uncjin/corrupt.htm

Жижиг төрийн хандлага нь төрийн үүрэг, оролцоог бууруулж, дүрэм, журмыг цөөрүүлэх замаар авлигыг хянах ёстой, ингэснээр түүнийг таслан зогсоох гол шийдэл гэж үздэг.

Улс төр-эдийн засгийн хандлага

Энэ хандлага нь төрийн эрх мэдлийг багасгахад бус харин ил тод байдал, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлснээр авлигыг хянах боломжтой гэж үздэг. Авлигын эсрэг тэмцэх бус харин макро эдийн засгийн тогтвортой байдал, зах зээлийн харилцаа, ардчиллыг хөгжүүлснээр авлига оршин тогтнох нөхцөлийг өөрчлөх хэрэгтэй гэж үздэг байна.

Мэдээлэл олж авах эрх

АНУ, Канад, Хонконг, Солонгос, Швед, Австрали, Шинэ Зеланд зэрэг орнууд Авлигатай тэмцэх бодлогын хүрээнд олон нийтийг Засгийн газрын талаарх мэдээлэл олж авах боломжийг өргөжүүлэх, улмаар төрийн үйл ажиллагаанд олон нийтийн санаа бодлыг хэвлэл мэдээлийн хэрэгслээр дамжуулан нөлөөлөх эрх зүйн зохицуулалт хийсэн нь ихээхэн үр дүнд хүрсэн гэж үздэг. Олон нийтийн мэдээлэл нь мэдээлийн гол эх сурвалж тул Авлигын эсрэг байгууллагын олонх нь мэдээлэл өгөх, авах  үйл ажиллагааг хялбарчлах механизмыг бий болгодог. Авлигын талаар мэдээлэл өгсний төлөө шийтгэгдэхээс айж байгаа байдлаас гарахын тулд нэргүй мэдээлэл буюу гэрчийг хамгаалах явдлыг Авлигатай тэмцэх стратегийн чухал хэсэг гэж үзнэ.

“Олон нийтийн шударга байдалд тулгуурласан” хандлага

Энэ хандлага нь “Муу зүйл хийвэл илэрч баригдана, сайн зүйл хийвэл урамшил хүртэх боломжтой“ гэсэн энгийн логикт тулгуурласан, төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэхэд гол анхаарлаа хандуулсан байна. Төрийн албан хаагчдыг авлигад өртөх магадлалыг багасгах үүднээс төрөөс байнга урамшуулж байх, төрийн албаны давуу талуудыг бий болгох аргыг олон улсад түгээмэл хэрэглэж байна. Төрийн албаны хараат бус байдлыг ёс зүйн дүрмээр зохицуулж, бизнес, улс төр болон төрийн алба хоорондын ашиг сонирхлын зөрчил байгаа нөхцөлд төрийн албан хаагч үүнийгээ мэдээлэх үүргийг онцгойлон хүлээх нь төрийн албыг “цэвэр байлгах үндэс юм. Тодорхой албан тушаалтнуудын хувьд олон нийтэд Авлигын асуудал эрхэлсэн албанд орлогоо тайлагнах нь мөн л нээлттэй байх, авлигыг хянах бололцоог олгоно. Ёс зүйн дүрэм нь тодорхой, ойлгомжтой, эргээд биелүүлэх болон хянах, сахилгын шийтгэл ногдуулахад боломжтой байх нь чухал.

Авлигатай тэмцэх бие даасан байгууллага

Авлигатай тэмцэх бодлогын өөр нэг тэргүүлэх чиглэл нь Авлигын эсрэг бие даасан байгууллага юм. Австрали, Хонгконг, Ямайк /Авлигын эсрэг бие даасан комисс/, Сингапур /Авлигад автсан хэргийг шалгах хороо/, Тайланд /Авлигын эсрэг үндэсний комисс/, Уганда /Засгийн газрын Ерөнхий хянан шалгагч/ зэрэг орнуудад авлига болон эдийн засгийн хэрэг, зөрчлийг шалгах, авлигаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, авлигын хэргийн хор хөнөөлийг нийтэд таниулах, авлигатай тэмцэхэд олон нийтийн дэмжлэгийг авахад чиглэсэн бие даасан үйл ажиллагаа явуулдаг байгууллага байдаг байна.

“Олон чиглэлт стратеги” хандлага

Авлигын үндэс нь засаг төрийн  сул дорой байдалд тулгуурлаж, аажмаар өргөжиж байгаа тул ардчиллыг гүнзгийрүүлэх, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын эрх мэдлийг багасгах, хяналт, хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгохыг онцолдог.

Өнөө үед жирийн иргэдээс эхлээд олон улсын байгууллагууд авлига нь эдийн засгийн өсөлт хөгжлийн хамгийн гол дайсан гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрсөөр байна. Тухайлбал, Дэлхийн банкнаас авлигыг эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх болон ядуурлыг бууруулахад саад тушаа болж байгаа гол хүчин зүйлсийн нэг гэдгийг нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд 1996 оноос өөрийн гишүүн орнууддаа авлигын эсрэг 600 гаруй хөтөлбөр болон засаглалын санаачилгуудыг дэмжин ажилласан байна. 1996 оноос Дэлхийн банк (зээлийн) гэрээг цуцлах үндсэн нөхцөл нь тухайн улсын авлигын үзүүлэлт байх тухай өөрийн зааварчилгадаа тусгасан байна. Дэлхийн Банк нь улс төрийн ил тод байдал, хариуцлага тооцох чадвар, байдал, иргэний нийгмийн оролцоо болон хувийн секторын өрсөлдөх чадвар зэрэг үзүүлэлтийг сайжруулснаар авлигатай үр дүнтэй тэмцэх боломжтой хэмээн vздэг.

Хэдийгээр ард иргэд авлига хор уршигтай гэдгийг ерөнхийд нь төсөөлдөг хэдий ч үнэн хэрэгтээ хэчнээн их уршиг дагуулдаг талаар туйлын бага мэдлэгтэй байдаг. Тиймээс тэд авлигыг бууруулснаар ахуй амьдрал нь хэрхэн сайжрах вэ гэдгийг бодитойгоор ухамсарлаж чаддаггүй.

Авлигын эсрэг стратегийг хэрэгжүүлэхэд сургалт, соён гэгээрүүлэх, сурталчлах ажил чухал байдаг. Хонгконгийн Авлигын эсрэг хараат бус комисс нь мэдээллийг нийтэд хүргэх өвөрмөц хөтөлбөртэй ба авлигын тухай мэдээллийг олон нийтэд түгээхийн тулд хэвлэлийн мэдээ, нийтийн зар сурталчилгаа, ярилцлага, баримт бичиг, зурагт хуудас, мэдээллийн товхимол, хурал цуглаан, олон нийтэд хандаж үг хэлэх зэргийг ашиглахын хамт сургууль, их сургуулиудтай хамтран ажилладаг. Залууст зориулсан биеийн тамир, соёл, цэнгээний арга хэмжээг санхүүжүүлж, авлигын эсрэг сэдэвт анхаарал хандуулж байна.

Ийнхүү дэлхийн улс орнууд авлигатай янз бүрийн арга замаар тэмцэж байгаа нь зохих үр дүнд хүрч байгаа боловч аль нэг орны туршлагыг нөгөө улс орон шууд хуулбарлан хэрэглэх явдал нь хүссэн үр дүнд хүрэхгүй байгаа талаар энэхүү чиглэлээр судалгаа шинжилгээ хийж байгаа холбогдох байгууллагууд саналаа хэлсээр байгаа.

Зүүн Азийн туршлагаас харахад, ардчиллын чанарыг үлэмж хэмжээгээр тодорхойлдог дор хаяж гурван чухал хүчин зүйл байна. Нэгдүгээрт, олон нийтийн улс төрийн соёл юм. Хэрвээ дийлэнх иргэд улс төрийн үйл явцад анхааралтай хандаж, эрх чөлөө, хязгаарлагдмал төр, ардчилсан тайлагнах ёс, эрх зүйт төр, хамгаалах эрх зэрэг зарчмуудыг тууштай баримталж байвал төрийн албан тушаалтнууд сайн засгийн ёс горимыг дагахаас өөр аргагүй болно. Хувь хүний эрх чөлөөнд халдсан, хууль бус үйлдэл хийсэн, авлига авсан төрий албан хаагчид сонгуулиар байраа тавьж өгнө гэж санаа зовинох болно. Хоёрдугаарт, улс төрийн элитүүд. Улс орны оюун санаа, соёл, бизнес, нийгмийн байгууллагуудын манлайлагчид болон төрийн бүх гол удирдагчид ардчиллын хэм хэмжээ, ёс горимыг баримтлахгүй бол ардчиллын чанар муу байх нь гарцаагүй. Эцэст нь иргэний нийгэм мөн ардчиллын чанарыг тодорхойлоход чухал үүрэгтэй. Хүчтэй иргэний нийгэм, иргэний байгууллын уламжлал нь улс төрчид, намуудыг ардчилалд

түлхэх амин чухал нөхцөл юм. Ийм иргэний нийгэм нь бүхлээрээ төрийн албан хаагчдыг хүчтэй хянан шахах, шаардах хүч болдог билээ.[27]

Авлигатай тэмцэх талаар дэлхийн улс орнуудын туршлагуудын талаар http://www.transparency.org хаягаар хандан үзэх боломжтой. Мөн энэ хаягаар "Транспэрэнси интернешнл" байгууллагаас авлигатай тэмцэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцах боломжтой.

## 3. БОЛОВСРОЛД АВЛИГА БИЙ ЮУ?

Ерөнхий боловсролын сургуульд хичээлээ заагаад явж байхад авлига авдаг гэж ярих нь хэр шударга вэ? гэж зарим багш нар, сургуулийн удирдлага, боловсролын яам боддог. Үнэхээр боловсролд авлига байдаг уу, багш, сурган хүмүүжүүлэгчид, боловсролын салбарынхан үүнийг хүлээн зөвшөөрдөг үү, багш нар авлига авдаг уу, бидний сурагчид авлига өгдөг үү, шавь нараас маань багш нарын баяраар өгдөг чихрийн цуглуулга, нэг шил вино авлига мөн үү, тэд авлигыг шударга бус, муу үйл гэдэгт итгэж, түүнийг жигших үзэл хандлага, зан үйлтэй болж чадаж байна уу, ер нь авлигын талаар багш бид хэр зэрэг мэдлэгтэй вэ, бид өөрсдөө авлигыг тэвчих зан үйлд суралцсан уу гэээд боловсрол ба авлигын хүрээнд бид олон асуулт тавьж болно.

Авлига гэдэг зөвхөн эрх мэдэлтэн, насанд хүрэгчдэд тохиолддог зүйл ч биш ажээ. Хүүхдүүд
мөн л авлигад ... өртдөг. Харин
тэднийг авлига ... авах, өгөхийг зааж
бэлтгэдэг газар нь ... гэр бүлийнхэн
болон сургууль нь ... болдог гэвэл та
үнэмших үү.

> Авлига байх ёстой үзэгдэл. Учир нь авлигагүй бол хэн ч хүссэн байр суурьтаа очих боломжгүй. Авлига авдаггүй багш байдаггүй.
>
> *"С-1" ТВ-ийн "Боловсрол ба Авлига" буланд оролцсон*

Азийн сангаас хийсэн судалгааны дүнгээс үзэхэд 18-29 насны залуучуудын 13.7 хувь нь авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрч, 39.2 хувь нь нийгэмд ихээхэн газар авсан хүнд суртлыг гэтлэн давах цорын ганц арга нь хээл хахууль өгөх явдал юм гэж үзсэн байна. Тэдний 35 хувь нь мөнгө байвал хээл хахууль өгнө, эсвэл хахууль төлөхгүй байхад туслах хэн нэгнийг хайх болно гэж 46.5 хувь нь мэдэгдсэн байна.

---

[27] Юн-хан Чу нар. Зүүн Ази дахь ардчилын чанар ба дэглэмийн легитим чанар. Азийн Барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2008.72 дахь тал.

Хоёр оролцогчийн нэг нь амьдралын үнэт зүйлээ эрх мэдэл, эд хөрөнгө гэжээ. Мөн мэргэжлээ сонгосны 32.9 хувь нь "надад туслах хүн бий", авлига гэдэг нь албан тушаалаа урвуулан ашиглах (37.2 хувь), өөрийн ажлаа гүйцэлдүүлэхийн тулд бусдад өгч буй төлбөр (29.6 хувь) гэдэг ойлголттой байгаагаас гадна авлига өгч авах асуудлаар тэд хариулахдаа "өөрт болон цаад хүнд маань ч ашигтай учир хүссэн ажлыг нь бүтээж өгөхийг хичээнэ" гэжээ. Үүнээс гадна эдгээр хүүхдүүдийн 82 хувь нь гэр бүл ойр дотын хүмүүс нь өөрсдийн нь төлөө авлигад өртөж байсныг мэднэ гэснээ ч нуугаагүй байна.

Авлига хээл хахуульд өртөмтгий байгууллагуудад боловсролын байгууллага 21.5 %-аар 4-рт орсон бол, авлигад өртсөн мэргэжлийн бүлэг, түүний хэлбэрт багш нэгдүгээр байрт бичигдсэн байна.

*Зориг сангаас хийсэн "Авлигатай тэмцэх үндэсний*

Хүүхэд залуучуудад авлигыг хүлээн зөвшөөрөх сэтгэхүй төлөвшиж байгааг судалгааны баримтууд харуулж байна. Иймээс тэднийг гэгээрүүлэх нарийн төвөгтэй үйл явц нь тодорхой хугацаанд тасралтгүй явагдаж байж үр дүнд хүрнэ (Зураг 2). Иймээс бид юуны өмнө ерөнхий боловсролын сургуульд суралцаж байх хугацаанд нь хүүхдийн нас, бие, сэтгэл зүйн онцлогт тохирсон, сонирхолтой хэлбэрээр, үр дүнтэй эзэмшүүлж чадвал олон хүнийг хамран, авлигын эсрэг боловсролын талаар наад захын мэдлэгтэй болгох хангалттай нөхцөл энд бий.

Боловсролын салбарын авлигыг аваад үзэхэд төлөвлөлт, удирдлагын түвшинд хамгийн их, түгээмэл байна гэж дээрх судалгаанд үзсэн байна. Үүнд сургуулийн барилга барихтай холбоотойгоор тендер зарлах, эд хөрөнгийг хувьдаа ашиглах, сургуулийн зураглал зэрэг багтдаг, мөн боловсон хүчин томилох, тушаал дээшлүүлэх, багш ажилд авах зэрэг тодорхой үйл ажиллагаануудад авлига хамгийн өргөн байна.

Эдгээр түвшинд багш нарын ёс зүйн хүрээнд ажил үйлчилгээ явуулах цар хүрээг гаргаж өгснөөс гадна ЕБС-аас илүү дээд боловсрол тэр дундаа хувийн сургуулиудад авлига маш их байгааг тогтоожээ.

Өдөр тутмын харилцаанд элбэг тохиолддог бэлэгний зохицуулалтын талаар авч үзье. Шагнал бэлэгтэй холбоотой зохицуулалтыг боловсролын байгууллагын ажилтнуудад таниулсан байх нь авлигаас сэргийлэх чухал чиглэл болдог. Мөнгө, ваучер, үзвэр үйлчилгээ, дайллага, цайллага, хөрөнгө, эрх зэрэг нэг хүний нөгөө хүнд өгч буй үнэ цэнэ бүхий зүйлийг бэлэг хэмээдэг. Бэлэг нь талархсан сэтгэлийн илэрхийлэл болж хариу төлбөргүй байдаг онцлогтой. Улс үндэстэн ба байгууллагын зан үйлийн хэм хэмжээнд нийцсэн хямд үнэтэй, удаан хэрэглээний бус бэлэг дурсгалын зүйлсийг жижиг бэлэг гэнэ. Жишээ нь, төдийлөн үнэтэй бус үзэг, алчуур, дурсгалын таваг, лонх дарс гэх мэт. Хахууль бол тус авахын тулд өгсөн бэлэг бөгөөд төрийн албан хаагчаас ажил албаа гүйцэтгэх зан үйлд нь нөлөөлөх, төрийн албаны шударга байдал, ёс зүйн дүрэм журмаас эсрэг үйлдэл хийлгэх зорилготой байдаг. Энд хамгийн түрүүнд ямар бэлгийг авч болохгүй вэ гэдэг асуулт гардаг. Таныг ямар нэгэн өрөнд оруулаагүй, ямар нэг юмны төлөөс, шан

харамж маягаар өгөөгүй, зөвшөөрөгдсөн үнийн дүнгээс доогуур үнэтэй бэлгийг авч болно. Хэн нэгэн ажил үүргээ биелүүлэхэд тань нөлөөлөх зорилготой бэлэг өгвөл авч болохгүй. Өөрөөр хэлбэл, танд ямар нэг өр төлөөс үүрүүлж буй, таны өгсөн санал ба зөвлөгөөний шан харамж маягтай өгч байгаа бэлгийг авч үл болно. Тэгэхээр хэн нэгэн танд бэлэг санал болговол зорилго, үнэ цэнэ, хэн өгч байгаа, ямар үед өгч байгааг нь үнэлж цэгнэсний дараа авах, үгүйгээ шийдэх хэрэгтэй байдаг ажээ.[28]

Ерөнхийдөө боловсролын авлигыг бий болгож нөлөөлж байгаа хүчин зүйлийг дараах байдлаар ангилсан байна. Үүнд,

Байгууллагын хүчин зүйл
Нийгэм, улс төрийн хүчин зүйл
Эдийн засгийн хүчин зүйл
Соёлын хүчин зүйл  зэрэг багтана.

*Багш нарын биеэ авч байдал, багшийн ёс зүйн хандлагад хүүхэд сургуульд оруулах, сурагчийг үнэлэх хоёр асуудалтай холбогдох авлига хамгийн түгээмэл байна гэж үзжээ. Түүнээс гадна тоног төхөөрөмж, хоол хүнс, сурах бичгийг хангах нийлүүлэх, тэтгэлэгт хөтөлбөр олгох, хувийн салбарт хувь нэмэр оруулах, шалгалт, дипломын ажил нь боловсролын салбар дахь авлигын давамгайлж байгаа хэсэг. Боловсролын салбарт авлигатай холбоотой шинээр гурван нэр томъёо гарч ирсэн байна. Неопотизм, Сивилретизм, хахууль гэсэн хэлбэрт*

ХАВСРАЛТ 1

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Авлига | Албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил |
| | Авлигаас урьдчилан сэргийлэх |
| | Авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолбор |
| Алтан дүрэм | “Ёс суртахууны алтан дүрэм” хэмээн нэрлэгддэг ёс суртахууны үндсэн зарчим |
| Ажлын байр | Ямар нэгэн ажил хэрэг, түүнтэй холбогдон гарах эрх, үүрэг, харилцаа |
| Ажил хэргийн нэр хүнд | Тодорхой байгууллага, хувь хүмүүсийн нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эерэг үнэлэмж, |
| Ардчилал | Засаглалын дээд эрх мэдэл нь ард түмэнд хамаардаг засаглалын хэлбэр |

[28] Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага. УБ., 2010.37-38 дахь тал.

| | |
|---|---|
| Ашиг хонжоо | Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдал |
| Бүлэг | Зорилго, үйл ажиллагаа, ашиг сонирхол зэргээрээ адил төстэй хувь хүмүүсийн нэгдэл. |
| Гэм буруу | Гэмт этгээд өөрийн үйлдлийн бурууг ойлгон ухаарах байдал |
| Гэм буруутан | Хууль бус үйлдэл хийсэн, бусдад хохирол учруулагч этгээд |
| Гэм хор | Гэм буруутай этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол |
| Гэр бүл | Гэрлэлт болон цусан төрлийн холбоогоор холбогдсон, нэгдмэл амьдрал бүхий хүмүүсийн нэгдэл. Нийгмийн зохион байгуулалтын хэлбэр |
| Гэрээ | Тодорхой эрх, үүргийг бий болгох, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн хувь хүн, байгууллагуудын хооронд хийгдсэн хэлцэл |
| Ёс зүй | Ёс суртахууны зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг судалдаг ухаан |
| Ёс суртахуун | Бусадтай харилцах харилцаандаа даган баримтлах зан үйлийн хэм хэмжээ, дүрмийн цогц |
| Ёс суртахууны зарчим | Юуг зөв, буруу, сайн, муу хэмээн ойлгохталаар нийгэмд тогтсон ёс суртахууны хэм хэмжээнүүдийн цогц |
| Ёс суртахууны эрхэм чанар | Хүмүүсийн амьдралд бичигдээгүй хууль болон үйлчилдэг зан үйлийн эерэг, сайн чанарууд |
| Иргэн | Тухайн улс орны хууль ёсны харъяалал бүхий хүн |
| Иргэний эрх | Тухайн улсын хуулиар иргэддээ тогтоож өгсөн эрх, эрх чөлөө |
| Иргэний үүрэг | Тухайн улсын хуулийн дагуу иргэдийн биелүүлбэл зохих шаардлагуудын цогц |
| Иргэний нийгмийн байгууллага | Хууль, дүрмээр зохицуулагддаг нийгэм, улс төр болон эдийн засгийн хүрээнд хоорондоо харилцаж буй зохион байгуулалттай иргэд, иргэдийн бүлэг |
| Конвенц | Тодорхой асуудлыг хэлэлцэн тохирч баталсан олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл |
| Мэдээлэл | Аливаа юмс үзэгдлүүдийг тодорхой дохио, тэмдгийн хэлбэрээр дамжуулж буй харилцаа |
| Мэргэжил | Тодорхой ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, чадвар дадлын цогц. |
| Нийгэм | Хүмүүсийн хамтын амьдрал, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр, Өөр хоорондоо харилцан үйлчлэлцэж буй хувь хүмүүс, бүлэг, байгууллагууд, тэдгээрийн хоорондын харилцааны цогц |
| Нийгмийн харилцаа | Хувь хүмүүс, бүлэг, байгууллагуудын хооронд үүсч буй тогтвортой, олон талт хэлхээ холбоо |
| Нэр төр | Аливаа хүнийг өөрөө болон нийгмийн зүгээс үнэлсэн үнэлэмж |

| | |
|---|---|
| Орлого | Тодорхой хугацаанд олж буй үр ашгийн мөнгөн илэрхийлэл |
| Оролцоо | Тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцох байдал, идэвх |
| Өмч | Ямар нэгэн үнэт чанар бүхий юмс үзэгдэл, тэдгээрийн ашиглалт, хэрэглээ |
| Өмчлөх эрх | Өмчийг худалдах, бэлэглэх зэрэг боломж бүхий эрх хэмжээ |
| Пакт | Хүний эрхийн асуудлаар улс орнуудад үүрэг хүлээлгэдэг олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл |
| Соён гэгээрүүлэх | Олон нийтэд аливаа асуудлыг ухуулан таниулах, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолбор |
| Сүүдрийн эдийн засаг | Эдийн засгийн хүрээн дэх хууль бус үйл ажиллагаа |
| Төрийн бус байгууллага | Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бусаар, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн бус байгууллага |
| Үндсэн хууль | Тухайн улсын хувьд даган мөрдөх гол хууль |
| Үнэт зүйлс | Ямар нэгэн юмсад агуулагдаж буй үнэт чанар, түүний үнэлэмж |
| Хамтралчид | Зөвлөлт Холбоот Улсын үед өмчөө нэгтгэсэн аж ахуй эрхлэгчид нэгдсэн удирдлага бүхий ажлын үр дүнг хамтын шийдвэрээр хуваарилж байв. Хөдөө тосгод дахь уг аж ахуйг хэлбэрт оролцогсдыг хамтралчид хэмээдэг. |
| Харилцаа | Ямар нэгэн мэдээлэл, үзэл бодол, хандлагыг дамжуулах цогц үйл явц |
| Хариуцагч | Гэм буруутай, төлбөр төлөгч тал |
| Хариуцлага | Гэм буруутай этгээд буруутай үйлдлийнхээ төлөө бусдын өмнө хүлээх үүрэг |
| Хохирол | Гэмт үйлдлийн үр дүнд бий болсон алдагдал, гэмтэл, төлбөр |
| Хууль | Төрөөс тогтоосон заавал биелүүлэх хэм хэмжээний цогц |
| Хуулийн этгээд | Өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, үүрэг бүхий байгууллагыг хуулийн этгээд гэнэ. |
| Хууль ёсны эрх | Хуулиар тогтоож, баталгаажуулсан эрх, эрх чөлөө |
| Хүний эрх | Хүнд хүн болж төрсний хувьд заясан боломжууд |
| Эдийн засаг | Хүн амын хэрэгцээг хангах, баялгийг бүтээхэд чиглэдэг нийгмийн харилцааны нэг хэлбэр |
| Эргэх холбоо | Аливаа юмсын хооронд үүсч буй эргэх хөдөлгөөн, дахин давтагдах байдал |
| Эрүүгийн хариуцлага | Хуулиар тогтоосон ял шийтгэл хүлээх гэм буруугийн төрөл |

ХАВСРАЛТ 2

## СУДАЛГААНЫ ӨГҮҮЛЛҮҮД

Стефан Мерл. “Өнөөгийн Оросын авлига нь Сталины гэрээс үү?” өгүүллээс

...ЗХУ-ын сүүдрийн эдийн засаг. Зах зээлийн тогтолцоотой харьцуулахад ЗХУ-ын сүүдрийн эдийн засаг огт өөр үүрэгтэй байсан. Тэрээр татвар төлөхөөс зайлсхийж хувийн ашиг хонжоо олохоос илүү албан ёсны эдийн засаг оршин тогтноход чухал үүрэгтэй байжээ. Иймээс тогтолцоо нь сүүдрийн эдийн засагтай шийдвэртэй тэмцэхээс зайлсхийж байсныг бид харах болно. Хэдийгээр энэ салбар дахь үйл ажиллагаа нь юуны өмнө олон нийтийн сонирхолтой холбоотой боловч хувь хүн баяжих боломжийг бүрдүүлж байсан. Харин зах зээлийн эдийн засагт энэ нь олон нийтийн сонирхлыг хөндөж байсан. Сүүдрийн эдийн засаг байгаагүй бол юу болох байсан бэ? гэж асуухад үүргийн ялгаа тод томруун харагдах болно. Зах зээлийн эдийн засагт үйлчилгээний салбарын үйл ажиллагаа буурч үүний хамтаар хууль ёсны үйл ажиллагаа болон улсын татварын орлого нэмэгдэнэ.

Харин Зөвлөлтийн тогтолцоонд үүний эсрэг сүүдрийн эдийн засаг нурахад албан ёсны төвлөрсөн эдийн засаг нэн даруй задран нурахад хүрэх байсан. Өөрөөр хэлбэл үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд материалаа олж авч чадахгүй хээл хахууль авахгүйгээр шийдвэр гаргадаггүй, хүнд сурталтнуудын дургүйцэл дийлдэхгүй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хүн амыг хүнсээр хангаж чадахгүйд хүрэх байсан. Зөвлөлтийн сүүдрийн эдийн засаг нь олон нийтийн болон хувийн салбарын хооронд хоёрдмол байр суурьтай байсны улмаас түүнийг албан ёсны эсвэл хууль бус гэсэн ангилалын алинд нь ч хамруулахад төвөгтэй. Хамтралчдын өөрсдийн үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нийлүүлэлт нь хуулиар зөвшөөрөгдсөн байсан. Хувь хүн баяжих асуудал болон эдийн засаг нийгмийн тогтолцооны чадавхийг хангах асуудлыг бие биенээс нь салгах боломжгүй байсан ч улмаар тэр үеийн дэглэм шийтгэл оноох арга хэмжээг хэрэгжүүлэх хэр сонирхолтой байсан бол гэсэн асуулт гарч ирнэ. Зөвлөлтийн сүүдрийн эдийн засгийг үнэлэхэд ёс зүйн шалгуур ч тохирохгүй. Учир нь авлига, хээл хахууль нь гэмт үйлдэл үү, аль эсвэл оршин тогтнох стратеги уу гэдгийг тодорхойлоход төвөгтэй.

Эхлээд бид 1930-аад оны эхээр Сталины үеэр тогтсон төвлөрсөн эдийн засгийн үйл ажиллагааны зарчмуудыг авч үзнэ. “Сүүдрийн эдийн засаг” гэдэг ойлголт нь тогтоосон дүрэм горимыг зөрчсөн үйлдвэрлэгчдийн цогц ажиллагаа, албан ёсны байгууллагатай зөрчилдөх албан бус байгууллагуудыг илэрхийлнэ.

Сталины үед бүрэлдсэн төвлөрсөн эдийн засгийн үйл ажиллагааны зарчмууд. Ойлгомжтой шалтгааны улмаас ихэвчлэн төлөвлөгөө биелэгдээгүй тохиолдолд гадны хяналт шалгалт хийгдэж байсан. Иймээс төлөвлөгөө биелэгдэх нь хянах шалгалтаас хамгаална. Гэхдээ тооцоонд өртөхгүй элемент заавал хадгалагдаж үлдэнэ. Илэрсэн зөрчилд гайхамшигтай зөөлөн шийтгэл оноож байсныг намын хянан шалгах хорооны шалгалтын практиктай холбоотой архивын материалууд харуулж байна. Ихэнхдээ үйлдвэрийн дарга сануулга өгнө, донгодно, зэмлэнэ. Ихэвчлэн “tolkaci” (ажлыг хийж гүйцэтгэхэд уриалах зохион байгуулах үүрэгтэй хүмүүс) нэрт хариуцлагад татна. Олон тооны үйлдвэрийн газрууд байсны улмаас гадны хяналт шалгалтад өртөх магадлал бага байсан. Хяналт шалгалтад ихэвчлэн асуудалтай салбар, өөрөөр хэлбэл, төлөвлөгөө биелүүлж чадаагүй, ингэснээр бусад салбаруудад бусад хор уршиг учруулж байсан

салбарууд өртөж байв. Хяналт шалгалтын том хэсэг яамдын дотор хийгдэж байсан. Энд амжилттай ажиллаж буй менежерүүд айх шаардлагагүй байсан.

Харин хууль дүрмийн дагуу ажиллаж иймээс ажилтад хүрч чаддаггүй үйлдвэрийн дарга эсвэл зарга гомдлоороо бусдын сөрөг хандлага дургүйцлийг бий болгосон дарга захирал нар дотоод хяналт шалгалтын золиос болж байжээ. Амжилттай менежерүүдийн эсрэг өгсөн гомдол заргыг шүүж байсан журам нь тэрхүү гомдол заргыг хүчингүй болгож байсан. Сталинд хаягласан гомдол заргын хувьд ч байдал ижил байсан. Өргөдлийг шалгаж үзээд холбогдох яам тамгын газар шилжүүлэх хэдий ч яам эцсээ хүртэл “өөрийн” менежерийг хамгаалдаг байсан. Үүний үр дүнд хяналт шалгалтын практик нь хууль дүрмийн зөрчил болон сүүдрийн эдийн засгийг хүлээн зөвшөөрч байв. 1930-аад оны эхээр бүрэлдэж дээр дурьдсан замбараагүй байдлаас үл хамааран Сталины үед үйлчилж байсан төвлөрсөн эдийн засгийн үйл ажиллагаа бодит нөхцөлүүд нь гэмт сүлжээ болж хөгжиж болох сонирхлыг бүлгэмүүд үүсэх суурийг бүрдүүлжээ. Үүний хамтаар ийм нөхцөлд шийдвэр гаргахдаа хойрог хүнд суртлаас эрс ялгаатай шинэ хэв маягийн үйлдвэрийн дарга гарч ирсэн. Амжилттай менежер нь эрсдэлтэй үйл хийх хандлагатай бөгөөд сүүдрийн эдийн засгийг хэрхэн ашиглахаа мэддэг хүн байв. ЗХУ-д удирдах албан тушаалыг зах зээлд бус харин өөрийн хувийн сүлжээ болон хар зах руу чиглэсэн “үйлдвэрийн эзний авъяастай” хүмүүс эзлэх болсон.

Өдөр тутмын оршин тогтнохуйг зохион байгуулах арга зам: Сүүдрийн эдийн засаг ямар ч саадгүй бэхэжсэнээр хүн ардад танил механизмуудыг эргэж хэрэглэх суурь тавигдсан. Үүнд хахууль, өөрт хэрэг болно гэсэн үүднээс өргөл барьц барих уламжлал болон мораль эдийн засаг буюу ёс суртахуунт эдийн засгийн зан үйл орно. Бүр хаант засаглалын Орос оронд Оросын хүн ам эдгээр үзэгдлүүдэд хандах өвөрмөц хандлагатай байсан. Хэдийгээр эдгээр гурван үзэгдлийн хооронд урсгал шилжиж байх боловч хоорондоо зааг ялгаатай болно.

Хахууль. Хахууль гэдэг нэр томьёо нь мөнгө төлөх замаар төрийн албан хаагчийн гаргах гэж буй тодорхой шийдвэрт нөлөөлөхийг хэлнэ. Хахуульд оролцогчид өмнө нь бие биенээ танихгүй хуулийн дагуу хахууль авч байгаа хүн, өгч байгаа хүний аль аль нь буруутай. Зөвлөлт орны хувьд хахуульд хандах хүн амын хандлага болон тогтолцооны үйл ажиллагааны чадавхид хахууль зайлшгүй шаардлагатай байдаг нь өвөрмөц онцлог нь болдог. Зөвлөлтийн олон иргэн төрийн албан хаагчдын хээл хахуулийг зохисгүй зүйл биш бөгөөд харин захиргаа ямар нэгэн шийдвэр гаргахад төвөгтэй боловч шаардлагатай бөгөөд урьдчилсан нөхцөл нь болдог хэмээн үзэж байсан.

Хахууль өгч буй хүн авлигад идэгдсэн, эсвэл чадавхи султай захиргааны өмнө өөрийн эрхийг эдэлж байна хэмээн үзэж байсан. Ийм арга замаар шийдвэр гаргаж, зорилгодоо хүрэх нь түүний хувьд оршин тогтнох нөхцөл байсан бөгөөд иймээс ёс зүйн хувьд буруутгах аргагүй байжээ. Ийм практик үүсч болох үндэс нь төрийн албан хаагчдын хуваарилалтын уламжлалтай холбоотой бөгөөд энэ нь магадгүй залхуу, үр өгөөж багатай гэдэг худалддаггүй Герман албан хаагчийн дүр зураглалаас ялгаатай. Төрийн албан хаагчид хээл хахуульд идэгдсэн гэсэн хүн амын итгэл үнэмшил нь бүр хаант засгийн үеэс үүсэлтэй. Дээд засаг нь хааны домогт үндэслэж орон нутгийн захиргааг чадавхгүй бөгөөд хахуульд идэгдсэн гэдгээр өөрийгөө харуулж байсан. Яг үүнд Сталины диктатур /дарангуйлан захирах засаглал/ суурилсан.

Тогтолцооны гэм зэмийг өөрөөсөө холдуулж, орон нутгийн засаг захиргааны хувь хүмүүстэй холбоотой түвшин рүү чиглүүлэхийн тулд бүх дутагдлыг хүн амтай шууд харилцаж ажилладаг хүмүүс рүү чиглүүлсэн. Төрийн албан хаагч чадваргүй бөгөөд хахуульд идэгдсэн байснаар төрөөс өөрт нь ногдуулсан үүргийг биелүүлж ингэсэнээр /хачирхалтай сонсогдож магадгүй ч/ дэглэмийг тогтоож /хуульчилж/, түүнд итгэл үнэмшлийг өгч байсан. Иймээс Зөвлөлтийн ард түмэн албан хаагчдын хахуульд идэгдсэнийг гэмт үйлдэл гэж үзэхгүй, харин төрийн албан хаагчийн мөн чанарт орших зан үйлийн хэлбэр хэмээн үзэж байв. Хэн хахууль өгөх, эсвэл хахууль авах нь нийгмийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн байсан. Сталины үед тогтолцоо өөрийн үүргийг биелүүлж, үйл ажиллагаагаа явуулахад хээл хахуулийн урьдчилсан нөхцөл болсон. Хээл хахуулиар дамжуулан хүмүүс өөр арга замаар шийдвэрлэх боломжгүй олон асуудлыг зохицуулж байсан. Хээл хахууль нь эхэндээ хялбар төдийгүй, илүү үр өгөөжтэй арга зам байсан. Жижиг хахууль нь хүн амын оршин тогтнох стратеги байсан. Олон хүмүүс ийм замаар өөрийн сонирхлыг дагаж байна хэмээн үзэж байлаа. Зарим хахуульчид хахууль, мөнгө өгөхийг тогтолцооны эсрэг эсэргүүцэл үзүүлж буй хэрэг гэж байсныг Каролины Хамфрей тэмдэглэсэн байна.

Үйл ажиллагаа явуулж, шийдвэр гаргаж чаддаг засаглалын нөхцөлд өөрийн сонирхол хэрэгцээг хахууль өгөх замаар хангах үзэгдэл байхгүй байх байсан. Улсын төвлөрсөн аж ахуйн адил дэглэм нь төрийн захиргааны хувьд орон нутгийн төлөөлөгчдийн хууль бус зан үйлд суурилсан. Төрийн албан хаагчид хахууль авах замаар шийдвэр авах дургүйцлээс холдож шийдвэр гаргаснаар тогтолцоо үйл ажиллагаатай байхад хувь нэмрээ оруулж байсан. Түүнчлэн төрийн захиргааны хувьд ч бид толгой эргүүлэм давхар ёс зүйтэй тулгарч байна. Албан ёсоор төр болон ард түмэн үзэл суртал, хээл хахууль болон хууль бус бусад зан үйлд дургүйцлийг илэрхийлдэг. Харин амьдрал практик дээр зөрүү үзэлтэй хүмүүс л тогтолцооны албан ёсны тодорхойлолтыг үнэнээр нь хүлээн авч, зарчмыг баримтлах гэж оролдож байсан.

Сталины дарангуйллын үед хээл хахууль хэр дэлгэрсэн, ард түмэн хахуулийг оршин тогтнох стратеги хэмээн үзэх үзэл ямар түвшинд байсныг 1950-иад оны эхээр хийгдсэн. Харийн дүрвэгсдийн асуулга харуулсан. Хээл хахууль авах сонирхолтой албан хаагчид болон хахуульд өгөх шаардлагатай хөрөнгө мөнгөтэй, өөрийн сонирхлыг гүйцэлдүүлэхийн тулд бусдад хээл хахууль өгөхөд бэлэн байсан олон хүмүүс байсан нь харагдаж байна. Иймээс Жеймс Хайнус хээл хахуулийг үйлчилгээ санал болгогч болон үйлчилгээг худалдан авагчийн хоорондын хэлэлцээр гэж үнэлж, түүний “оролцооны практикийг” онцлон тэмдэглэж байна.

Авлигын зах зээлд нийгмийн бүх бүлэг оролцож байсан. Улс төр, нийгэм, соёлын элитүүд “боловсролгүй хүмүүсийн” арми түүнийг өөрийн зорилго, сонирхол хэрэгцээг хангахын тулд хэрэглэж байсан. “Авлигын соёлд” хийсэн анализ нь авлигыг олон нийтийн хүртэхүй төдийгүй олон нийтийн түүнд оролцсон оролцоог харуулж байна. Зөвлөлтийн иргэд “авлигад баригдсан захиргааны золиос” бус харин өөрийн эрх ашгийн төлөө энэхүү тогтолцоонд сайн дураараа оролцож байсан. Иймээс Хайнус авлигыг зөвлөлтийн иргэний “дадал” гэж тодорхойлсон байдаг. Тэрбээр төрийн албан хаагчдыг ажиллах тэдэнтэй наймаалцах, “солилцоо наймаа хийх” тэр байтугай тэднийг “худалдаж авахад” суралцсан байна.

Авлига нь зөвхөн хувийн ашиг сонирхол төдийгүй, тухайлбал үйлдвэрийн дарга нар сүүдрийн аж ахуйн хүрээнд төлөвлөгөөний биелэлт зэрэг олон нийтийн сонирхлыг татах үүднээс хэрэглэж байна. Мэдээж энэ бүгд нь төрийн албан хаагч бүр авлигад өртсөн гэсэн үг биш юм. Авлига нь

шийтгэлтэй байх учраас буруу хүнд хандах нь эрсдэлтэй байсан. Өмнө нь авлига хахуульд өртөхөөс сэргийлэх талаар сургадаг байсан. Авлигад өртөх хуульчдыг олох зэрэг асуудал нь илүү төвөгтэй байсан учир зуучлагч шаардлагатай байсан. Сүүдрийн аж ахуйн адил зах зээлд харилцаа холбооны сүлжээг хариуцдаг зуучлагчид байсан. Шийтгэлийн практик нь авлигын тогтолцоог тогтворжуулах, зөвтгөсөн үүргийг олгож байсан. Мөн чанартаа авлигын маш бага хэсэг илэрч байсан. Учир нь хахууль өгсөн хүн, хахууль авсан хүний адил хуулийн хариуцлага хүлээх үүднээс нууцыг хадгалах сонирхолтой байдаг. Иймээс шүүхийн өмнө хэлэлцэгч хоёрын нэг нь ихэвчлэн хахууль өгсөн хүн хулхидуулсан гэж үзсэн, эсвэл авлигыг өөр шалтгааны улмаас бүтэлгүйтсэн тохиолдлуудад очдог байжээ. Бүх судалгаанууд Сталины үед хүртэл зөөлөн шийдвэрүүд зонхилж байсныг харуулж байна.

Хэдийгээр шүүгчийг сонгох явцад сонгох хуудсан дээр зарим нэр дэвшигчдийн талаар хахуульд өртөмтгий гэсэн бичиглэл байсан болович түүнийг дахин судалж үзээгүй байв. Үүний адил дэглэм нь их, дээд сургуулийн ажилтнуудын авлигын асуудалд хайнга хандаж байсан. Энэ байдлаар ийм зан үйлийг олон нийтийн дунд шүүмжилж, зарим тохиолдолд шийтгэн ял ногдуулж байсан хэрнээ түүнд улс бага анхаарч, ард түмэн чимээгүй хүлээн зөвшөөрч байсныг харуулж байна. Асуудлыг ойлгоход авлигын үед хоёр биш харин гурван хэсэг оролцдог гэдгийг ойлгох хэрэгтэй. Үйлчлүүлэгч агент-төлөөлөгч өөрийн хэрэгцээг хангахад агентын зөвшөөрөл олгодог. Төлөөлөгчийн зан үйл даргын сонирхлыг хөндөх тохиолдолд авлигын үйлийн тухай ярилцана. Төрийн албан хаагч (түшээ) зан үйлийн дүрэм горимыг зөрчих боловч шийдвэр гаргах өөрийн үүргээ биелүүлж, улсын сонирхлын төлөөлөгчийн хувьд өөрт албан ёсны үүргээс нөхцөл байдлаар л хазайсан. Авлигын тогтолцоо өөрөө үүнийг биелүүлэх баталгаа болж байгаа учраас хувийн ба олон нийтийн сонирхлын хооронд өвөрмөц байдлаар холилдсон.

Авлигыг хүлээн зөвшөөрөх нь хэдийгээр хувь хүн баяжихад хүргэх авч үүний хамтаар олон нийтийн сонирхолд илрэх захиргааны ажиллах чадварт баталгаатай болно. Төрийн тушаалтны хувьд олонх нь улсаас авах бага хэмжээний цалинг авлига авах ёс зүйн зөвтгөл болгон үзэж байна. Авлига нь орон сууцанд орох, ажил хайх, шүүхийн шийдвэрт нөлөөлөх гэх мэт Зөвлөлт орны өдөр тутмын амьдрал болсон.

Шүүх, өмгөөлөгч зэрэг мэргэжлийн бүлгүүд хоёрдмол байр суурьтай байна. Учир нь эл бүлгийн төлөөлөгчид авлига авахын зэрэгцээ даргын тушаал даалгаврын дагуу авлигатай тэмцэх ёстой. Шүүгчид өөрсдөө үүрэгт ажлаа гүйцэтгэх явцдаа авлига авах нь хэвийн зүйл байсан. Төрөөс эмнэлгийн үйлчилгээ, бага боловсролыг үнэгүй олгодог ч эмч нар эмчилгээндээ, их дээд сургуулийн багш нар суралцагчдыг элсүүлэхдээ мөнгө “бэлэг, өргөл барьц” авдгийг бүгд мэддэг. Ингэж өргөл барьц барьснаар хүн өөрийгөө илүү сайн эмчлүүлэх бөгөөд эмч нар амжилттай сайн эмчилгээ хийснийхээ урамшууллыг авдаг.

1. Blat (шунахай зорилготойгоор бэлэг өргөл барих, өөрт хэрэг болно гэсэн үүднээс бэлэг өргөл барих “арын хаалга”): Blat нь Оросын соёлын өвөрмөц онцлогийг ихээхэн хэмжээгээр харуулж байдгийн улмаас энэ нэр томъёог бусад хэлээр орчуулах боломжгүй юм. Энэ нь “өөрт хэрэг болно гэсэн шунахай зорилготойгоор бэлэг өргөн барих”, өөрөөр хэлбэл ирээдүйд хэзээ нэгэн цагт өөрт хэрэг болох хүнтэй сайн харилцаа холбоо тогтоох, түүнийгээ хадгалах явдал юм. Ингэхдээ ихэвчлэн нийгмийн шаталсан ижил түвшинд байх хүмүүсийн тухай яригдана. Хээл хахуультай харьцуулахад Blat харилцаа холбоо тогтооход тодорхой зорилгод баригдахгүй. Blat

үерхэл нөхөрлөл, удаан хугацааны ажил хэргийн холбоо харилцаа, нийтлэг сонирхол зэргээс үүдэн итгэлцэлд суурилсан байдаг. Цаашилбал хээл хахуулиас ялгагдах нэг гол онцлог бол хүргэсэн тусынхаа төлөө эргээд шууд хариу нэхэхгүй, өөрөөр хэлбэл энэ нь ижил үнэ цэнэ бүхий солилцооны харилцаа биш юм. Ирээдүйд хариу тус барих эсэх, барих тохиолдолд ямар хэлбэрээр барих нь нээлттэй байна.

Сталины эдийн засаг болон нийгмийн тогтолцоо үндэслэгдсэнээр Blat-ын ач холбогдол маш их нэмэгдсэн. Учир нь нийтэд хүртээмж багатай байсны улмаас олон төрлийн бараа, үйлчилгээг зөвхөн солилцоо, танил тал, харилцаа холбоогоор дамжуулан авах боломжтой байсан. 1930-аад оны эхэн үеэс мэдээлэл, харилцаа, бараа үйлчилгээнд хүрэх замыг хуваалцдаг “найз нөхөдтэй” байх нь маш чухал болсон. Энэ утгаар “Atomisiery” загвар нь (Ханнах Арендт) Зөвлөлтийн нийгмийг зөвхөн түүний улс төрийн зохион байгуулах чадварыг нарийн тодорхойлсон. Гэтэл Зөвлөлтийн хүн төрөл бүрийн албан бус Blat сүлжээнд хамрагдах замаар өөрийн амьдрал, өөрийн мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулж байжээ. Blat нь дайсагнасан орчинд нийгмийн дулаан бүлээн уур амьсгалыг бүрдүүлж байсан. Blat гэдэг найздаа, хамаатан садан төрлийн хүндээ, эсвэл сайн хүнд тусална гэсэн үг юм. Иймээс түүнд оролцсон хүмүүс Blat-ыг зөвшөөрөгдөөгүй (хийж болохгүй, хориотой) үйл ажиллагаа гэж үздэггүй. Blat нь Зөвлөлт тогтолцоонд энгийн ард иргэд, бага элитийн гишүүд зэргээр нийгмийн шатлал, бүх түвшинд дэлгэрсэн байсан бөгөөд амьдарч, аж төрөхөд мөн чухал байна. Ингэхдээ Blat нь нийгмийн шат ахих хэрээр зөвхөн хувийн амьдралын хүрээ төдийгүй мэргэжил олон нийтийн сонирхолд хэрэглэж болно. Зөвлөлтийн үед байгууллага, нам эсвэл улс гүрний зорилготой уялдаатай өгөх-авах Blat-Prokmna дэлгэрэх таатай орчин бүрдүүлж байна. Blat –ын практик vormodun (орчин үеийн өмнөх) нийгэмд өргөн дэлгэрсэн. Орчин үеийн (modern) тогтолцоонд шилжсэнээр Blat гэж хээл хахууль гэж үнэлэх болсон. Орос оронд үлэмж өөрчлөлт гараагүй бөгөөд албан бус харилцаа хамаарлын тогтолцоог хүн ардын өргөн хүрээ хүлээн зөвшөөрсөн хэвээр байв. Энэ нь Орос орны улс төрийн тогтолцооны өвөрмөц шинжтэй холбоотой. Оросын хувьд хууль цаазат төр болон зах зээлийн харилцаа харьцангүй сул байна. Шейло Ритцпатрик Blat-ын зарчмууд нь коммунист ёс зүйн зөрчилтэй нийцэж байна хэмээн үзсэн. “Хүн хүндээ найз, анд, ах дүү” аль ч цагт Blat гэдэг нэр томьёо сөрөг утгатай байна. Blat гэдэг хууль бус арга замаар ямар нэгэн зүйлд хүрэхийг хэлнэ гэдэг хээл хахуулиас ялгаатай ч хуулийн дагуу үнэлэх гэмт хэрэг биш. Иймээс хэн ч өөрийн найз нөхөртэй харилцаа холбоог Blat гэж нэрлэхгүй. Ажиглагчийн хувьд бусад хүмүүс blat-аар дамжин шударга бусаар ашиг олно. Харин яг ижил үйл ажиллагаа өөр дээр нь авбал цэвэр найз нөхдийн тусламж үйлчилгээ гэж үнэлдэг.

Blat нийгмийг “бид”, ба “тэд нар” гэж хуваан, Blat –оршин тогтнохуй “та нар” гэсэн хүрээнд хүлээн авч байсан. Хээл хахуультай харьцуулахад Blat нь тодорхой хугацаатай байна. Ийм арга замаар “худалдан авч болохгүй” зүйлийг ч зохион байгуулах боломжтой болсон. Blat-ын хажуугаар Patronage харилцаа (ивээн тэтгэх) авлигын чухал суурь болсон. Удирдах ажилтнуудыг хүрээлж хамаарал болон захирах захирагдах харилцаанд тулгуурлаж бүлэглэлүүд үүссэн. Үүнд номенклатурын тогтолцоо ээрэг нөлөө үзүүлсэн. Төвийн болон орон нутгийн түвшинд намын удирдлагуудад тодорхой ажлын байр хуваарилж байсан бөгөөд тэд өөрсдийн хүнээ сонгож ажиллуулж байсан. Тодорхой бүлэгт харьяалагдсанаар ажлын байраар хангагдах боломжтой болсон. Гэхдээ ивээн тэтгэсэн хүмүүстээ үнэнч гэдгээ байнга нотлох шаардлагатай байсан. Түүнчлэн бүлэглэлийн гишүүн байснаар ажлаас халагдах тохиолдолд өөр байранд шилжих боломжтой байсан. Хэдийгээр Сталины үед Patronage-ийн эсрэг албан ёсоор тэмцэж байсан ч

Сталины дарангуйлал ийм бүлэглэлээр дамжуулж өөрийгөө хамгаалах тодорхой хугацааны турш харьцангуй баталгаатай байх гэсэн оролдлогыг улам хүчтэй болгосон.

2. Moral эдийн засгийн хүрээнд хулгайг авч үзэх нь: Орчин үеийн өмнөх тогтолцоонд Moral эдийн засаг нь Европын бүх хэсгүүдэд тархсан байсан. Орос оронд энэхүү төсөөлөл XX зуун хүртэл үйлчилж Зөвлөлтийн тогтолцоонд дахин шинээр хүчтэй болсон. Үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмчийг устгаснаар өмч шамшигдуулах, хулгай хийх явдал газар авсан бөгөөд учир нь ёс зүйн хувьд улсын өмчийг хамтран эзэмших санаархал илэрсэн. Улсын өмчид ингэж дур зоргоороо хандах хандлагыг хийсэн ажлын хөлс бага, харин хамтралчдын хувьд Сталины үед огт хөлс төлөхгүй байгаа мэдрэмж улам хүчтэй болгосон. Энэ нь хөдөлмөрчид болон нам ба улсын даалгавараар өмчтэй харилцаж байсан хүмүүсийн хувьд ч ижил байсан. Амьдрал практик дээр тэд бараа таваар, нөөцийн нэг хэсгийг өөртөө эсвэл найз нөхдөдөө хуваарилж авах боломжийг хүсч байсан. Ингэснээр хувийн болон олон нийтийн салбарын өмнө нь тод томруун байсан хязгаар зааг бүдгэрсэн. Ажлын байрны хяналт шалгалт сул байсны улмаас энэ нь тийм ч хэцүү зүйл биш байсан. Ялангуяа материаллаг үйлдвэрлэл болон худалдааны хамгийн бага цалин хөлстэй салбаруудад хулгай, шамшигдуулалтыг мэдрэх боломжтой... [29]

Сэтиш Чанд. Улс төрчдөд зориулсан үнэгүй аялал болон төлбөр нь хахууль мөн үү?

Marshall Islands Journal сэтгүүл 2006 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн дугаартаа “Улс төрчдөд зориулсан үнэгүй аялал болон төлбөр нь хахууль мөн үү” гэж асуужээ. 2006 оны эхээр Маршаллын Арлуудын Бүгд Найрамдах улсын сенатчид гэр бүлийн хамтраа БНХАУ-д хийсэн албан айлчлалын дараахан энэ асуулт гарч иржээ. Мэдээжээр албан айлчлал бол тийм ч хачирхалтай зүйл биш Номхон далайн арлын улс төрчид тусламж, халим, загас агнуурын талаар ярилцахаар урилгаар олон газар айлчлах нь олонтаа. Гэхдээ орон нутгийн хэвлэлийн анхаарлыг татсан гол зүйл нь уг аяллын зардлыг БНХАУ бүрэн даасан гэж нэр нь тодорхойгүй эх сурвалжаас мэдээлсэн явдал юм. Цаашлаад аялагчид 7000-12000 ам.долларыг мөн урьсан газраасаа хүлээж авсан ажээ. Маршаллын Арлуудын Бүгд Найрамдах улс нь Бүгд Найрамдах Хятад Улс буюу Тайваныг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг цөөхөн орнуудын нэг бөгөөд үүнийг БНХАУ мэдээжээр байнга эсэргүүцэж ирсэн. Нэр дурдагдсан сенатчийн нэг нь томилолтын зардал гэж 1000 ам.доллар авсан бөгөөд сониныг шүүхэд өгнө хэмээн сүрдүүлсэн байна. Гэхдээ аливаа “бэлэг” ямар үед хахууль болдог вэ? Энэхүү Маршаллын Арлуудын улсад болсон явдал нь авлига хэмээх тодорхойгүй ойлголтын талаарх зарим нэг асуудлыг тодруулах боломж олгож байгаа юм. Авлига гэж юу вэ? Авлигын үр дагавар юу вэ? Авлигатай хэрхэн тэмцэх вэ?

Авлига гэж юу вэ? Авлига гэдэгт ихэвчлэн “хувийн ашиг хонжоо олохын тулд төрийн албыг ашиглах” /Бардан 2003:1/ гэж ойлгодог. Гэвч энэ бүрэн бус. АНУ-д болсон Энрон корпорацийн хэрэг, Австралийн Улаан буудайн зөвлөлд хийж буй шалгалтууд нь хувийн хонжоо олохын тулд хувийн салбарт албан тушаалаа урвуулан ашиглаж буйн илрэл. Монополиуд хувийн ашгаа

---

[29] Стефан Мерль. ЗХУ ба Европын тї ї хэнд холбогдох зарим асуудлууд.Редактор Д. Наранцэцэг. УБ., 2009. 71-79-р тал.

нэмэгдүүлэхийн тулд зах зээлд эзлэх хүчин чадлаа ашигладаг боловч энэ нь хэзээ ч авлигад тооцогдохгүй. Авлига нь хувийн ашиг хонжоог олохын тулд төрийн албан хаагч хамсаатан байх ёстой. Хэрвээ монополи нь өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээсэн албан тушаалтнуудтай хуйвалдан зах зээл дээр ноёрхож байвал сая авлигад тооцогдоно. Авлигад нэг талаас авлига өгөгч / тодорхой үйлчилгээг хүсэгч/ нөгөө талаас авлига авагч /үйлчилгээ үзүүлэгч/ гэсэн хоёр талтай. Авлигыг ихэнх хүмүүс харвал таньж, ялгаж чадна гэдэг боловч авлигыг тоогоор хэмжих нь илүү бэрхшээлтэй. Өгүүллийн эхэнд дурдагдсан үнэгүй аялал болон томилолтын мөнгө авлига болж чадах уу?

Яагаад авлига гэж? Авлига байхын үндэс нь ийм үйлчилгээг хүссэн эрэлт, болон түүнийг хангадаг нийлүүлэлт оршин байдагт юм. Маршаллын Арлуудын тохиолдол ч мөн адил. Тиймээс авлигыг эрэлт, нийлүүлэлтийн дүн шинжилгээгээр авч үзэж болно. Авлигын нийлүүлэлтэд орлого бага байх, орлуулах ажлын байрны боломж байх, мөрдөн илрүүлэх, байцаан шийтгэх механизм ядмаг, эсвэл огт байхгүй байх, төвлөрсөн эрх мэдэл зэрэг орно. Харин эрэлтэд авлигын үр дүнд асар их хэмжээний орлого олох боломжтой байх тухайлан Засгийн газрын том хэмжээний тендер, гэрээ нь авлига бий болгох эрэлтийг өсгөх юм. Тиймээс тодорхой үйлчилгээнд өгөх хахуулийн үнэ, авлигын хэмжээ зэрэг нь дээрх хүчин зүйлсээс хамааралтай. Аливаа нэгэн авлига нь тодорхой үнэд /хахууль/ хийгдэж байдаг. Авлигын хэмжээ цаг хугацаа, орон зайн хувьд ялгаатай байх нь авлигын эрэлт нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлттэй нягт уялдаатай. Тухайлбал, эрдэс баялгаас олох гэнэтийн ашиг нь авлигын эрэлтийг өсгөж эрэлтийн муруйг баруун тийш нь шилжүүлнэ. Мэдээжээр авлигын нийлүүлэлт хязгаалагдмал байгаа үед хахуулийн үнэ өндөр байна. Ийнхүү хязгаарлагдмал байхад ёс зүйн өндөр хэм хэмжээтэй байх, нийгмийн зүгээс тавих хяналт өндөр, мөрдөх, байцаан шийтгэх механизм хүчтэй байх, төвлөрсөн эрх мэдэл багатай байх зэрэг нөлөөлдөг. Ийнхүү цаг хугацаа, орон зайн хувьд авлигын хэмжээ, хахуулийн түвшинг мэдэж байх нь авлигад удаан хугацаанд нөлөөлөх хүчин зүйлс нь эрэлтийн, эсвэл нийлүүлэлтийн талынх болохыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Авлигын шалтгааныг мэдэх нь түүнтэй тэмцэх зөв стратегийг тодорхойлоход гол үүрэгтэй.

Авлигын үр дагавар юу вэ? Авлига ядуурлыг нэмэгдүүлдэг хэмээн дүгнэсэн олон тооны судалгаанууд байдаг. Энэ нь хоёр арга замаар нөлөөлдөг. Нэгд, авлига бол үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ утгаараа орлогын өсөлтийг бууруулах хүчин зүйл болдог. Мэдээж, ядуус орлогын зэргээрээ хамгийн доод шатанд байх тул эдийн засгийн уналтын сөрөг үр дагаврыг хамгийн түрүүнд мэдэрдэг. Түүнчлэн, олон эмпирик судалгаагаар авлига нь эдийн засгийн өсөлтийн хурдыг сааруулдаг нь тогтоогдсон байна. Түүнчлэн, ерөнхий эдийн засгаас гадна микро эдийн засгийн төвшинд ч төсөөтэй нөлөөтэй гэдэг нь тогтоогдож байна. Фисман болон Свенссон /2000/ нар Уганда дахь компаний тоо баримтыг ашиглан хийсэн судалгаагаар хахуулийн хэмжээ 1 хувиар нэмэгдэхэд компаний бүтээгдхүүн гаргалтын хэмжээ 3 хувиар буурдаг гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, ижил хэмжээний татварын өсөлтөөс 3 дахин их ачаалал учруулдаг байна.

Хоёрт, авлига нь ядуурлыг нэмэгдүүлэх хор уршигтайгаар орлогын дахин хуваарилалт хийдэг байна. Мэдээжээр, ядуу давхарга хээл хахууль төлөх хөрөнгө, түүнд нэвтрэх мэдээлэл ч байхгүй. Авлига нь тодорхой хөрөнгө мөнгийг нэгээс нөгөөд шилжүүлж байгаа үйлдэл бөгөөд ингэхдээ ядуусыг золиосоо болгож байдаг. Гаалийн татвар ногдуулах ёстой бараа хилээр нэвтрэхэд хахууль авсан гаалийн байцаагч тооцохгүй өнгөрөөж байгаа нь хуулийн дагуу улсад орох ёстой

байсан орлого үгүй болж байдаг. Мөн сувилагч үйлчилгээний төлөө хахууль авч байгаа нь нэг өвчтөнд үзүүлэх ёстой байсан эмчилгээг хойшлуулж, , ингэснээр ядуу өвчтөн хохирч байдаг. Нөгөө талаас, энэ нь дээрх олон чухал үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй албан хаагчид чухал шаардлагатай үйлчилгээг хээл хахууль авахын тулд цааргалах, хүнд суртал гаргах зэргээр ашиглах илүү ноцтой сөрөг үр дагавартай.

Хэтэрхий их хүнд сурталтай нөхцөлд бэлэн мөнгөний тусламжтайгаар ажил бүтээх боломжийг бий болгодог. Өөрөөр хэлбэл, хүнд суртлын дарамт ихтэй үед авлига, хээл хахууль нь зохих журмын дагуу шийдвэр гаргах ганц боломжит арга нь ч байж болох. Тийнхүү авлига нь бизнесийн зардал болох үед авлигын нийгэм дэх өртөг нь хоёр сувгаар нөлөөлдөг. Нэгд, нэгэнт хууль бус тул уг гүйлгээг олж мэдэх, мэдээлэл нууц, хомс байдаг. Хоёрт, Авлига өгөгч тал уг үйл ажиллагаандаа монопол эрхтэй тул өрсөлдөөн байдаггүй.

Цаашлаад, авлига даамжран, өндөр төвшинд, байнга хийгдвэл гарахад хэцүү урхинд оруулдаг. Бүгд авлигад ямар нэгэн байдлаар холбоотой байхад авлигатай тэмцэнэ гэдэг хүндрэлтэй. Хэрэв бодит байдал дээр тийм биш ч гэсэн бүгд авлигач болсон гэж үзэх нь өөрөө бусдыг авлигачдын эгнээнд нэгдэх “шаардлагыг” нэмэгдүүлдэг. Хэн ч татвар төлөхгүй байгаа үед татвар төлөх нь утгагүй мэт санагдана. Үүний үр дүнд, төрөөс үзүүлж буй үйлчилгээ муудаж, авлигатай тэмцэх хүчин чармайлтыг бууруулж, авлига ужгирдаг. Тиймээс авлигатай тэмцэх үйл ажиллагааг аль болох эртнээс ихээхэн хүчин чармайлттай эхлүүлэх шаардлагатай.

Авлигатай хэрхэн тэмцэх вэ? Эдийн засагчид үзэхдээ авлига оршин байгаа нь түүнийг өөгшүүлдэг зүйлстэй холбоотой бөгөөд тэдгээр сэдэл, хүчин зүйлсийг багасгах хэрэгтэй гэж үздэг. Эрэлт нийлүүлэлтийн шалтгааныг тодорхойлж, авлигыг бууруулах стратегидаа тусгасан байна. Тухайлбал, жижиг авлига нь ажилгүйдэл ихтэй, цалин багатай үед газар авах бөгөөд эдийн засаг өсөхийн хэрээр буурна гэж үзэж болно. Жижиг авлига аяндаа буурна гэж орхигдуулахын оронд ажлын байр бий болгоход учирч буй саад бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд анхаарах нь нийлүүлтийн талын авлигыг бууруулахад чухал үүрэгтэй. Дээрх арга хэмжээнээс гадна дүрэм журмыг цөөлөх, энгийн болгох, шийдвэр гаргагчид төвлөрсөн эрх мэдлийг бууруулах, зөрчигчдөд тавих хяналт, арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх, ажилчдын цалин хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээтэй хослуулах нь нийлүүлийн хүчин зүйлээс хамааралтай авлигыг бууруулах боломжтой. Эрэлтийн талд, хонжоо бий болгох бүтцийг багасгах нь зүйтэй мэт боловч улс үндэстэн, хувь хүмүүс гэнэтийн ашгийн цаг хугацаа, хэмжээг нарийвчлан тодорхойлох боломжгүй байдаг. Тиймээс аливаа зохицуулалт, дүрэм журмын үйл ажиллагаа бүгдэд нээлттэй, ил тод арга замаар зохион байгуулах нь хонжоо хайх боломжийг бууруулахад чухал ач холбогдолтой. Хонконг, Сингапурт авлигыг бууруулах чармайлт нэлээд амжилттай болсон.

Дээрх мэдээлэлд үндэслэн Хятадын талаас Маршаллын Арлуудын Бүгд Найрамдах Улсын улс төрчдийн аяллын зардлыг даах нь хээл хахууль мөн үү? Хэрэв тийм бол түүнээс хэрхэн сэргийлэх вэ?[30]

---

[30] Магистрантурын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн агуулга, арга зүйн асуудлууд-II. Редактор: Д.Наранцэцэг. УБ., 2007. 72-76-р тал.

Питер Лармур. Авлигын өвчнийг оношлох нь: Авлигыг анагаах талаар салбарууд ямар зөвлөгөө өгч байна вэ?

Авлигыг ихэвчлэн нийгэмд туссан өвчин эмгэг гэж ярьдаг. Ийнхүү зүйрлэх нь түүнийг эмчлэх анагаах боломжтой тухай санааг давхар агуулдаг. Түүнчлэн түүнийг оношлох, буруу онош тавих тухай ч санаа байж болно. Ямар өвчин бэ, ямар эмчилгээ шаардлагатай вэ, мэс засал хийх үү, аспирин уулгах уу, эсвэл хүлээвэл аяндаа алга болох түр зуурын шинжтэй юу? Ямар ч байсан оношоо зөв тогтоох хэрэгтэй юм байна.

Олон нийтийн санаа бодол, сонины тэргүүн нүүр, сүм, хийд, мэргэжилтнүүдийн номлол, сургаалд авлигын талаар олон янзын онош байдаг. Зарим нь энэ бол үхлийн өвчин гэдэг. Өөрөөр хэлбэл, эмчилгээгүй гэдэг. Эсвэл маш удаан хугацааны нийгмийн өөрчлөлтийг хүлээх хэрэгтэй гэдэг. Зарим нь үл бүтэх шинжтэй (утопи) эмчилгээг санал болгодог: хувьсгал хийх, эсвэл зүрхийг солих гэх мэт. Ихэнх оношийг дагалдсан практик эмчилгээний аргууд байдаг. Онош нь тухайн эмчилгээний аргын үндэс нь болдог. Энэ эмчилгээ нь өөр зорилгод ч үйлчилж болно. Авлигын эсрэг кампанит ажил нь нийгмийн хяналтыг сайжруулах хэрэгсэл байж болохоос гадна улс төрийн өрсөлдөгчийнхөө нэр хүндийг унагаах гэсэн зорилгод ч үйлчилж болно. Заримдаа эмчилгээ нь өвчнөө улам дордуулж ч болох юм.

Энэ өгүүлэлд хэд хэдэн онош-эмчилгээний хосololыг тодорхойлох гэж оролдсон бөгөөд энэ нь бас онол практикийн харилцан холбоо, нэг талын урсгалтай, заримдаа эмчилгээ нь оношоосоо өмнө байх тохиолдол бий, өмнө нь эмч нар буруу эмчилгээ хийснээс өөрөөр хэлбэл, авлигын эсрэг кампани нь урьдчилан төлөвлөгдөөгүй сөрөг үр дагавартай ч байж болох.

1990-ээд оноос олон улсад авлигын асуудалд онцгой анхаарч эхэлсэн бол Авлигын эсрэг бие даасан комисс байгуулах нь 1970-аад онд гол загвар болсон юм. Харин орчин үеийн төрийн албаны тогтолцоо нь XIX зууны үеийн албан тушаалд томилогдох болох ахихад авлигыг бууруулах шинэчлэлийн үр дүн байсан. Хяналт тэнцвэржилтийн тогтолцоо нь XYIII зууны үед бий болсон. Энэ мэтчилэн авлигыг хязгаарлах тухай үзэл санаа нь улс төрийн шинжлэх ухаан болон Үндсэн хуулийн ардчиллын нэг чухал хэсэг байсаар ирсэн билээ.

Харин авлигын эсрэг тэмцлийн үр нөлөө ахицтай биш гэж үздэг судлаачдын хүрээ багагүй газар авсан байна. Тухайлбал, Фрэнк Анэчиарико үзэхдээ Нью-Йоркод гарсан авлигын томоохон шуугиан бүрийн дараа бий болсон хяналт шалгалтын бүтэц нь төрийн албаны үр ашгийг бууруулж байна гэжээ. Иван Крастев тэргүүтэй Зүүн Европын хэсэг судлаачид донор байгууллагын санхүүжилттэй авлигын эсрэг үйл ажиллагаа нь үр дүнд хүргэхгүй, харин ч олон түмний дунд төр, засагтаа итгэх итгэлийг сулруулж, улс төрийн популистуудыг дэвэргэж байна гэжээ.

Классик оношууд

Судлаач Ричар Малгэн эртний Грекийн философчид болох Платон, Аристотель нар ертөнцийг үзэх идеал болон бодит гэсэн хоёр (дуалист) загварыг харьцуулдаг байсан гэжээ. Идеал ертөнцийн үнэн, сайныг бодит ертөнцийн урвалт, ялзрах үйл явцтай эсрэгцүүлж, идеал ертөнц нь бодит ертөнцийг үнэлэх хэмжүүр болдог байсан ажээ. Тиймээс бүхий л бодитой орших

нийгэм авлигач байсан бөгөөд удирдагчид нийтийн сонирхолд өөрийгөө бүрэн зориулах ёстой гэдэг байсан ажээ.

Эртний Грекчүүдийн хувьд гол эмчилгээ нь хууль дээдлэх ёс байсан. Аливаа хууль аль нэг бүлэг хэсэгт илүү давуу тал олгодог байсан ч гэсэн хууль байгаа нь илүү дээр. Учир нь хууль байгаа учраас тохиолдлын бус, тодорхой механизмаар зохицуулагдсан шийдвэр гарна.

Түүнээс гадна улс төрийн тогтворт байдлын хамгийн чухал үндэс нь хуулиа сахидаг, аж ахуй эрхэлдэг дундаж анги гэж үзсэн. Учир нь язгууртнууд болон ажилгүйчүүд нийгэмд хууран мэхлэх нь илүүтэй байдаг ажээ.

Өрнөдийн бус Классик онош

Исламын түүхч Ибн Калдун /1332-1406/ үзэхдээ авлигын шалтгаан нь элитийн дундах унхиагүй, сул амьдралд байна гэсэн. Хятадын философч Ванг Ан Ши (1021-86) авлига нь муу тогтолцоо, муу хүмүүсээс болж төрөн гардаг гэжээ. Энэ нь сайн удирдагчид агуу их даруу төлөв зантай байхыг зааснаас гадна элитийн дундах ёс суртахуунгүй явдлыг эсэргүүцсэн онол юм.

Орчин үеийн авлигын эсрэг үйл ажиллагаа нь сайн хүмүүс гэхээсээ илүү сайн системийг бий болгохыг чухалд тооцдог байна. Ялангуяа “Трэнспэрэнси интернэшнл” байгууллага урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болон хязгаарласан тогтолцоо байгуулахыг чухалчилдаг. Хэдий тийм боловч хувийн шинж чанар бас байгууллагын, бүтцийн хүрээнд олгогдож буй боломжид хэрхэн хариу өгөхөд нөлөөлдөг ажээ. Тухайлбал, Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан комиссын үзэж байгаагаар мөрийтэй тоглоомны өртэй үлдсэн албан тушаалтнууд авлигад илүү өртөх боломжтой ажээ. Түүнчлэн, ажилд авах сонгон шалгаруулах явцад ажилтны ёс зүйн байдлыг судлах, тусгай сургалт зохион явуулах замаар хувийн муу зуршлыг багасгахаар оролдож болох юм.

Төрийн захиргааны онош ба эмчилгээ

XX зуунд АНУ-ын хотын захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлэгчид төрийн албан хаагчдыг томилоход улс төрийн оролцоонд санаа зовниж байсан бөгөөд үүнийг засахын тулд төрийн алба ба төрийн захиргааг зааглаж, илүү биеэ даасан, шаталсан бүтэцтэй төрийн албыг бий болгож, ажилтнуудад төрийн захиргааны албанд удаан жил шат ахин ажиллах боломжтой бүтэц чухал гэж үзжээ. Тиймээс авлигын учир шалтгааныг авч үзэх төрийн захиргааны онош нь сул, үр ашиггүй байгууллагууд, төрийн ба хувийн салбарын үйл ажиллагааг хангалттай салгаагүй, улс төрчид төрийн захиргааны үйл хэрэгт хутгалдан орох зэрэг шалтгааныг тоочжээ. Эмчилгээ нь хүний нөөц, хянан шалгах, гэрээ хэлцэл байгуулах үйл ажиллагааг гадны нөлөөнөөс ангид байлгах, хуучирсан болон зөрчилтэй хуулийн зүйл, заалтыг засварлах, шүүх болон авлигын эсрэг байгууллагуудыг бэхжүүлэх шаардлагатай гэж үздэг байна.

Улс төрийн онош ба эмчилгээ

Төрийн албаны шинэчлэл улс төрчдийг төрийн захиргаанаас ангид байлгах замаар авлигыг бууруулна гэж үздэг. Энэ зарчмыг дунд, доод шатны сонгуульт албан тушаалтнуудын хувьд ч

төрийн захиргааны албан хаагчийн адил хэрэглэж болох юм. Харин улс орны түвшинд сонгогддог албан тушаалтны хувьд хэрэглэхэд бэрхшээлтэй. Учир нь хууль дүрмийг тэд өөрсдөө бүтээдэг, өөрсдийн хүсэл сонирхолдоо нийцсэн хууль гаргах боломж нь байдаг. Улс төрийн онош нь хариуцлагын тогтолцоо сул, удирдлагын авторитар арга барил зэрэг нь эрх мэдлийг урвуугаар ашиглахад нөлөөлдөг байна. Түүнийг эмчлэхэд ардчилсан шинэчлэл, хүчирхэг мэдээллийн хэрэгсэл, гүйцэтгэх засаглалд тавих хууль тогтоох засаглалын хяналт, улс төрчдийн ёс зүйн кодекс, сонгуулийн кампанийн санхүүжилтийн тухай хууль, болон улс төрчдөд хариуцлага тооцох эрмэлзэлтэй хүчирхэг иргэний нийгэм зэрэг орно.

Эдийн засгийн онош ба эмчилгээ

Авлигын талаарх хамгийн нөлөөтэй шинэ хандлага эдийн засгийн салбарт бий болсон бөгөөд олон улсын байгууллагууд ялангуяа "Транспэрэнси Интернэшнл" байгууллага тухайлан бизнесийн үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцэхээр анх 1993 онд байгуулагдсан билээ. Зарим нь хэтэрхий их зохицуулалттай тогтолцоонд "дугуйг эргүүлэхийн тулд бага зэргийн тос" буюу авлига ашигтай ч байж болох тухай ярьдаг. Судлаач Роберт Клитгаард өөрийн хандлагыг товчхон томьёолж, Монополь+Эрх мэдэл-Хариуцлагын тогтолцоо=Авлига хэмээн үзүүлжээ.

Энэхүү оношийн нэг шинэ ойлголт нь монополь буюу өрсөлдөөнгүй нөхцөл байдал юм. Энэ нь эрх мэдлийн тухай өөрөөр авч үзэх боломж олгож байгаа юм. Судлаач Клитгаардын үзэж байгаагаар, төрийн эрх мэдлийг монопольчлох нь албан тушаалтнуудад үйлчүүлэгч нараасаа хээл хахууль шаардан авах эрх мэдлийг өгдөг. Тэрхүү монополь эрх байхгүй бол үйлчлүүлэгчид хахууль төлөхгүйгээр өөр газраас үйлчилгээ авах боломжтой байдаг. Цахилгаан холбооны үйлчилгээг хувьчлах, төрийн зохицуулалтаас гаргах нь монополийг зогсоож буй сайн жишээ юм.

Клитгаардын томьёоллын нөгөө нэг тал нь илүү их яригддаг, хүлээн зөвшөөрөгдсөн зүйл байдаг. Эрх мэдэл албан тушаалтнууд тодорхой үйлчилгээ өгөх, зогсоох, түдгэлзүүлэх, татвараас хөнгөлөх зэрэг бодит нөлөөг өгдөг тул үүгээр далимдуулан хээл хахууль нэхэх, шаардах боломжийг бий болгодог байна. Гурав дахь хэсэг болох хариуцлагын тогтолцоо нь засаглалын бүх төрлийн эмгэгийг эмчлэх хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээ юм. Тиймээс эмчилгээ нь томьёог эсрэгээр тавих буюу монополийг зогсоо, албан эрх мэдлийг бууруул, хариуцлагын тогтолцоог сайжруул, тэгвэл авлига буурна гэсэн үг.

Криминологийн онош ба засал

Олон улсын байгууллагуудын төвшинд эдийн засгийн болон төрийн захиргааны хандлагууд илүү түгээмэл байхад дотоодын авлигын эсрэг тэмцэлд цагдаа болон эрүүгийн шүүхийн үйл ажиллагаа чухал байдаг. Хонконгод анх Авлигын эсрэг бие даасан комиссыг /АЭБК/ цагдаагийн тогтолцоонд байгаа авлигатай тэмцэхээр байгуулжээ. Шүүгч тэргүүлдэг бөгөөд мөрдөн байцаах хэлтэст нь хуучин цагдаагийн ажилтнууд ажилладаг байна.

Ихэнх орнуудад авлигыг гэмт хэрэгт оруулан тооцдог байна. АЭБК-ийн судалгааны захирал Анжела Горта гэмт хэргийн талаарх бүтээлүүдийг судлан, 1/ гэмт хэрэг нь нөхцөл байдлаас хамаардаг болохоос хэрэг үйлдэгчийн тодорхой хувийн шинж чанараас хамаардаггүй, 2/ хүмүүс гэмт хэргийг ухамсартай хийдэг, тэд ихэвчлэн тооцоолсон байдаг, 3/ олон янзын гэмт хэрэг байна, өмчийн эсрэг, хувь хүний эсрэг гэх мэт, 4/ хэрэг үйлдэгчид хийсэн хэргээ ямар нэг

байдлаар зөвтгөхийг хичээдэг, 5/ байгууллагын хүчин зүйл гэх мэт нь хэрэг болоход нөлөөлдөг өөрөөр хэлбэл, гэмт үйлдэл гарах боломж байгаа эсэх, бусад хүмүүсийн уруу таталт, нөхдийн шахалт зэрэг гэж тоймлон үзжээ.

Гэмт хэргийн тухай энэхүү ерөнхий тодорхойлолт нь тодорхой төрлийн гэмт хэрэг ялангуяа, авлигын хэрэгт чухал ач холбогдолтой. Эхний бодомжийн дагуу зохих нөхцөл бүрдсэн үед хүн бүр авлигач байх боломжтой бөгөөд авлигын эсрэг кампани нь бүх албан тушаалтнуудыг авлигач байх боломжтой гэж үзэх шаардлагатай болно. Хоёрт, хэрэв авлигач үйлдэл гаргасан аваас яагаад тэгсэн учрыг тунгаах шаардлагатай. Гуравт, авлигын олон янзын хэлбэр бүрт бид өөрөөр хандах ёстой. Бүгдийг нь адилтгаж авч үзвээс тухайн хэргийн тохиолдол, ноцтой байдал, засах боломж зэргийг буруу тооцох магадлалтай. Албан хаагчдын хахуулийн хэргийг сонгуулийн кампанийн санхүүжилтийн асуудлаас ялгаатай авч үзэх хэрэгтэй. Дөрөв дэх зарчим, мөрдөн байцаагчид авлигын хэрэг үйлдэгчид өөрсдийгөө зөвтгөх тайлбарыг нь үгүйсгэх үндэслэлийг боловсруулсан байх шаардлагатай. Тавд, байгууллагын соёлын асуудалд АЭБК онцгойлон анхаардаг ялангуяа, найз нөхөд, хамт олны үлгэр жишээ, хүлээлт, удирдагчдын үлгэр жишээ зэрэг болно. Тухайлбал, шинээр орсон цагдаагийн ажилтанд сургуульд сурсан зүйлсээ мартаж, өөр амьдралд дасан зохицох тухай байнгын номлол сургаал нь удирдлагын авлигач байдлыг хүлээн зөвшөөрч, дагаж ороход нөлөөлдөг байна.

Дүгнэлт. Онош болон эмчилгээний өөр хослол хувилбарууд ч байх боломжтой бөгөөд эрэлхийлэх нь чухал. Жишээлбэл, антропологи, сэтгэл судлал, шашны урсгалууд болон орон нутгийн уламжлалаас ажиглаж судлах боломжтой юм. Харин энэ хандлага маань авлигыг ойлгох, түүнтэй тэмцэх талаар бидэнд юу өгсөн бэ?

Нэгдүгээрт, авлигын талаар ганцхан зөв хандлага гэж байхгүй. Харин ч олон янзын хандлага байдаг бөгөөд ялангуяа криминологийн хандлага авлигын олон янзын хэлбэрүүд тус бүр өөр өөр аргаар хандах хэрэгтэйг санал болгож байгаа юм.

Хоёрт, өмнө нь алдаатай байсан зарим нэг мэргэжлийн болон салбарын номлолыг тодотгож өгсөн. Тиймээс авлигын эсрэг тэмцэгчид тодорхой салбарын санал болгож буй арга хэмжээ, үйл ажиллагааны бодит үр дүнг хэмжих, эмпирик түвшинд шалгах, түүний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай юм. Харамсалтай нь өнөөдөр авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнгийн талаарх системтэй эмпирик судалгаа нотолгоо бага байгаа бөгөөд тийм судалгаа хийх шаардлага улам тулгамдсаар байна. (Орчуулсан Ц.Мөнхцэцэг, Э.Гэрэлт-Од) [31]

## ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:
Монгол Улсын Үндсэн хууль 1992 он.
Авлигын эсрэг хууль 1996 он.
Авлигын эсрэг хууль 2006 он.

[31] Магистрантурын сургалтын хөтөлбөрийн øèí÷ëýëèéí àãóóëãà, àðãà ç¿éí àñóóäëóóä-II Редактор: Д.Наранцэцэг. УБ., 2007. 76-81-р тал.

Монгол Улсын Иргэний хууль 2002 он.
Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он.
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2002 он.
Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он.
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт 1966 он.
Авлигын эсрэг НҮБ-ын конвенц 1999 он

Ном, сурах бичиг:
Авлигатай тэмцэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, харьцуулсан судалгаа.УБ., 2005 он
Авлига: Мөнхийн үзэгдэл биш. УБ., 2002 он
Авлига:түүний тухай ойлголт, тэмцэх арга зам. УБ., 2000 он
Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-мониторингийн судалгаа. УБ., 2004 он
Авлигын эсрэг эх сурвалж. УБ., 2003 он
“Авлигын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь -1999, 2002” сэдэвт социологийн судалгааны харьцуулалтын дүн. УБ., 2002 он
Л.Батжав Хээл хахуулийн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн үндсэн шинж. УБ., 2003 он
П. Одгэрэл. Захиргааны эрх зүй. УБ . 2005 он
Д. Ганзориг. Захиргааны эрх зүйн нэр томёоны тайлбар толь УБ
Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд. УБ., 2003 он
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт мониторингийн судалгаа. Зориг сан. 2004 он
ARRCenter for Human Rights Education. Human Rights Education Pack 1995, Bangkok, Thailand
George J Andreopoulos, Richard Pierre Claude ., (1997)
Human Rights Education for the Twenty First Century University of Pennsylvania Press
Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн VIII-IX ангийн сургалтын төлөвлөгөө, БСШУ-ны сайдын 2010 оны 4 дүгээр сарын 2-ний өдрийн 201 дүгээр тушаал
Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, НҮБХХ., Авлигын эсрэг цагаан толгой., УБ., 2010
Авлигатай тэмцэх газар., Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага., УБ., 2010
Философийн толь. УБ.,1990
Монгол Улсын Авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүн. АТГ-ын Шударга ёс сэтгүүл. №1. 2010
С.Баяраа, Д.Ганбат, Ч.Ган-Өлзий, А.Саруул, Д.Төмөртогоо, Г.Чулуунбаатар. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томьёоны тайлбар толь. УБ.,2006
Монгол Улсын ШУА., Монголын нэвтэрхий толь. УБ., 2000
Магистрантурын Сургалтын Хөтөлбөрийн шинэчлэлийн агуулга, арга зүйн асуудлууд-II. Редактор: Д.Наранцэцэг. УБ.,2007
Стефан Мерль. ЗХУ ба Европын түүхэнд холбогдох зарим асуудлууд. Редактор Д.Наранцэцэг. УБ., 2009
Дилав хутагт Б.Жамсранжав. Ариун сэтгэл-авралын үндэс. (Дуртгал, намтар, өгүүлэл). Хэвлэлд бэлтгэсэн Л.Чойжилсүрэн. УБ.,2000
Юн-хан Чу нар. Зүүн Ази дахь ардчиллын чанар ба дэглэмийн легитим чанар. Азийн Барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2008 Монголын авлигын түвшин тогтоох судалгаа. Азийн сан. УБ.,2006

Цахим эх сурвалж:


http://www.iaac.mn
http://www.ifs.univie.ac.at/~uncjin/corrupt.htm
www.tovan.pms.mn
http://integrity.blog.gogo.mn
http://mn.wikipedia.org/wiki
tusuv.files.wordpress.com
www.transparency.org/policy_research/surveys_indices/cpi/2010/results


* * *

1969

АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ УТАС

Энэхүү гарын авлагыг АНУ-ын Азийн сан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагын дэмжлэгтэйгээр, АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны санхүүжилтээр хэвлэн гаргав